



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 10



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

ЦУВРАЛ 10

Улаанбаатар, 2023

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 10

СУДЛААЧИД:

1. Ө.Эрдэнэ-Очир, Ш.Алтангадас, М.Жавхлан, Б.Цэрэнлхам
2. Г.Цэцгээ, У.Мөнхцэцэг

Дугаар хариуцсан редактор Н.Отгончимэг

© Нээлттэй Нийгэм Форум, 2023.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9990-1-8

Шүүхийн шийдвэрийн судалгаа

ЦУВРАЛ 10



1

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ
ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ БУРУУТАЙ АЛБАН
ТУШААЛТНААС НЭХЭМЖЛЭХ ЭРХИЙГ ТОДОРХОЙЛЖ
БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

9

2

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН
БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

101

ӨМНӨХ ҮГ

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын 10 дахь дугаараар захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг судалсан дараах хоёр тайланг танилцуулж байна.

“Онч шийдэл” төрийн бус байгууллагын Ө.Эрдэнэ-Очир ахлагчтай судалгааны баг төрийн албан хаагчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг төлүүлэх нэхэмжлэлийг шүүх хэрхэн шийдэж байгааг судалж хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр зөвлөмж танилцууллаа. Гэм хорын асуудлаар шүүхийн шийдвэрийн судалгааны арвин туршлагатай, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач Д.Ганхүрэл энэхүү тайланд шүүмж өгч ажилласан юм.

Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан шийдвэрлэж буй шүүхийн практикийг судлаач Г.Цэцгээ, У.Мөнхцэцэг нар судалж судалгааны тайланд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүгч, судлаач Т.Мөнх-Эрдэнэ шүүмж бичиж тайланг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулж ажилласан юм. Судлаач Г.Цэцгээ нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ажиллаж байсан туршлагатай бөгөөд ажил үүргийн хүрээнд энэ төрлийн маргаан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцож байсан зэрэг нь асуудлын голыг эрх зүйн болон практик өнцгөөс дүгнэн шинжлэхэд дөхөм болсон нь дамжиггүй.

Энэхүү дугаарын агуулгыг боловсруулсан нийт судлаач, шүүмжлэгч болон дугаар эрхэлсэн редактор Н.Отгончимэг нарт талархал илэрхийлье.

“Нээлттэй Нийгэм Форум (ННФ)”-ын хэвлэн нийтэлсэн “Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралууд болон бусад судалгаа, шинжилгээний тайлан, мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас унших болон “LegalTalks: Шүүхийн шийдвэр судалгаа” подкастаас сонсох боломжтой. Бидний үйл ажиллагааг сайжруулах талаар санал бодлоо илэрхийлж, дэмжлэг үзүүлэхийг уншигч танаас хүсье.

ННФ-ын Гүйцэтгэх захирал
П.Эрдэнэжаргал

РЕДАКЦЫН ЗУРВАС

“Шүүхийн шийдвэрийн судалгаа” цувралын энэхүү дугаарт “Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэхтэй холбоотой нэхэмжлэгчийн шаардах эрхийг хэрхэн тодорхойлж буй шүүхийн практик”, “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” сэдвээр захиргааны болон иргэний хэргийн шүүхийн шийдвэрүүдийг сонгон судалж шинжилж, дүгнэсэн судалгааг толилуулж байна.

“Онч шийдэл” төрийн бус байгууллагын судлаач Ө.Эрдэнэ-Очир, Ш.Алтангадас, М.Жавхлан Б.Цэрэнлхам нар төрийн албан хаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ буруутай шийдвэр гаргасны улмаас төрд учирсан хохирлыг түүнээс нэхэмжлэхэд анхаарал татсан зарим асуудлыг судалжээ.

Судалгаанд дурдсанаар Иргэний хэргийн шүүх 2019 онд 1.3 тэрбум төгрөг, 2020 онд 2.2 тэрбум төгрөг, захиргааны хэргийн шүүх 2019 онд 160 гаруй сая төгрөг, 2020 онд 300 гаруй сая төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар шийдвэрлэжээ. Үүнээс ажлаас буруу үндэслэлээр халсны улмаас ажилтанд олгох ажилгүй байсан хугацааны цалин, бусад нөхөн олговор гэхэд 2019 онд 21 байгууллагын 46 ажилтанд 0.5 тэрбум, 2020 онд 30 байгууллагын 38 ажилтанд 0.6 тэрбум төгрөг байна.

Энэ нь тухайн хууль бус шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаас хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх шаардлага тэр хэрээр үүсэж буйг харуулж байна. Практикт энэ төрлийн

нэхэмжлэлийг төрийн аудитын байгууллага, Төрийн албаны зөвлөл, прокурор, хохирол хүлээсэн төрийн байгууллага өөрөө буруутай албан тушаалтнаас нэхэмжилж байгааг судалгаанд төрөлжүүлэн авч үзсэн нь энэ сэдвээр сонирхож, мэдээлэл хайж байгаа нэгэнд хялбар дөхөмтэй болжээ. Түүнчлэн энэ төрлийн маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй хууль хэрэглээ, эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийн талаар судлаачид нэлээд нарийвчлан авч үзэж, эрх зүйн шийдэл, үндэслэлийн хувьд сонирхолтой шинжилж дүгнэжээ.

Судлаач Г.Цэцгээ, У.Мөнхцэцэг нарын “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” судалгаа нь иргэдийн өмчлөх эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн маргааны хууль хэрэглээнд чухал ач холбогдолтой мэдээлэл, дүгнэлт агуулж байна.

Тэдний олж судалснаар сүүлийн 3 жилд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан мэдүүлгийн дунджаар 16 орчим мянга нь буюу 3.8 хувьд нь улсын бүртгэлд бүртгэхээс татгалзан шийдвэрийг бичгээр гаргасан байна. Ингэхдээ энэ тоонд бичгээр шийдвэр гаргахгүйгээр буцааж байгаа тэдгээр мэдүүлэг ороогүй буюу энэ тоо улсын бүртгэлийн байгууллагад байдаггүйг тэмдэглэснийг дурдах нь зүйтэй. Энэ тоо баримт нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр бүртгүүлэхтэй холбоотой маргаан төдий хэрээр үүсэх боломжтойг харуулна.

Та бүхэн энэ судалгаанаас орон сууцны дуусаагүй барилгад гэрчилгээ олгож, барьцаалсан байтал захиалагч түүнийг мэдэхгүйгээр үнэ төлснөөр өмчлөгчийн бүртгэлийн маргаан олон гарч буй талаар, хуулийн бусад байгууллагын шийдвэрээр битүүмжлэгдсэн эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгчөөр бүртгүүлэхтэй холбоотой маргааныг шийдвэрлэж буй практик, улмаар орон сууц захиалагч нар улсын бүртгэлд бүртгүүлэх, урьдчилсан тэмдэглэл хийлгэх зохицуулалтын ач холбогдол, хэрэгцээ шаардлагын талаар сонирхолтой дүгнэлттэй танилцаарай.

Дугаар эрхэлсэн редактор
Н.Отгончимэг

1

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ БУРУУТАЙ АЛБАН ТУШААЛТНААС НЭХЭМЖЛЭХ ЭРХИЙГ ТОДОРХОЙЛЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ӨЛЗИЙГИЙН ЭРДЭНЭ-ОЧИР

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн үүсгэн байгуулагч, партнер өмгөөлөгч.

2010 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2012 оноос одоог хүртэл Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д партнер өмгөөлөгч, “Онч шийдэл” НҮТББ-ын гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байна.



ШАГДАРСҮРЭНГИЙН АЛТАНГАДАС

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн үүсгэн байгуулагч, партнер өмгөөлөгч.

2010 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйн бакалавр, 2016-2017 онд Англи улсын Лондон хотын, London South Bank University-д Хууль зүйн магистрын (LL.M) зэрэг хамгаалсан.

2012 оноос одоог хүртэл Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д партнер өмгөөлөгч, “Онч шийдэл” НҮТББ-ын Удирдах зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байна.

Судлаачид:

Ө.Эрдэнэ-Очир

Ш.Алтангадас

М.Жавхлан

Б.Цэрэнлхам



МИЖИДДОРЖИЙН ЖАВХЛАН

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн өмгөөлөгч, судлаач.

2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2018 оноос одоог хүртэл Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д өмгөөлөгч, “Онч шийдэл” НҮТББ-ын судлаачаар ажиллаж байна.



БАТ-ЭРДЭНИЙН ЦЭРЭНЛХАМ

Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-ийн хуульч, судлаач.

2020 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2020 оноос одоог хүртэл Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН-д хуульч, “Онч шийдэл” НҮТББ-ын судлаачаар ажиллаж байна.

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	12
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	13
УДИРТГАЛ.....	14
 НЭГ. НИЙТЛЭГ АСУУДАЛ.....	19
1.1. Нийтийн өмчийн тухай ойлголт.....	19
1.2. Нэхэмжлэгч болон түүний шаардах эрхийн тухай.....	22
1.3. Нийтийн өмчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, боломж.....	24
 ХОЁР. НЭХЭМЖЛЭГЧИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ТОДОРХОЙЛЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	28
2.1. Аудитын байгууллага шүүхэд хандсан тохиолдол.....	30
2.2. Төрийн албаны зөвлөл шүүхэд хандсан тохиолдол.....	41
2.3. Прокурорын байгууллага нэхэмжилсэн тохиолдол.....	52
2.4. Хохирол хүлээсэн байгууллага өөрөө нэхэмжилсэн тохиолдол.....	74
 НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....	89
 АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	97

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БЗДИХАШШ	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
БСЧДЭХАШШ	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЕБ	Ерөнхий боловсрол
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗХАШШ	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
СБДИХАШШ	Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
УДШ	Улсын дээд шүүх
ХУДИХАШШ	Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Төрд учруулсан хохирлыг шаардаж буй эрх бүхий байгууллагын төрөл
- График 2. Иргэний шүүхээр шийдвэрлэсэн байдал
- График 3. Захиргааны шүүхээр шийдвэрлэсэн байдал
- График 4. Захирамжийн үндэслэл

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн хоёрт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж заажээ. Нийтийн өмч, түүний хэлбэрийн нэг болох улсын төсөв, тусгай сангийн мөнгөн хөрөнгийг зориулалтын бусаар буюу албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас иргэнд төлсөн мөнгөн хөрөнгө нь хохирол болох бөгөөд буцаан төлүүлэх нь нийтийн өмчийг хамгаалж буй хууль зүйн үйлдэл юм.

Албан тушаалтны буруутай шийдвэрээс болж, иргэнд учирсан хохирлыг төр нь албан тушаалтныхаа өмнөөс төлж, улмаар төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлдэг харилцаа нь харьцангуй шинэ мэт боловч Төрийн албаны тухай хууль, Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль, Прокурорын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд энэ талаарх харилцааг аль хэдийн тодорхойлсон байна.

2019 онд Иргэний хэргийн шүүх 1.3 тэрбум төгрөг, Захиргааны хэргийн шүүх 160 гаруй сая төгрөг, 2020 онд Иргэний хэргийн шүүх 2.2 тэрбум төгрөг, Захиргааны хэргийн шүүх 300 гаруй сая төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар

шийдвэрлэжээ.¹ Үүнээс зөвхөн ажлаас буруу халсны улмаас ажилтанд олгох ажилгүй байсан хугацааны цалин бусад нөхөн олговрын хувьд шүүхийн шийдвэрийн дагуу төрөөс 2019 онд Төрийн байгууллагын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан 21 байгууллагын 46 ажилтанд 0.5 тэрбум, 2020 онд 30 байгууллагын 38 ажилтанд 0.6 тэрбум төгрөгийн нөхөн олговор тус тус олгожээ.²

Дээрх төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжилсэн тохиолдол практикт хомс байх бөгөөд нэхэмжилсэн тохиолдлуудад шүүхээс нэхэмжлэгчийн шаардах эрхийг өөр өөр байдлаар тодорхойлж, энэ нь шүүхэд маргаан үүсгэхээс өмнөх шатанд буюу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байгаа нь шүүхийн практикт ажиглагдаж байна.

Үүний цаад шалтгаан нөхцөл нь хууль тогтоомжийн зөрүүтэй хэрэглээ, нэхэмжлэл гаргах боломжит субъектийн идэвхгүй байдал, тэдгээрийн буруу ойлголт зэргээс үүдэлтэй эсэхийг тодорхойлохын тулд энэ төрлийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн практикийг судалж, нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай.

Улмаар төрд учирсан хохирлыг буцаан төлүүлж, төрийг хохиролгүй болгох ажлыг үр дүнтэй зохион байгуулахын тулд энэ төрлийн нэхэмжлэл гаргаж байгаа байгууллагын нэхэмжлэл гаргах эрхийн талаар дүгнэж буй шүүхийн практикийг шинжилж дүгнэх нь зүйтэй гэж үзэв.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан хохирлыг арилгуулах нэхэмжлэлтэй хэрэгт нэхэмжлэгчийн шаардах эрхийг

¹ П.Ангарагсайхан, “Ажил олгогчийн буруугаас халагдсан нь тогтоогдсон төрийн албан хаагчдад дөрвөн тэрбум төгрөг олгохыг шүүхээс даалгасан” сэдэвт ярилцлага, https://www.judcouncil.mn/site/news_full/11535, 2021.11.02 (2022.03.28-нд нэвтрэв)

² Мөн тэнд.

хэрхэн тодорхойлж байгааг шүүхийн практикийг судлах замаар тухайн шийдвэртэй холбоотой эрх зүйн асуудлыг тодруулах, шүүхийн практикийг тогтоох, улмаар эрх зүйн хөгжилд хувь нэмэр оруулах зорилго дэвшүүлээ. Энэ хүрээнд дараах зорилтыг тавилаа. Үүнд:

- Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжилсэн хэргийг шийдвэрлэсэн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэр, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжуудын агуулга, хэлбэрийг шинжилж дүгнэх;
- Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх нэхэмжлэгч байгууллагын шаардах эрхийг тодорхойлж буй шүүхийн практикийг шинжилж дүгнэх;
- Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх нэхэмжлэгч байгууллагын шаардах эрхийг тодорхойлсон хуулиудын уялдаа холбоог гаргах;
- Асуудлыг илрүүлж, дүгнэлт зөвлөмж гаргах зэрэг болно.

Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой сэдвээр дараах судалгаа, өгүүлэл нийтлэгдсэн ч энэхүү судалгаанд хөндөгдөж буй асуудал өмнө нь цогц байдлаар судлагдаж байгаагүй. Үүнд:

- “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал³ сэдэвт судалгаа”, Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2009.
- “Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь⁴ харьцуулсан судалгаа”, судлаач Б.Улсболд, 2020.

³ <https://nli.gov.mn/?p=1950>

⁴ <https://legaldata.mn/b/701>

- “Авлига-урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд, судалгааны тайлан, Нийслэлийн Прокурорын газар, 2021.

Судалгаанд хөндөх маргааны тоо мэдээ, шийдвэрлэсэн байдлын талаарх мэдээллийг шүүн таслах ажиллагааны тайланд тусгайлан оруулдаггүй, мөн Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан (www.shuukh.mn)-д шийдвэрийг нээлттэй байршуулаагүй байсан тул судалгааны багийн зүгээс 21 аймаг, 9 дүүргийн шүүхийн тамгын газар болон 21 аймгийн ЗДТГ-т албан бичгээр хандсаны хариуд ирүүлсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжуудаас судалгаанд хамааралтайг ялган авч, зарим тохиолдолд биечлэн танилцах замаар судаллаа. Судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”⁵-д үндэслэн боловсруулан хийж гүйцэтгэв.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэх нэхэмжлэлийг Иргэний хэргийн шүүх хүлээн авахаас татгалзахад хүргэж байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлох, ялангуяа нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрхийн талаарх шүүхийн практикийг судаллаа. Харин судалж буй асуудалтай холбогдох энэ төрлийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхтэй холбоотой асуудал болон захиргааны хэргийн шүүхийн харьяаллын маргаан болох төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай улсын байцаагчийн акттай холбоотой шүүхийн практикийг тус судалгааны ажилд авч үзээгүй болно. Цаашид энд судлагдсан асуудалд үндэслэн төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэхтэй

⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”, УБ., 2015.

холбоотой асуудлыг материаллаг эрх зүйн хүрээнд судлах нь асуудлын мөн чанарыг бүрэн дүүрэн гаргахад харилцан бие биеэ нөхөх ач холбогдолтой гэж үзэж байна.

НЭГ. НИЙТЛЭГ АСУУДАЛ

1.1 НИЙТИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Төрд учирсан хохирлыг буцаан төлүүлэхээр шаардах нь өргөн утгаараа нийтийн өмчийг хамгаалж буй нэг хэлбэр тул бид энд нийтийн өмчийн талаарх ойлголтыг хууль зүйн талаас нь авч үзэхийг зорилоо.

Монгол Улсын Үндсэн хуульд “ашиг сонирхол” хэмээх нэр томъёо нийт долоон удаа⁶ дурдагдсан байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана” гэж зааснаар төрийн албаны харилцаан дахь үндсэн суурийг тогтоож өгчээ.

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд 37.1.2-т “Өргөсөн тангарагтаа үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэрэхгүй байх” гэж зааснаар төрийн албан хаагч нийтийн эрх ашигт захирагдах үндэс суурийг тогтоож өгчээ. Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн ашиг

⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 4, 16 дугаар зүйлийн 10, 11, 17 дугаар зүйлийн 1.2, 23 дугаар зүйлийн 1, 28 дугаар зүйлийн 2, 46 дугаар зүйлийн 2.

сонирхол болон Төрийн албаны тухай хуульд заасан нийтийн ашиг сонирхол нь агуулгын хувьд адил бөгөөд энэ тохиолдолд нийтийн ашиг сонирхолд юу хамаарах вэ? гэдгийг судлах шаардлага зүй ёсоор үүсэж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах ...” гэж тодорхойлсноор нийтийн эрх ашгийн суурийг тогтоож өгчээ. Өөрөөр хэлбэл, нийтийн эрх ашгийн тодорхойлолт байхгүй хэдий ч хуулиар хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийн асуудлуудыг нийтийн эрх ашигт хамааруулсан байна.

Дээрхээс дүгнэн үзвэл, агуулгын хувьд төрийн албан хаагч нийтийн эрх ашиг (хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, **нийтийн өмч**)-т захирагдан түүнийг хамгаалах үүргийг хэрэгжүүлэхээр байна.

Энд дурдсан нийтийн өмчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” хэмээн зааснаар Монгол Улсад өмчийн тухай ойлголт, өмчийн төрөл, хэлбэр, өмчлөх эрхийн агуулга шинээр бүрэлдэн бий болох эрх зүйн үндэс бүрдсэн юм.

Өмчийн тухай үндсэн хуулийн ойлголт нь өргөн утгаар материаллаг болон материаллаг бус хөрөнгийг хамгийн өргөн цар хүрээнд эрхшээлдээ байлгах эрх⁷ хэмээн хуульчид тодорхойлдог. Энэ нь аливаа хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг агуулахаас гадна тухайн хөрөнгийг аливаа этгээдээс хамгаалах, хэн нэгэн өөр этгээд хөрөнгийг нь зөвшөөрөлгүйгээр

⁷ Монгол Улсын иргэний хуулийн тайлбар, УБ., 2015.

ашиглахыг таслан зогсоох эрхтэй байдаг. Тэгвэл хувийн өмчид байх энэ шинж нийтийн өмчид байх эсэх, хэн уг эрхийг хэрэгжүүлэх эсэх, эсвэл эдгээр эрх нийтийн өмчид хамаарагдах эсэх нь төдийлөн тодорхой бус байдаг. Өөрөөр хэлбэл, нийтийн өмчийн өмчлөгч нь хэн болох, аливаа халдлагаас хамгаалах, учирсан хохирлоо хэн хэнээс шаардах, буцаан төлүүлэх тохиолдолд хэн авах зэрэг нь хууль зүйн хүрээнд тогтолцоотой болоогүй тус тусын салбарын хэм хэмжээнд тусгагдсанаас үүдэлтэй ойлгомжгүй байдал байсаар байна.

ИХ-ийн 99 дүгээр зүйлд өмчийн хэлбэрийг тодорхойлж өгсөн ба 99.1-д Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна, 99.2-т нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэрийг тогтоож өгчээ. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар төрийн өмч нь “төрийн нийтийн зориулалттай” болон “төрийн өөрийн өмч”-өөс бүрдэх бөгөөд нийтийн зориулалттай өмчид Үндсэн хууль, бусад хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар бүх ард түмний өмч болгон заасан өмчийг нийтийн зориулалттай өмч гэх ба дараахаас бүрдэнэ. Үүнд:

1. Иргэдэд өмчлүүлснээс бусад газар
2. Газрын хэвлий, түүний баялаг
3. Ус, түүний доторх баялаг
4. Ой түүний дагалдах баялаг
5. Ургамал, ан амьтны нөөц
6. Түүх соёлын үнэт цогцолбор, хөшөө дурсгал
7. Археологийн болон палеонтологийн олдвор
8. Хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө⁸

⁸ “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 4 дүгээр зүйл.

Төрийн өөрийн өмчид дээрхээс бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараах эд хөрөнгө хамаарна. Үүнд:

1. Төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө
2. Төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө
3. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь
4. Улсын төсвийн хөрөнгө болон төрийн бусад тусгай сан
5. Төрийн тусгай хэрэгцээний бэлтгэл нөөц
6. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө⁹

Дээрх бүгд нь нийтийн өмчийг тодорхойлж байгаа хэлбэрүүд бөгөөд эдгээрийг дүгнэн үзвэл буруутай албан хаагчийнхаа өмнөөс тухайн байгууллага эсвэл эрх бүхий этгээд (төр) иргэнд хохирлыг төлсний дараа тухайн байгууллагын төсөв, сангаас зориулалтын бусаар зарцуулсан мөнгийг хохирол гэж бүртгэх билээ.

Иймээс төрийн албан хаагч нийтийн эрх ашигт захирагдана гэдэг нь улсын төсвийн хөрөнгө болон төрийн тусгай сангийн хөрөнгийг хууль бусаар зарцуулахгүй байх үүргийг хүлээж буй хэрэг юм.

1.2 НЭХЭМЖЛЭГЧ БОЛОН ТҮҮНИЙ ШААРДАХ ЭРХИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар

⁹ “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйл.

шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах,... эрхтэй” гэж заажээ.

ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2-т “Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон **бусдын нэрийн өмнөөс** нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ”, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.3-д “нэхэмжлэл гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсвэл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, **хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг**” хэлнэ гэж тус тус заажээ.

Хуульд зааснаар нэхэмжлэл гаргах этгээдийг зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн хүрээнд хязгаарлахгүйгээр хуулиар эрх олгогдсон этгээд бусдын нэрийн өмнөөс шүүхэд мэдүүлэх эрхийг хэрэгжүүлэх боломжийг олгосон байдаг.

ИХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно”, ИХШХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Монгол Улсын хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзэж байгаа аливаа этгээд уг эрхээ хамгаалуулахаар энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл, хүсэлт, гомдол гаргах хэлбэрээр мэдүүлэх эрхтэй” гэж тус тус

зааснаар иргэний эрх зүйн харилцаа төдийгүй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төр иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нэхэмжлэгчээр оролцох боломжийг зохицуулжээ.

Төр болон иргэн (хуулийн этгээд) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зарчмын эхний ялгаа нь иргэн болон хуулийн этгээдийн хувьд шүүхэд нэхэмжлэл гаргах, шаардах эрхээ хэрэгжүүлэх эсэх нь эрх буюу чөлөөт сонголт байдаг. Харин төрийн байгууллагын нэхэмжлэл гаргахтай холбоотой чиг үүрэг холбогдох хуулиар зохицуулагдсан байдаг тул төр тодорхой тохиолдлуудад нэхэмжлэл гаргах эрхтэй бус үүрэгтэй байна. Үүнийг ч ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.3-д “Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос, эсвэл гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсан явдал уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй” гэж хуулиар хязгаарласан байна.

1.3 НИЙТИЙН ӨМЧИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, БОЛОМЖ

Бусдын нэрийн өмнөөс, тодруулбал төрийн нэрийн өмнөөс төрд учирсан хохирлыг шаардах эрх бүхий этгээдийг дараах хууль тогтоомжид ийнхүү нэрлэн заасан байна. Үүнд:

1. ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Хохирол нөхөн төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна, мөн хуулийн 103.3-д дотоод аудитын нэгж байхгүй бол төрийн аудитын байгууллага хариуцна”;
2. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэ-

рийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана”;


3. Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно”;
4. ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-д заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй”;
5. Гаалийн тухай хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4-д “гаалийн байгууллага энэ хуулийн 239.2-т зааснаар барагдуулсан хохирлыг буруутай гаалийн албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана”;
6. Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д “Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар төлүүлнэ”;
7. Төрийн аудитын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д “Төрийн аудитын байгууллага тухайн жилд ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.3-д заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна”;

Хуульд заасан дээрх зохицуулалтаас үзэхэд, аудитын байгууллага, прокурор, Төрийн албаны зөвлөл, гаалийн байгууллага, нийгмийн халамжийн байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллага төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах боломж хуулиар бүрджээ.

Гэвч эдгээр байгууллагаас зөвхөн прокурорын байгууллага төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас шаардах эрхээ идэвхтэй хэрэгжүүлж байгаа нь график 1-ээс харагдаж байна.

График 1. Төрд учруулсан хохирлыг шаардаж буй эрх бүхий байгууллагын төрөл

(2019-2021 оны байдлаар)



Прокурор төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг гаргуулахаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож зөрчлийн болон эрүүгийн хэргийн улмаас учирсан хохиролд 376.9 тэрбум төгрөг, иргэний эрх зүйн бусад маргааны улмаас төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохиролд 348.2

тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлүүлжээ.¹⁰

Энэ нь нэг талаас сайшаалтай хэдий ч нөгөө талаасаа прокурорын байгууллага төр, нийтийн ашиг сонирхлыг ямар тохиолдолд төлөөлөх, төрд учирсан хохирол гэдэгт чухам юуг ойлгох талаар нэгдсэн ойлголт байхгүйгээс нэхэмжлэлийн шаардлага хангагдахгүй байх, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нөхцөлийг бүрдүүлсэн тохиолдол цөөнгүй гарсан байна.


¹⁰ Нийслэлийн Прокурорын газар, Авлига-урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд, судалгааны тайлан, УБ, 2021 он, 70 дахь тал дам эшлэв.

ХОЁР. НЭХЭМЖЛЭГЧИЙН ШААРДАХ ЭРХИЙГ ТОДОРХОЙЛЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт төрд учруулсан хохирлыг нэхэмжлэхтэй холбоотой нэхэмжлэлийг хүлээн авах болон хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай Иргэний хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрийг нэгтгэн судлахыг зорьсон болно.

2019-2021 онд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэсэн Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн тоон үзүүлэлтийг график 2-оос харна уу.

График 2. Иргэний шүүхээр шийдвэрлэсэн байдал



Харин захиргааны хэргийн шүүхээр 2015-2021 онд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой шийдвэрлэгдсэн байдлыг (график 3) авч үзэхэд энэ төрлийн нэхэмжлэлийг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн тохиолдол үгүй байна.


График 3. Захиргааны шүүхээр шийдвэрлэгдсэн байдал



Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан болон хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн захирамжийн тухайд судалгааны багаас 21 аймгийн анхан шатны шүүх, тамгын газар, Улаанбаатар хотын 9 дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж, “Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаас нэхэмжлэхтэй холбоотой” хэргийг шийдвэрлэсэн, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамжуудыг гаргуулахаар албан бичиг хүргүүлснээс нийт 68 захирамж ирсэн бөгөөд үүний 7 нь манай судалгаанд хамааралтай, ач холбогдол бүхий байсан тул эдгээр захирамжийг шинжилж дүгнэлээ.

График 4-т шүүхээс ямар үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан болон хэргийг хэрэгсэхгүй болгосон талаар харууллаа.

График 4. Захирамжийн үндэслэл



2.1. АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ШҮҮХЭД ХАНДСАН ТОХИОЛДОЛ

Жишээ 1.

Дархан-Уул аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүгчгийн 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2097 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүгчгийн захирамж.

Нэхэмжлэлийн шаардлага:

Дархан-Уул аймгийн хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын дарга С.Э, нийгмийн халамжийн сангийн мэргэжилтэн Э.Б нараас 847,800 төгрөг гаргуулах тухай.

Хэргийн товч агуулга:

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “Санхүүгийн хяналт, аудитын албанаас батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 02 дугаар сарын 29-ний өдрөөс ажлын 20 хоногт багтаан аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2017, 2018 оны санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны баримтад төлөвлөгөөт шалгалтыг гүйцэтгэж, Нийгмийн халамжийн сангаас олгох амралт, асаргаа, тэтгэвэр

тэтгэмжийн хөнгөлөлтийн зөрүү үүсгэж, дутуу олгосон зөрчилд улсын ахлах байцаагчийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 23-01-19/26, 23-01-19/27, 23-10-19/29 тоот актуудын дагуу төсөвт төлүүлэхээр Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Э, Халамжийн сангийн мэргэжилтэн Э.Б нарт хариуцуулан барагдуулахаар төлбөрийн актыг тогтоосон болно. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус зөрчиж Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг үндэслэлгүй зарцуулсан”. Иймд төлбөрийн барагдуулаагүй актуудын үлдэгдэл 847,800 төгрөгийг хариуцагч Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Э, Э.Б нараас гаргуулж, төсөвт төвлөрүүлж өгнө үү¹¹ гэжээ.

Шүүгчийн захирамжийн үндэслэл:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 184.1-д “Эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр шийдвэрлэсэн, талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн болон цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг албадан гүйцэтгүүлэхээр бол уг цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр,

¹¹ Дархан-Уул аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021.06.11-ний өдрийн 2097 дугаартай захирамж.

улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт шүүхээр баталгаажсан байна., мөн хуулийн 184.2-т “Шийдвэрийг гүйцэтгүүлэхийг сонирхож байгаа тал цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) харьяалах шүүхэд хүсэлт гаргана” гэж заажээ.

Өөрөөр хэлбэл, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин байгаа харьяалах шүүхэд хүсэлт гаргахаар зохицуулсан байх тул Дархан-Уул аймгийн Санхүү хяналтын аудитын улсын байцаагчийн гаргасан төлбөрийн актуудын барагдуулаагүй үлдэгдэл 847,800 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл нь ИХШХШтХ-ийн 12 дугаар зүйлд заасан иргэний хэрэг үүсгэж, хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй байна.

Иймд Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Дархан-Уул аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Э, Халамжийн сангийн мэргэжилтэн Э.Б нарт холбогдуулан 847,800 төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэлийг ИХШХШтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.1-д заасны дагуу хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага ИХ-ийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гээд 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны

байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан ба хэрэв ийм нэгж байхгүй бол төрийн аудитын байгууллага нь төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх ажлыг хариуцдаг. “Аудитын нэгж хариуцан барагдуулна” гэдэг нь үр дүнг шаардсан зохицуулалт бөгөөд үйл явц болон аргыг зааж тодорхойлоогүй.

Шүүхээр шийдвэрлүүлж байгаа хэрэг маргаан нь тухайн шүүхийн харьяаллын маргаан мөн эсэх нь нэн тэргүүний асуудал юм. Маргаан бүхий нөхцөл байдлын хувьд Нийгмийн даатгалын сангаас олгох амралт, асаргаа, тэтгэвэр, тэтгэмжийн хөнгөлөлтийн зөрүү үүсгэж, илүү болон дутуу олгосон зөрчилд улсын ахлах байцаагчийн 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 23-01-19/26, 23-01-19/27, 23-01-19/23 тоот актуудын дагуу төсөвт төлүүлэхээр Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга С.Э, Халамжийн сангийн мэргэжилтэн нарт хариуцуулан барагдуулахаар төлбөрийн актыг тогтоосон гэжээ.

Нэхэмжлэгчийн хувьд дээрх актыг баталгаажуулахаар шүүхэд хандсан байх бөгөөд улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт нь ИХШХШТХ-ийн 183, 184 дүгээр зүйлд тус тус заасны дагуу албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргаснаар шүүхээс баталгаажуулж энэ тухай гүйцэтгэх хуудас олгогддог эрх зүйн үр дагавар бүхий баримт бичиг юм.

Иймд тухайн акттай холбоотой төлбөрийг гаргуулах ажиллагааг иргэний хэргийн шүүхэд маргаан үүсгэх замаар бус шууд гүйцэтгүүлэх хүсэлт гаргах байдлаар албадан гүйцэтгүүлэх боломжийг хуулиар олгосон байна. Энэ тохиолдолд шүүхийн бус журмаар төлбөр барагдуулах харилцаа гэж үзнэ. Гэтэл Нийгмийн халамжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д “Нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, ажилтны гаргасан алдааны улмаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар төлүүлнэ” гэж заажээ.

Иймд илүү нарийвчилсан зохицуулалтаар нийгмийн халамжийн санд учирсан хохирол барагдуулах ажиллагааг “Шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар төлүүлэх”-ээр зохицуулжээ.

Шүүхээс ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.1-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий болж чадаагүй байна.

Жишээ 2. *Архангай аймгийн сум дундын ИХАШШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 129/ШЗ2022/00418 дугаар хүсэлт шийдвэрлэх тухай шүүгчийн захирамж.*

Хэргийн товч агуулга:

Архангай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1, 184.2-ыг үндэслэн, аудит хяналт шалгалтаар тогтоогдсон иргэн Ж.Б-тай холбоотой 43,193,285 төгрөгийн улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг шүүхээр баталгаажуулахаар хүсэлт гаргажээ.

Өмнө нь улсын байцаагчийн төлбөр тогтоосон тус акттай Ж.Б нь маргаж, актыг хүчингүй болгуулахаар аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасныг Завхан аймаг дахь захиргааны хэргийн шатны шүүх хянан хэлэлцэж, 2020 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 118/ШШ2020/0012 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүгчийн захирамжийн үндэслэл:

Шүүгчийн захирамжаар уг актаар тогтоогдсон төлбөрийн биелэлтийг хангуулах нь Архангай аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн харьяалан шийдвэрлэх хүсэлт биш байх тул Архангай аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь уг захиргааны хэргийг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхэд

хандаж шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэх нь зүйтэй¹² гэж үзэн улсын байцаагчийн актыг баталгаажуулах тухай хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Дүн шинжилгээ:

Дархан-Уул аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2097 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжаар ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1, 184.2-т заасны дагуу улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) харьяалах шүүхэд хүсэлт гаргах боломжтой гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Гэтэл хуулийн энэ зохицуулалтын дагуу Архангай аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг адил шатны шүүх хуулийг өөр байдлаар дүгнэн, иргэний хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал биш хэмээн хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Тус тохиолдолд шүүхээс дээрх хүсэлтийг тухайн акттай холбогдох маргааныг шийдвэрлэсэн захиргааны хэргийн шүүхэд хандах ёстой гэж дүгнэснээс үзвэл шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх тухай хүсэлттэй андуурсан нөхцөл байдлыг шүүх бий болгосон байна. Акттай холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж хэрэгсэхгүй болгосон тул тус төлбөр тогтоосон акт хуулийн хүчин төгөлдөр хэвээр үлдсэн.

Иймээс “Улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт”-д дурдсан төлбөрийг төлүүлэх талаар ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д заасныг үндэслэж, гүйцэтгэх хуудас бичүүлэх хүсэлт гаргах нь захиргааны хэргийн шүүхийн

¹² Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2022.01.14-ний өдрийн 129/ШЗ2022/00418 дугаар хүсэлт шийдвэрлэх тухай шүүгчийн захирамж.

шийдвэр гүйцэтгэхээс зарчмын хувьд өөр ойлголтууд байна. Гэтэл эдгээр зохицуулалтыг ялгамжтай авч үзэхгүйгээр шүүхээс ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д зааснаар улсын байцаагчийн төлбөр тогтоосон актад үндэслэж, гүйцэтгэх хуудас бичихээс татгалзсан нь үндэслэлгүй байна.

Улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг шүүгчийн захирамжаар албадан гүйцэтгүүлэхээс татгалзсан тул аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас актаар тогтоосон төлбөрийг гаргуулахаар Архангай аймаг дахь Сум дундын ИХАШШ-д нэхэмжлэл гаргасан хэд хэдэн тохиолдол гарчээ.

Жишээ 3. Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 129/ШШ2022/00089 дүгээр шийдвэр.

Хэргийн товч агуулга:

Хариуцагч П.М нь Архангай аймгийн Цэцэрлэг сумын Засаг дарга байхдаа аймгийн ЗДТГ-ын дарга П.Ч-г үүрэгт ажлаас нь чөлөөлсөн бөгөөд П.Ч нь захиргааны хэргийн шүүхэд тухайн тушаалтай маргаан үүсгэж, улмаар захиргааны шүүхээс түүнийг урьд эрхэлж байсан ажилд нь эргүүлэн томилжээ. Архангай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 129/ШШ2020/00838 дугаар шийдвэрээр хариуцагч П.М-аас нэхэмжлэгч П.Ч-д ажилгүй байсан хугацааны цалинд 26,053,035 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсний дагуу аймгийн ЗДТГ-аас цалингийн нөхөн олговор, нийгмийн даатгалын шимтгэлд нийт 10,657,818 төгрөгийг П.Ч-д олгосон байна.

Ингээд аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны улсын ахлах байцаагч 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Төсвийн орлого болгох тухай 17/03/12 дугаартай акт үйлдэн,

буруутай албан тушаалтан П.М-ээр нөхөн төлүүлэхээр тогтож тус актыг үндэслэж, аймгийн Санхүү аудитын албанаас төрд учирсан хохирол 10,657,818 төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

Шүүхийн шийдвэр:

Анхан шатны шүүх ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2, ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1 болон 498 дугаар зүйлийн 5-д заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэжээ..

Дүн шинжилгээ:

Энэ тохиолдолд улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг албадан гүйцэтгүүлэх талаарх ИХШХШтХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1, 184.2-оор аудитын байгууллага төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай актыг шүүхэд албадан гүйцэтгүүлэх хүсэлт гаргах замаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байхад шүүх тус зохицуулалтыг хэрэглэхээс үндэслэлгүйгээр татгалзсан байна.

Үүнээс улбаалан аудитын байгууллага төлбөр тогтоосон акт гаргасан бөгөөд тэрхүү акт нь ЗЕХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Захиргааны актыг цуцлах, хүчингүй болгох, эрх бүхий байгууллагын шийдвэр гарах, эсхүл захиргааны актад заасан хугацаа дуусгавар болох, түүнчлэн бусад байдлаар биелэгдэх хүртэл тухайн захиргааны акт хүчин төгөлдөр байна” гэж зааснаар хүчин төгөлдөр байхад тус агуулгаар дахин шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүх акт дахь асуудлыг дахин шийдвэрлэж байгаа нь үндэслэлгүй байна. Энэ нь ЗЕХ-ийн Наймдугаар бүлэгт заасан захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд заагдаагүй арга болох шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхээр шийдвэрлүүлэх аргыг хэрэглэж буй нь зарчмын алдаатай үйл ажиллагаа байна.

Үүнтэй ижил дөрвөн тохиолдлыг нэхэмжлэлийн шаардлагыг

бүхэлд нь ханган шийдвэрлэсэн¹³ (2), хялбаршуулсан журмаар¹⁴ (2) тус тус шийдвэрлэжээ.

Иймд шүүхүүд хуулийн эдгээр зохицуулалтын хэрэглээг нэгдмэл болгох, цаашлаад ИХШХШТХ 184 дүгээр зүйлийн 184.2-т заасан улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг шүүгчийн захирамжаар шууд албадан гүйцэтгүүлэх зохицуулалтыг хэрэглэж, практикт нэвтрүүлэх нь богино хугацаанд төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ач холбогдолтой юм.

Дүгнэлт

Судалгааны явцад цугларсан шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийн хүрээнд авч үзэхэд аудитын байгууллага төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилсэн нийт 7 тохиолдлыг (2020-2022 он) шүүхээр хянан шийдвэрлэжээ. Эдгээрээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн 3, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан 2, зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн тохиолдол 2 байна.

ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан. Тухайн зохицуулалт нь хохирол нөхөн төлүүлэх үүргийг заасан бөгөөд харин ямар арга замаар хохирлыг нөхөн төлүүлэх аргыг тодорхойлж өгөөгүй.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах,

¹³ Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2020.04.28-ны өдрийн 00456 дугаар шийдвэр, 2020.04.29-ний өдрийн 00461 дүгээр шийдвэр.

¹⁴ Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2020.04.22-ны өдрийн 00441 дүгээр захирамж, 2022.04.17-ны өдрийн 00421 дүгээр захирамж.

нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно” гэж заасан.

Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг ЗЕХ-ийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ” гэж заасан. Мөн ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.2-т “Шийдвэрийг гүйцэтгүүлэхийг сонирхож байгаа тал ... улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) харьяалах шүүхэд хүсэлт гаргана” гэж заасан.

Гэтэл аудитын байгууллагаас буруутай этгээдээс хохирол нөхөн төлүүлэх ажиллагааг дээрх журмаар улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт тавьж түүнд үндэслэн гүйцэтгэх хуудас бичүүлж хэрэгжилтийг хангуулсан тохиолдол байхгүй байна. Архангай аймгийн санхүүгийн хяналт аудитын албанаас дээрх журмаар “Улсын байцаагчийн акт”-ыг албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хандсан боловч Архангай аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан байна.

Иймд цаашид санхүүгийн хяналт аудитын албанаас “Улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт”-ыг гүйцэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлжээ. Гэтэл эрх бүхий этгээдээс гаргасан хүчин төгөлдөр актад дурдагдсан асуудлыг дахин шүүхийн журмаар нэг бүрчлэн хэлэлцэж тухайн актаар тогтоосон нэхэмжилж буй дүнг үндэслэлтэй эсэхийг дахин дүгнэх байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлж байна.

Энэ нь захиргааны акттай холбогдуулж эрх нь хөндөгдсөн этгээд шүүхийн журмаар маргаагүй байхад Иргэний хэргийн

шүүхээс захиргааны актыг дахин хянах ажиллагаа явуулж байгаа нь зарчмын ноцтой зөрчил бүхий үйл ажиллагаа болжээ.

Аудитын төлбөр тогтоосон акт үндэслэлгүй гэж холбогдогч этгээд үзвэл урьдчилан шийдвэрлэх болон шүүхийн журмаар хянуулах эрх нь нээлттэй байгаа болно. Нөгөө талаар дээрх байдлаар аудитын алба гаргасан актын гүйцэтгэлийн шүүхэд нэхэмжлэл гаргах байдлаар хангуулах нь цаг хугацаа алдах, хохирол нөхөн төлүүлэх боломж магадлалыг багасгах, аудитын байгууллагын үр нөлөөг бууруулахаар байна.

Шүүхийн зүгээс ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1 дэх заалтыг хэрэгжүүлэхээс үндэслэлгүй татгалзаж буй нь Аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсан шийдэл болжээ. Харин Нийгмийн халамжийн тухай хуульд Нийгмийн халамжийн санд учирсан хохирлыг “Шүүхийн журмаар барагдуулах” тусгай зохицуулалттай тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх түүнийг хүлээн авч шүүх хуралдаанаар шийдвэрлэх боломжтой байна.

Дээрх байдал нь хууль тогтоомжийн болон тогтолцооны алдаа зөрчил бус харин хууль хэрэглээний практик алдаа байгааг харуулж байна.

2.2. ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ШҮҮХЭД ХАНДСАН ТОХИОЛДОЛ

Жишээ 4. БЗДИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 101/ШШ2019/03027 дугаар шүүхийн шийдвэр, НИХДЗШШ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 209 дүгээр магадлал, УДШ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2021/01246 дугаар тогтоол.

Хэргийн товч агуулга:

Хариуцагч Б.Э нь Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байх хугацаандаа 2017 оны ... тоот тушаалаар Б.М-г Гэр хорооллын дахин төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнийг албан тушаалаас чөлөөлсөн. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр хариуцагчийн гаргасан 2017 оны тушаалыг хүчингүй болгож, Б.М-г урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлс 775,783 төгрөгийг ханган шийдвэрлэж, учирсан хохирлыг Хан-Уул дүүргийн ЗДТГ-аас олгожээ.

Улмаар Төрийн албаны зөвлөлөөс Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Э-д холбогдуулан Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2-т заасны дагуу гэм хорын хохиролд 775,783 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснийг Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн магадлалаар хэвээр үлдээсэн бол УДШ-ээс анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн байна.

Шийдвэрийн үндэслэл:

Анхан болон давж заалдах шатны шүүхээс Төрийн албаны зөвлөлийг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэж шийдвэрлэжээ. Төрийн албаны тухай хууль (2002)-ийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т Төрийн албаны зөвлөл нь “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг гаргуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заасан. Тус заалт нь Төрийн албаны зөвлөлийн эрхээ хэрэгжүүлэх зохицуулалт учир хариуцагч Б.Э-ийн 2017 онд албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад бусдад гэм учруулсан үйлдэлд нь гэм хорын хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

Төрийн албаны тухай хууль (2017.12.07 шинэчилсэн найруулга)-ийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ. 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж тус тус заажээ. Дээрх хуулийн заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр журамласан тул тус зохицуулалт нь хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавихтай холбоотой үйл баримтад үйлчлэхээр байна. Иймд дээрх заалтаар хариуцагч Б.Э-ийн

2017 онд ажил үүргээ гүйцэтгэж байхдаа гаргасан шийдвэртэй холбоотой учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг Төрийн албаны зөвлөлд үүсээгүй¹⁵ гэж үзсэн байна.

Төрийн албаны тухай /2002 он/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д “Хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах” гэж заасан төрийн албаны зарчмаас үзэхэд хариуцагч Б.Э-ын үйл ажиллагаатай холбоотой хохирлыг төр хариуцна гэж нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Анхан болон давж заалдах шатны шүүх 2002 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д заасан заалтыг үндэслэн, “Б.Э-ийн үйл ажиллагаатай холбоотой учирсан хохирлыг төр хариуцна” гэж үзэн “Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн” гэж үзэхээр байна. Учир нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцна гэсэн заалт нэхэмжлэлийн шаардлагын эрх зүйн үндэслэлд хамаарахгүй зохицуулалт юм.

Мөн төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай “Төрийн албаны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр журамласан тул үүнээс хойших хугацааны төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавихтай холбоотой үйл баримтад үйлчлэхээр байна” гэж хоёр шатны шүүх дүгнэсэн нь үндэслэлгүй болжээ. Тодруулбал, 2002 оны Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д “Зөвлөл дараах бүрэн

¹⁵ БЗДИХАШШ-ийн 2019.11.05-ны өдрийн 101/ШШ2019/03027 дугаар шүүхийн шийдвэр, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.01.27-ны өдрийн 209 дүгээр магадлал.

эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.2-т “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих”, энэ хуулийн 39.1-д заасан “Маргааныг хянан шийдвэрлэх, **албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах** мөн төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах тухай” зохицуулалт үйлчилж байсан тул тухайн үйл баримтад хуулийн тус зохицуулалтыг хэрэглэх боломжтой.

Харин УДШ-ийн тогтоолоор хоёр шатны шүүхийн хууль хэрэглээний алдааг засаж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэжээ. Ингэхдээ хоёр шатны шүүхийг хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй буюу ИХ-ийн 498.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана” гэж, 498.5-д энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан “Этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэж зааснаар “Нэхэмжлэгч нь өөрт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй гэх зохицуулалтыг хэрэглэх ёстой байсан” гэж дүгнэжээ.

Анхан болон давж заалдах шатны шүүх 2002 оны Төрийн албаны тухай хууль болон 2019 оны Төрийн албаны тухай хуулиар төрийн албаны зөвлөлийн шаардах эрхийг тодорхойлсон заалтын хэрэглээтэй холбоотой тодорхой дүгнэлт өгөөгүй байна.

Жишээ 5. *Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар магадлал.*

Хэргийн товч агуулга:

Хариуцагч Н.Э нь Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байх хугацаандаа 2016 оны ... тоот тушаалаар Б.Г-г Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалаас чөлөөлжээ. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан, давж заалдах, УДШ-ээс Н.Г-г урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин хөлс 1,620,017 төгрөгийг ханган шийдвэрлэсэн. Дээрх шүүхийн шийдвэрийг хариуцагч Н.Э нь биелүүлээгүйн улмаас ажилтан Н.Г нь ажилгүй байсан хугацааны цалин хөлс 7,061,664 төгрөгийг нэхэмжилснийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс ханган шийдвэрлэж, учирсан хохирлыг Сүхбаатар дүүргийн ЗДТГ-аас олгосон байна.

Улмаар Төрийн албаны зөвлөл нь Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Э-д холбогдуулан, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2-т заасныг үндэслэн Н.Э-ийн хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан хохирол болох нийт 8,904,718 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

Шүүхийн шийдвэр:

ХУДИХАШШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02620 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлага хангасныг давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шийдвэрийн үндэслэл:

Давж заалдах шатны шүүхээс Төрийн албаны зөвлөлийг нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэж шийдвэрлэжээ.

Төрийн албаны тухай хууль (2002)-ийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т Төрийн албаны зөвлөл нь “Төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих”, энэ хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг гаргуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж заасан. Тус заалт нь Төрийн албаны зөвлөлийн эрхээ хэрэгжүүлэх зохицуулалт учир хариуцагч Н.Э-ийн албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад бусдад гэм учруулсан үйлдэлд нь гэм хорын хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

Төрийн албаны тухай хууль (2017.12.07 шинэчилсэн найруулга)-ийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ”; мөн 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж тус тус заасан. Дээрх хуулийн заалтыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр журамласан тул тус зохицуулалт нь хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавихтай холбоотой үйл баримтад үйлчлэхээр байна. Иймд дээрх заалтаар “Хариуцагч Н.Э-ийн 2016 онд ажил үүргээ гүйцэтгэж байхдаа гаргасан шийдвэртэй холбоотой учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг Төрийн

албаны зөвлөлд үүсээгүй”¹⁶ гэж үзэж шийдвэрлэжээ.

Дүн шинжилгээ:

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхээс 2002 оны Төрийн албаны тухай хуулийн 35.1.2-т “Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг гаргуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заасан нь төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийг Төрийн албаны зөвлөл хэрэгжүүлэх зохицуулалт байна. Иймд “Албан тушаалын чиг үүргийн дагуу үүргээ гүйцэтгэж байхдаа бусдад учруулсан гэм хорыг нөхөн төлүүлэх үндэслэл байхгүй” гэж дүгнэсэн нь ойлгомжгүй. Төрийн албаны хуулиар төрийн албаны зөвлөлд нэхэмжлэх эрх олгосон заалт төрийн албан хаагчийг буруутай үйл ажиллагаагаараа төрд учруулан хохирол (гэм хор)-ыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх зохицуулалт болгож хэрэглэх боломжгүй. Харин 2019 оны Төрийн албаны тухай хуулиас хойш үүссэн гэм хорыг буруутай төрийн албан хаагч төлөх үүрэг тус хуулийн 50.2-т зааснаар үүсэх мэтээр хуулийг тайлбарлан хэрэглэжээ.

Тус тохиолдолд хуулийг хэрэглэхдээ алдаа гаргасан гэж дүгнэхээр байна. Учир нь нэхэмжлэл гаргах эрх бол процессын эрх зүйн зохицуулалт, харин гэм хорыг нөхөн төлөх үүрэгтэй эсэх асуудал нь материаллаг эрх зүйн зохицуулалт юм. Процессын зохицуулалтаар материаллаг хуулиар хүлээсэн үүрэггүй байх гэх агуулга бүхий дүгнэлт хийх боломжгүй. Тухайн тохиолдолд Төрийн албаны зөвлөл “Албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас төрд учруулсан хохирол”-ыг гаргуулахаар буруутай албан тушаалтантай холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх буюу иргэний хэрэг үүсгэх үед хэрэглэгдэх ёстой. Хэрэв Төрийн албаны зөвлөлд нэхэмжлэл гаргах эрх олгогдоогүй гэж дүгнэж буй бол ИХШХШТХ-ийн 65

¹⁶ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.02.14 өдрийн 376 дугаар магадлал.

дугаар зүйлийн 65.1-д “Шүүгч дараах тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана”; 65.1.5-д “Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэх үндэслэлд хамаарах бөгөөд энэ нөхцөл иргэний хэрэг үүсгэснээс хойш бий болсон бол ИХШХШтХ-ийн 117 дугаар зүйлийн 117.1-д “Энэ хуулийн 65.1.9-д заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш, 65.1.1, 65.1.3-65.1.8, 65.1.10-д заасан үндэслэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үед тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно. Энэ тухай шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж заасны дагуу шүүхээс захирамж эсвэл тогтоол гарах ёстой.

Харин хариуцагчаар оролцож буй этгээд байгууллагад учирсан хохирлыг үүсгэхэд гэм буруутай эсэх, тухайн гэм буруу нь шууд санаатай болон илтэд болгоомжгүй гэм буруугийн хэлбэрээр үйлдэгдсэн эсэхийг дүгнэсний үндсэн дээр ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасныг хэрэглэж нэхэмжлэлийн шаардлагыг хангах, хэрэгсэхгүй болгох эсэх асуудлаар шийдвэр гаргах ёстой. Иймд тус тохиолдолд шүүх материаллаг хуулийг хэрэглээгүй байна гэж үзэхээр байна.

Жишээ 6. *Сүхбаатар аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2022 оны 01 дүгээр 04-ний өдрийн 147/ШЗ2022/00045 дугаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж.*

Нэхэмжлэлийн шаардлага:

Төрийн албаны зөвлөлийн 4,797,201 төгрөгийг Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2-р багт оршин суух М.Ө-өөс гаргуулах тухай нэхэмжлэлтэй иргэний хэрэг.

Хэргийн товч агуулга:

М.Ө нь Сүхбаатар аймгийн Мэргэжлийн хяналтын газрын

даргын алба үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа 2019 оны 10 сарын 28-ны өдөр Б/73 тоот тушаал гаргаж, М.Ч-г тус газрын Төрийн газрын захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалаас халсан.

Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 11 дүгээр шийдвэрээр тус аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2019 оны 10 сарын 28-ны өдрийн Б/73 тоот тушаал хууль бус болохыг тогтоож хүчингүй болгож, М.Ч-г төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалинд 5,252,224 төгрөгийг олгохоор шийдвэрлэсний дагуу тус газраас 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр М.Ч-д 4,797,201 төгрөг олгожээ.

Албан тушаалтны хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан хохирол болох нийт 4,797,201 төгрөгийг буцаан нэхэмжилжээ.

Шүүгчийн захирамжийн үндэслэл:

Шүүхээс нэхэмжлэгч Төрийн албаны зөвлөл нь хариуцагч М.Ө-д холбогдуулан 4,797,201 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэх шүүхэд ирүүлсэн ч нэхэмжлэлийн шаардлагадаа “... 4,797,201 төгрөгийг буруутай албан тушаалтан хариуцагч Я.С-ээс гаргуулж өгнө үү...” гэсэн нь хариуцагчийн нэрийг зөрүүтэй бичиж, хариуцагч нь хэн болох нь тодорхойгүй, мөн хариуцагчийн хаяг тодорхойгүй тул ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.11-д зааснаар нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаагүй нь хүлээн авахаас татгалзах үндэслэл болж байна”¹⁷ гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Нэхэмжлэгчийн нэхэмжлэх эрхийн тухайд шүүх дүгнэлт хийгээгүй байна. Нэхэмжлэгчийн хувьд шүүхэд гаргасан нэхэмж-

¹⁷ Сүхбаатар аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2022.01.04-ний өдрийн 147/ШЗ2022/00045 дугаар захирамж.

лэлдээ хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтан М.Ө-д холбогдуулан нэхэмжлэл гаргасан атлаа “Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлдээ хариуцагч Я.С-ээс 4,797,201 төгрөгийг гаргуулж өгнө үү” гэдэг байдлаар хариуцагчийн нэрийг зөрүүтэй бичсэн тул ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийн шаардлагыг хангаагүй, мөн хаяг тодорхойгүй гэх үндэслэлээр ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.11-д заасны дагуу нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ. Хариуцагч этгээдийн нэр зөрүүтэй байгаа байдал нь ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлийн 62.1.3-д заасан шаардлагыг хангаагүй гэж үзэж байгаа нь хуульд нийцсэн байна. Харин хариуцагчийн хаяг тодорхойгүй байдал нь ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан хүлээн авахаас татгалзах үндэслэлд хамаарах тул тухайн заалтыг үндэслэж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байсан.

Учир нь ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасан шаардлага нь зөвхөн хэлбэрийн хувьд бичгээр гаргасан нэхэмжлэлд тавигдах шаардлагад хамаарах бол хуулийн 65 дугаар зүйлд заасан шаардлага нь тухайн нэхэмжлэлийг хүлээн авч хэргийг хянан шийдвэрлэх боломжтой эсэхийг тодруулах ач холбогдолтой юм.

Дээрх байдлаар техникийн ялимгүй алдаа гаргаж, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзуулах нь төрд учирсан хохирлыг төсөвт буцаан төвлөрүүлэхэд цаг хугацаа алдах сөрөг үр дагавартай тул цаашид энэ төрлийн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх нь зүйтэй байна. Төрийн албаны зөвлөлийн хувьд М.Ө эсвэл Я.С нарын алинд нэхэмжлэлийн шаардлагаа холбогдуулан гаргаж байгаа нь тодорхойгүй байгаа тул шүүх уг үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

Судалгааны материалаар Төрийн албаны зөвлөлийн шүүхэд

гаргасан 3 нэхэмжлэл шийдвэрлэгдсэн байх бөгөөд үүний 1 нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 1 тохиолдолд төрийн албаны зөвлөл шаардах эрхгүй гэж дүгнэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол өөр 1 тохиолдолд нь нэхэмжлэгч нэхэмжлэл гаргахдаа алдаа гаргасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон шийдвэр, магадлалын тухайд 2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулиар Төрийн албаны зөвлөл төрд учирсан хохирлыг нэхэмжлэх эрхийг олж авсан. Харин үүнээс өмнө тийнхүү шаардах эрх байгаагүй тул 2019 оноос өмнө (Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр мөрдөгдөх) учирсан хохирлыг Төрийн албаны зөвлөл нэхэмжлэх эрхгүй гэх дүгнэлт хийсэн нь өрөөсгөл байна.

2002 оны Төрийн албаны тухай хуулийн 35.1.2-т заасан “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг гаргуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж зааснаар төрийн албан хаагчийн төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрх Төрийн албаны зөвлөлд байсан.

Харин 2017 онд батлагдаж 2019 оны 01 дүгээр сарын 01-ээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх эрхийн хүрээг явцууруулж төрийн албан хаагчийн дараах тохиолдлоор төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхийг олгосон. Үүнд:

1. Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлснөөр үүссэн байх,
2. Тус шийдвэр хууль бус болохыг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон байх

Шүүхээс үйл баримт болох үед хүчин төгөлдөр байсан төрийг

төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийг олгосон Төрийн албаны тухай хуулийг болон буруутай этгээдээс өөрт үүссэн хохирлыг шаардах эрхийг олгосон ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь хэсгийг үндэслэлгүйгээр хэрэглээгүй байна. Ижил тохиолдолд УДШ-ээс дээрх алдааг залруулжээ.

2.3 ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА НЭХЭМЖИЛСЭН ТОХИОЛДОЛ

Жишээ 7: Говь-Алтай аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 133/ШШ2021/00196 дугаар шийдвэр.

Хэргийн үйл баримт:

Хариуцагч С.Г нь Говь-Алтай аймгийн Засаг даргаар ажиллаж байхдаа 2018 оны ... дугаартай захирамжаар Есөнбулаг сумын ЕБ-ын 3 дугаар сургуулийн захирлыг ажлаас үндэслэлгүй чөлөөлсөн нь Говь-Алтай аймаг дахь ЗХАШШ-ийн шийдвэрээр тогтоогдож, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх нөхөн олговорт 13,577,325 төгрөгийг олгохоор шийдвэрлэж улсын төсвөөс тус хохирлыг төлж барагдуулжээ.

Улмаар Говь-Алтай аймгийн ЗДТГ-аас 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 6/194 дугаартай албан бичгээр аймгийн Прокурорын газарт хандан төрийг төлөөлж, нэхэмжлэл гаргуулахаар хүсэлт илгээснийг прокурор үндэслэн Прокурорын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, ИХШХШТХ-ийн 25, 31 дүгээр зүйлд заасны дагуу С.Г-ийн хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан 13,577,325 төгрөгийн хохирлыг гаргуулахаар нэхэмжлэл гаргажээ.

Шүүхийн шийдвэр:

Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн. Тодруулбал хариуцагч нь хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад хохирол учруулсан буюу шүүхийн шийдвэрийн үндсэн дээр ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг байгууллагын төсвөөс олгосон болох нь хэрэгт нотлох баримтаар авагдсан төлбөрийн хүсэлтээр нотлогдож байх боловч С.Г-ийг хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдлээр байгууллагад гэм хор учруулсан гэж үзэх үндэслэл болохгүй гэж үзжээ. Мөн түүнтэй ажил олгогч нь эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэхээр гэрээгээр тохирсон байдал хэргийн үйл баримтаар нотлогдон тогтоогдоогүй тул эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэх, энэ нь ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй¹⁸ гэж дүгнэсэн байна.

Ингээд нэхэмжлэлийн шаардлагаас 1,418,630 төгрөгийг хангаж үлдэх 12,158,695 төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг Аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 215/МА2021/00016 дугаар магадлалаар хэвээр үлдээсэн байна.

Дүн шинжилгээ:

Тус шийдвэрт нэхэмжлэгч прокурорын байгууллагыг шаардах эрхтэй байна гэж дүгнэсэн. Үүнд: Говь-Алтай аймгийн ЗДТГ-аас 2021 оны 02 сарын 05-ны өдрийн 6/194 дугаартай албан бичгээр Говь-Алтай аймгийн прокурорын газарт төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргуулахаар хүсэлт ирүүлснийг прокурорын байгууллагаар төрийг төлөөлүүлж шүүхэд нэхэмжлэл гаргуулах хүсэл зоригийн илэрхийлэл гэж үзэх үндэслэлтэй” гэжээ. Үүгээр Говь-Алтай аймгийн прокурорын газрын нэхэмжлэлийг прокурор ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн

¹⁸ Говь-Алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2021.05.20-ны өдрийн 133/ШШ2021/00196 дугаар шийдвэр

31.1-д зааснаар төрийн ашиг сонирхол хөндөгдсөн асуудлаар, төрийн байгууллагын хүсэлтээр оролцсон гэж үзсэн байна.

Маргааны хувьд төрийн албан хаагчийг хууль бусаар халсны улмаас төрд учирсан хохирол нөхөн төлүүлэх харилцаа байна. Хариуцагчийн хувьд ажилтныг ажлаас халах шийдвэрийг Төрийн албаны хууль (2019) хэрэгжиж эхлэхээс өмнө гаргасан учир үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байна гэх тайлбар өгчээ.

Ажлаас халах захирамж 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр гарсан бөгөөд тус “буруутай” үйлдэл гарах үед дараах хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж байсан. Үүнд:

1. ИХ-ийн “498.1.Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ.”, “498.5.Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-д заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.”;
2. Мөн ЗЕХ-ийн “103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага ИХ-ийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.”, “103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.”

Иймд хариуцагч төрд албан тушаал эрхэлж байхдаа буруутай шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх үүргийг хүлээнэ.

Харин тус хохирлыг хэн нэхэмжлэх вэ гэдэг нь процессын харилцаа тул нэхэмжлэл гаргах үеийн хуулийг энд баримтална.

Говь-Алтай аймгийн прокурорын газар Говь-Алтай аймгийн шүүхэд 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр ханджээ. Тус нэхэмжлэл гаргах үед төрд учруулсан хохирлыг нэхэмжлэхтэй холбоотой дараах хуулиуд хүчин төгөлдөр байсан. Үүнд:

1. ЗЕХ-ийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага ИХ-ийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасан;
2. ЗЕХ-ийн 103.2-т зааснаар “тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”;
3. Төрийн албаны тухай хуулийн 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасан;
4. Прокурорын тухай хуулийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж заасан.

Тус тохиолдолд дээрх хуулиудын алийг баримтлах вэ? гэдэг нь нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг тодорхойлоход шууд ач холбогдолтой. Тус хохирол “Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ЕБ-ын 3-р сургуулийн захирал буюу төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтныг хууль бусаар ажлаас халснаас үүссэн.” Төрийн албаны тухай хуулийн 50.1-д

“Төрийн **жинхэнэ** албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж заасан тул төрийн үйлчилгээний албан тушаалтныг хууль бусаар халсан хохирлыг нөхөн төлүүлэх үүрэг Төрийн албаны зөвлөлд байхгүй.

ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1-д “тухайн байгууллага өөрт учирсан хохирлыг **нөхөн төлүүлнэ**”, 103.3-д “тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын **нэгж хариуцна**” гэж заасан. Эдгээр нь шууд тус этгээдүүдэд хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийг тогтоосон болохоос аргыг нь тодорхойлсон зохицуулалт биш байна.

Иймд тухайн байгууллага өөрөө прокурорт хүсэлт гаргаж төрийн зөрчигдсөн ашиг сонирхол (төсвийн хөрөнгө)-ийг нөхөн төлүүлэх зорилгоор нэхэмжлэл гаргуулж шийдвэрлүүлэх боломжтой байна. Иймд тус тохиолдолд прокурорыг нэхэмжлэл гаргах эрхтэй гэж дүгнэсэн шүүхийн шийдэл үндэслэлтэй байна.

Харин шүүхээс тус нэхэмжлэлийн шаардлагыг “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасан эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээлгэх гэж тодорхойлсон байна. Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-д зааснаар төрийн албан хаагчтай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна гэж заажээ. Иймд “Хөдөлмөрийн тухай хууль (1999)”-ийн 132 дугаар зүйлийн 132.1-д “Хөдөлмөрлөх үүргээ хэрэгжүүлэх явцаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан болон тус хуулийн 133 дугаар зүйлийн 133.1-д “Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад өөрийн буруугаас хохирол учруулсан ажилтан энэ хуулийн 135 дугаар зүйлд зааснаас

бусад тохиолдолд эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээх бөгөөд тэр нь уг ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтэрч болохгүй” гэж зааснаар хариуцагч С.Г-д эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэж түүний нэг сарын хөдөлмөрийн хөлс болох 1,418,630 төгрөг хэмжээнд нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгосон.

Хариуцагч нь хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтан биш бөгөөд эрх зүйн байдал нь Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуулиар эрх хэмжээ олгосон “Харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч” болох аймгийн Засаг дарга юм.

Иймд тус албан тушаалтныг “Хөдөлмөрийн тухай хууль (1999)”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “Ажилтан” гэж ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэнийг хэлнэ гэж заасан ажилтан гэж дүгнэж засаг даргын засаглан шийдвэр гаргах эрх хэмжээгээ хэрэгжүүлснийг “Хөдөлмөрлөх үүргээ хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон нь үндэслэлгүй байна.

Захиргааны байгууллага албан тушаалтны буруутай шийдвэр үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.2 болон мөн хуулийн 498.5 дахь заалтаар зохицуулсан, мөн ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1-д “буцааж төлүүлнэ” хэмээн зохицуулжээ. ИХ-ийн 3 дугаар зүйлийн 3.3-д “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж заасан. Тухайн тохиолдолд төрийн албан хаагчийн буруутай шийдвэр, үйл ажиллагааны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх харилцааг зохицуулсан

буюу илүү нарийвчилсан хууль нь ЗЕХ болон ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.2, 498.5 заалт юм. Гэтэл хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн хоорондын харилцааг зохицуулсан хөдөлмөрийн тухай хуулийг тус харилцаанд авч хэрэглэсэн нь хууль хэрэглэх дарааллын хувьд алдаа гаргасан гэж дүгнэхээр байна.

Жишээ 8. *Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 212/МА2020/00075 дугаар магадлал.*

Хэргийн товч агуулга:

Хариуцагч М.Х нь Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ЗДТГ-ын даргаар ажиллаж байх хугацаандаа 2017 оны ... тоот тушаалаар Т.М-ыг ажлаас чөлөөлжээ. Баян-Өлгий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолоор М.М-ыг ажилд эргүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговорт 9,418,380 төгрөгийг Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ЗДТГ-аас гаргуулахаар шийдвэрлэж, хохирлыг тус газраас олгожээ.

Баян-Өлгий аймгийн прокурорын газрын нэхэмжлэлтэй, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ЗДТГ-ын дарга асан М.Х-г хариуцагчаар татсан хэрэгт, нэхэмжлэгч нь түүний хууль бус шийдвэрийн улмаас төрд учирсан хохиролд 9,418,380 төгрөгийг нэхэмжилсэн.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл:

Аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг

ханган шийдвэрлэснийг Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 212/МА2020/00075 дугаартай шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Шүүхээс ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.5-д заасан үндэслэл тогтоогдохгүй байна гэж үзжээ.

Хариуцагч М.Х нь гүйцэтгэж байсан ажил үүргийн хувьд ямар үндэслэлээр, ямар хэмжээгээр хариуцлага хүлээх талаар ажил олгогчтой хэрхэн тохиролцсон нь тодорхойгүй, ажилтныг ажлаас чөлөөлсөнд тэрээр гэм буруутай болох нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдоогүй байхад шүүх ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасныг зөв тайлбарлан хэрэглээгүй. Ажилтныг үндэслэлгүй ажлаас чөлөөлснөөс байгууллагад учирсан хохирлыг ажил олгогч хариуцахаар шинээр батлагдсан Төрийн албаны тухай хуульд тусгасан байх ба дээрх хууль нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилж эхэлсэн тул хариуцагчийн үйлдэл тухайн хуулийн заалтад хамаарахгүй юм гэж дүгнэжээ.

Нэхэмжлэгчийн шаардах эрхийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 1-д “Прокурор ... шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж, Прокурорын тухай (Шинэчилсэн найруулга) хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж, 21 дүгээр зүйлийн (Шүүхэд төрийг төлөөлөх бүрэн эрх) 21.1.12-т “шүүхэд нэхэмжлэл, ... гаргах,” гэж, 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ... нэхэмжлэл, ... гаргана.” гэж, 41 дүгээр

зүйлийн 41.1-д “Төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл, ... гаргана.” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж тус тус хуульчилснаас үзвэл, Баян-Өлгий аймгийн Прокурорын газар нь төрийн байгууллага болох Баян-Өлгий аймаг дахь Санхүүгийн хяналт, аудитын газрын хүсэлтээр, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж, хариуцагч Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан М.Х-д холбогдуулж шүүхэд мэдүүлэх замаар нэхэмжлэл гаргах бүрэн эрхтэй байна¹⁹ гэж дүгнэсэн байна.

Дүн шинжилгээ:

Хариуцагч “Уг хэргийн нэхэмжлэгч нь аймгийн Прокурорын газар байх ёсгүй. Нэхэмжлэгч Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба шүүхэд нэхэмжлэл гаргах ёстой бөгөөд нэхэмжлэгч нь буруу гэж үзэж байна” гэж маргаж байна.

Прокурор Баян-Өлгий аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс хүсэлт ирүүлсэн тул ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар нэхэмжлэгчээр оролцох боломжтой гэж тайлбарласан. Прокурорын байгууллагын нэхэмжлэл гаргах эрхийн талаар шүүх ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1, Прокурорын байгууллагын тухай хуулийн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасныг хэрэглэж шаардах эрхтэй гэж дүгнэсэн байна.

Баян-Өлгий аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 18-01/83 дугаартай

¹⁹ Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.10.23-ны өдрийн 212/МА2020/00075 дугаар магадлал.

“Хохирол барагдуулах тухай” актыг гаргасан болон түүнийг нэхэмжлэгч хуулийн хүчин төгөлдөр акт биш гэж үзэж байгаа талаар дурдсан байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс Засгийн газрын 2015 оны 486 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.6-д “Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, ахлах байцаагчийн эрхийг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр олгоно” гэж зааснаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн аудитурууд улсын байцаагчийн эрхтэй байна. Тус эрхийн дагуу төлбөр тогтоосон акт гаргажээ.

Хариуцагч тус төлбөр тогтоосон актыг мэдсэн боловч гарын үсэг зурахаас татгалзсан тухай дурджээ. Үүнээс хариуцагч тус акттай холбогдуулан захиргааны болон шүүхийн журмаар гомдол нэхэмжлэл гаргаагүй байна. Төлбөр тогтоосон улсын байцаагчийн шийдвэр хүчинтэй байна. Иймд ИХШХШТХ-ийн 183 дугаар зүйлийн 183.1-д “Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үндэслэл шүүхийн шийдвэр болон шүүхээр баталгаажуулсан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна” гэж заасны дагуу гүйцэтгэх хуудас бичүүлж шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх боломжтой байна.

ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг тул улсын байцаагчийн өөрийн чиг үүргийг прокурорын байгууллага болон шүүхэд шилжүүлэх эрхгүй. Энэ тохиолдолд

прокурорын байгууллага улсын байцаагч төлбөр тогтоосон акт гаргасан атлаа түүндээ үндэслэж гүйцэтгэх хуудас бичүүлэхээр шүүхэд хандахын оронд шүүхэд нэхэмжлэл гаргуулахаар прокурорын байгууллагад гомдол гаргасныг хүлээж авсан нь үндэслэлгүй. Мөн тийнхүү хууль зөрчиж эрхээ шилжүүлсэн харилцаанд дүгнэлт өгөлгүйгээр прокурорыг нэхэмжлэх эрхтэй хэмээн дүгнэсэн нь үндэслэлгүй. Учир нь ЗЕХ-ийн 46 дугаар зүйлийн 46.2-т “Захиргааны актыг цуцлах, хүчингүй болгох, эрх бүхий байгууллагын шийдвэр гарах, эсхүл захиргааны актад заасан хугацаа дуусгавар болох, түүнчлэн бусад байдлаар биелэгдэх хүртэл тухайн захиргааны акт хүчин төгөлдөр байна” гэж зааснаар хүчин төгөлдөр байгаа “Төлбөр тогтоосон улсын байцаагчийн” шийдвэрт дурдсан асуудлыг нэхэмжлэлийг хүлээж авснаар дахин авч хэлэлцэх шийдвэрлэх үр дагавар хүрч байна. Зүй нь тухайн тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой асуудал тул ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.Шүүгч дараах тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана: 65.1.1-д *энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан хэргийн харьяалал зөрчсөн*” гэх нөхцөл хангагдсан байна. Иймд тус үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзаж шийдвэрлэх боломжтой байв.

Мөн хэргийг шийдвэрлэхдээ “Хариуцагч М.Х нь гүйцэтгэж байсан ажил үүргийн хувьд ямар үндэслэлээр, ямар хэмжээгээр хариуцлага хүлээх талаар ажил олгогчтой хэрхэн тохиролцсон нь тодорхойгүй, ажилтныг ажлаас чөлөөлсөнд тэрээр гэм буруутай болох нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдоогүй байхад шүүх ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасныг зөв тайлбарлан хэрэглээгүй байна. Хариуцагч М.Х нь сумын Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг бөгөөд тэрээр ажил үүргээ гүйцэтгэсний төлөө хариуцлага хүлээх үндэслэлгүй байна” гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байна.

Сумын ЗДТГ-ын дарга нь Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д “... нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал” гэж заасны дагуу төрийн захиргааны албан хаагч буюу төрийн жинхэнэ албан хаагч байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зүйн байдал, харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулах бөгөөд “хөдөлмөрийн гэрээ” байгуулж ажил олгогчид ажилладаг ажилтан биш байна. Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т “Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах”; Төрийн албаны тухай хууль (2017)-ийн 50 дугаар зүйлийн 50.1-д “Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ” гэж тус тус заасан. Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-д “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн тухай болон бусад хуулиар зохицуулна” гэж заасан. Иймд албан тушаалтны буруу шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлын нөхөн төлүүлэх харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулсан тул Хөдөлмөрийн тухай хуулийг хэрэглэх боломжгүй байна.

Жишээ 9: Увс аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 555 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж.

Нэхэмжлэлийн шаардлага:

1,802,432 төгрөгийг төрд хохирол учруулсан Ц.С-ээс гаргуулах тухай.

Хэргийн товч агуулга:

Иргэн Ц.С нь Увс аймгийн Өндөрхангай сумын Засаг даргаар ажиллаж байхдаа эрх мэдлээ хэтрүүлэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь заалтыг зөрчиж 2017 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн А/35 тоот захирамж гаргаж, 32,000,000 төгрөгийн төсөвт өртөгтэй наадмын талбай барих ажлыг тендер зохион байгуулахгүйгээр төсөвт өртгийг 4 хувааж иргэдийн бүлэгтэй шууд гэрээ байгуулан олгосон байх бөгөөд 2017 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн А/43 дугаартай захирамжаар байгуулсан ажлын хэсгийн хүлээн авсан тайлангаар нийт ажил (наадмын талбай)-г 91 хувийн гүйцэтгэлтэй хүлээн авсан. Уг наадмын талбайн зах зээлийн үнэ ханш, зарцуулсан материал, ажлын хөлсийг нийт 30,197,568 төгрөгөөр үнэлсэн бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангаас гарсан 32,000,000 төгрөгийн төсөвт ажлаас 1,802,432 төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байна.

Дээрх үйлдэлд прокуророос 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар зүйлийн 22.1.1-д зааснаар хэрэг бүртгэлтийн 193500165 дугаартай хэрэг нээн Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулсан. Хяналтын прокурор Х.Э нь хэрэг бүртгэлийн хэргийг хянаад 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.1-д заасан гэмт хэргийн

шинжгүй гэх үндэслэлээр 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 217 дугаартай тогтоолоор хааж шийдвэрлэжээ.

ИХШХШтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Прокурорын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцохоор нэхэмжлэл гаргасан. Ингэхдээ Ц.С-ийн төрд учруулсан хохирол 1,802,432 төгрөгийг гаргуулж өгнө үү гэжээ.

Шүүгчийн захирамжийн үндэслэл:

ИХШХШтХ-ийн 31 дүгээр зүйлд прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох журмыг тодорхойлсон. Хуулийн энэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд

1. Төрийн байгууллага иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцуулах хүсэлт гаргасан байх;
2. Прокурор оролцуулах хүсэлт нь төрийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд үндэслэгдсэн байх гэх нөхцөл байдлыг харгалзан үздэг.

Ийм нөхцөлд прокурор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын нэрийн өмнөөс оролцдог. Гэтэл төрийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзсэн төрийн байгууллагын хүсэлт хэргийн материалд авагдаагүй байна.

Иймд Увс аймгийн Прокурорын газрын нэхэмжлэлтэй, хариуцагч Ц.С-д холбогдох, 1,802,432 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан гэх үндэслэлээр ИХШХШтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.5-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.

Дүн шинжилгээ:

Шүүх энэ тохиолдолд прокурор ИХШХШтХ-д заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт хийсэн байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар прокурор төрийг төлөөлж оролцохдоо төрийн байгууллагын хүсэлтээр эсвэл өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хоёр үндсэн хэлбэрийг заажээ. Төрийн байгууллагын хүсэлтийн дагуу прокурор ажиллагаанд оролцох тухай ИХШХШтХ-д заасан бөгөөд шүүх заавал төрийн байгууллагын хүсэлтийг хэрэгт хавсаргасан байхыг шаардаж байна. Нөгөө талаар Прокурорын тухай хуульд прокурорын оролцоог хүсэлтийн үндсэн дээр мөн өөрийн санаачилгаар гэсэн хэлбэртэй байхаар хуульчилсан. Дээрх тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилж буй Прокурорын тухай хуульд зааснаар прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох бүрэн эрхийг олгосон байна. Учир нь прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд илүү нарийвчлан зохицуулсан хэм хэмжээг буюу Прокурорын тухай хуулийн зохицуулалтыг баримтлан оролцоно.

Энэ хуульд прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсвэл өөрийн санаачилгаар оролцох хэлбэрийг тусгасан байдаг. Гагцхүү төрийн ашиг сонирхол зөрчигдсөн бол хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн бол хүсэлтээс гадна өөрийн санаачилгаар оролцож болно гэдэг агуулга бий. Тэгэхээр шүүх нэхэмжлэлийг мөн үндэслэлээр хүлээж авахаас татгалзахаасаа өмнө нэхэмжлэлийн агуулгад дүгнэлт хийх шаардлагатай. Шүүхэд прокурорын оролцож буй маргааны төрөл, нэхэмжлэлийн агуулга нь “Төрийн ашиг сонирхолтой холбогдож байна уу? эсвэл Нийтийн ашиг сонирхолтой холбогдож байна уу?, мөн зөвхөн хүсэлтээр оролцох боломжтой маргаан уу? эсвэл Өөрийн санаачилгаар оролцох боломжтой маргаан уу?” гэдгийг тодруулах чухал ач холбогдолтой байсан.

Тодруулахад Сум хөгжүүлэх сангаас олгож байгаа мөнгөн

хөрөнгийн хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн өмчид хамаарахгүй, харин мөн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2-т “Орон нутгийн нийтийн зориулалттай өмчид тухайн орон нутгийн хүн амын нийтийн хэрэглээнд зориулсан эд хөрөнгө хамаарна” гэж заасан тул нийтийн ашиг сонирхолд хамаарна гэж үзэж шийдвэрлэх нь зүйтэй.

Иймд шүүх нэхэмжлэлийн агуулгын хүрээнд үзвэл “Төр, эсвэл нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан хохирлыг ялгахгүйгээр прокурорын хувьд нэхэмжлэгчийг төлөөлөх эрхгүй байсан” гэж ИХШХШТХ-ийг баримталж дүгнэлт гаргаж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан нь үндэслэлгүй гэж үзэхээр байна.

Жишээ 10: Увс аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 09 дүгээр 09-ний өдрийн 1378 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж.

Нэхэмжлэлийн шаардлага:

Төрд учирсан хохирол 7,897,450 төгрөгийг Увс аймгийн Наранбулаг сумын Засаг даргаар ажиллаж байсан Ч.Б-ээс гаргуулах тухай.

Хэргийн товч агуулга:

Увс аймгийн Засаг даргаар ажиллаж байсан Ч.Б нь 2017 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн Б/11 дугаартай тушаалаар тус сумын ЗДТГ-ын дарга П.Д-ийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, өөр ажлын байраар хангахыг Тамгын газрын даргад үүрэг болгож шийдвэрлэжээ. Гэвч Увс аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 639 дугаартай шүүгчийн захирамжаар П.Д-ийг үүрэгт ажилд нь

эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Улмаар Увс аймгийн Наранбулаг сумын Засаг дарга Ц.З нь Увс аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 639 дугаартай шүүгчийн захирамжийг үндэслэн П.Д-ийг үүрэгт ажилд нь эргүүлэн томилж, 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр 3,775,220 төгрөгийг мөн ЗДТГ-ын 2019 оны цалингийн сангаас тус тус олгож, холбогдох гүйлгээг Төрийн сангаар дамжуулан хийсэн байна. Мөн хариуцагч этгээд болох Ч.Б нь төрд учруулсан хохирлоо сайн дураар төлөөгүй тул ЗЕХ-ийн 103 дугаар зүйл, “Прокурорын тухай хууль”-ийн 41 дүгээр зүйлд тус тус заасныг үндэслэж, Увс аймгийн Наранбулаг сумын даргаар ажиллаж байсан Ч.Б-ээс 7,897,540 төгрөгийг гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Шүүгчийн захирамжийн үндэслэл:

ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д “Эрх зүйн маргааныг энэ хуулийн 13.2-т зааснаар арбитр шийдвэрлэсэн, талууд гэрээндээ үл маргах журмаар биелүүлэхээр тохиролцож нотариатаар гэрчлүүлсэн болон цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон актыг албадан гүйцэтгүүлэхээр бол уг цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт шүүхээр баталгаажсан байна.”, мөн хуулийн 184.2-т “Шийдвэрийг гүйцэтгүүлэхийг сонирхож байгаа тал цэргийн анги, байгууллагын захирагч (дарга)/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн зөвлөлийн шийдвэр, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудас,

улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа (оршин байгаа) харьяалах шүүхэд хүсэлт гаргана” гэж заажээ.

Дээрх хуульд зааснаар Увс аймгийн Санхүүгийн хяналт, Аудитын алба нь улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг баталгаажуулахаар төлбөр төлөгчийн оршин суугаа газрын шүүхэд нэхэмжлэл бус хүсэлт гаргаж, шүүх хүсэлтийг хянан үзэж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор шүүгчийн захирамжаар баталгаажуулахаар зохицуулжээ.

Иймд ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д заасан үндэслэлээр нэхэмжлэгч Увс аймгийн Прокурорын газрын 7,897,540 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийг ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.²⁰

Дүн шинжилгээ:

Шүүхээс прокурор төрийг төлөөлж төрд учруулсан хохирлыг гэм буруутай албан тушаалтантай холбогдуулан нэхэмжлэл гаргах эрхийн хүрээнд тодорхой дүгнэлт хийгээгүй байна.

Харин гагцхүү шүүхэд гаргасан нэхэмжлэлийг урьдчилан хянан шийдвэрлэх боломжтой буюу ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.3-д “Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал” нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана гэж заасны дагуу прокурорын гаргасан нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзжээ.

Түүнчлэн энэ хэргийг хянан шийдвэрлэхэд “Увс аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны улсын байцаагчийн төлбөр тогтоосон актын гүйцэтгэлийг шүүхээр албадан гүй-

²⁰ Увс аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021.09.09-ний өдрийн 1378 дугаартай захирамж.

цэтгүүлэх захирамж гаргуулах хүсэлтийн хүрээнд шийдвэрлүүлнэ” гэж тодорхойлсон боловч энэ хэрэгт тийм баримт байгаа талаар захирамжид дурдаагүй.

Хэдийгээр шүүгчийн захирамжид дурдаж буй байдлаар тус хохирлын талаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын улсын байцаагч төлбөр тогтоосон акт гаргасан бол үүнийг ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д заасны дагуу гүйцэтгэх хуудас бичүүлэх байдлаар гүйцэтгүүлэх боломжтой.

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт гараагүй тохиолдолд аймгийн тамгын газраас аудитад өөрийн байгууллагад төлбөр тогтоосон акт гаргуулах талаар чиглэл, заавар захиалга өгөх боломжгүй юм. Учир нь Төрийн аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтална” гэж заасан бөгөөд энэ талаар шийдвэр гаргуулах эрх хэмжээ аймгийн тамгын газарт байхгүй.

Иймд тус байгууллагыг “Өөрийн эрх, хэмжээ байхгүй асуудлаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжтой” гэж дүгнэсэн нь өрөөсгөл болжээ.

Тухайн тохиолдолд “Төлбөр тогтоосон улсын байцаагчийн шийдвэр” гараагүй тул ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага ИХ-ийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэж заасан өөрийн үндсэн чиг үүргийн хүрээнд байгууллага буруутай албан тушаалтнаар учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээг авахдаа Прокурорын тухай хууль болон ИХШХШТХ-д заасны дагуу прокурорын байгууллагын туслалцааг авсныг буруутгах үндэслэл байхгүй.

Дүгнэлт

Прокурор төрийн нэрийн өмнөөс төрд учирсан, нийтийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзэх нэхэмжлэгчээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон нийт 39 удаагийн тохиолдол буюу захирамж, шийдвэрийг судалгааны явцад судалж үзэхэд энэ судалгаанд хамааралтай 7 шийдвэр, 3 захирамж байгаа юм.

2002 оны ИХШХШТХ-ийн хүрээнд прокурорын оролцоог “Төрийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэдэг байдлаар зохицуулсан байна.

Прокурорын төрийг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхийн хүрээнд түгээмэл тулгардаг дараах асуулт байна:

1. Прокурорын шүүхэд нэхэмжлэл гаргаж хамгаалж буй ашиг сонирхол төрийн ашиг сонирхол уу? Нийтийн ашиг сонирхол уу?
2. Прокурор тус тохиолдолд өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргах эрхтэй юу? эсвэл төрийн байгууллагын хүсэлт шаардлагатай байгаа эсэх?
3. Прокурор төрийн байгууллагаас ирүүлсэн хүсэлт бүрийг хүлээн авч тус байгууллагын ашиг сонирхлыг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах ёстой эсэх?

Прокурор төрд учирсан хохирол болон нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаанд төлөөлөх эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах нарийвчилсан журам нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Прокурорын тухай хуульд байхгүй.

Гэхдээ төрийг төлөөлж оролцохдоо “төрийн байгууллагын хүсэлтээр эсвэл өөрийн санаачилгаар” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох үндсэн хоёр хэлбэрийг хуулиар заасан.

Төрийн байгууллагын хүсэлтийн дагуу прокурор ажиллагаанд оролцох тухай ИХШХШтХ-д заасан бөгөөд шүүх заавал төрийн байгууллагын хүсэлтийг хэрэгт хавсаргасан байхыг шаардаж байна (одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээний хувьд). Прокурорыг шүүхэд оролцуулах тухай хүсэлтийг гаргаж өгөөгүй шалтгааны улмаас нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тохиолдол мөн гарсан байна.

ИХШХШтХ болон Прокурорын тухай хуульд өөр өөрөөр тусгасан дээрх хоёр зөрүүтэй зохицуулалтыг уялдуулж ИХШХтХ-ийн дээрх заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулж, прокурорыг “нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд өөрийн санаачилгаар” хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжоор хангажээ. Энэ зохицуулалт 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөхөөр болсон.²¹

Энэ цаг хугацаанаас прокурор төрийн ашиг сонирхлыг хамгаалж байна уу эсхүл, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахаар хандаж байгаа юу гэдгээ нэхэмжлэлдээ тодорхой дурдах, шүүх тус ашиг сонирхлыг ялгах зүй ёсны шаардлага үүснэ.

Төр өргөн утгаараа өөрөө нийтийн эрх, ашиг сонирхлыг илэрхийлэгч тул энэ хоёр ашиг сонирхлыг ялгахад төдийлөн хялбар биш. Гэхдээ хохирол учирсан объектоор нь ямар ашиг сонирхолд хохирол учирсан бэ гэдгийг ялгаж болох юм. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 2-т заасан “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

²¹ Нийслэлийн Прокурорын газар, Авлига-урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд, судалгааны тайлан, УБ., 2021, 55 дахь тал.

2-т заасан төрийн нийтийн зориулалттай хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр прокурор өөрийн санаачилгаар нэхэмжлэл гаргах, бусад буюу тус хуулийн 5 дугаар зүйлд заасан хөрөнгүүдийн тухайд төрийн байгууллагын хүсэлтээр төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах боломжтой байдлаар ялгаж болохоор байна.

Мөн прокурор төрийн байгууллагаас хүсэлт ирүүлэх бүрд түүнд үндэслэн нэхэмжлэл гаргах боломж байхгүй. Учир нь ЗЕХ-ийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан зохицуулалтын хүрээнд тухайн байгууллага төрд учирсан хохирлыг шүүхэд хандан нэхэмжлэх чиг үүрэг өөрт нь олгосон байхад тус чиг үүргийг прокурорын байгууллагад шилжүүлэх, түүнийг прокурор гүйцэтгэх боломжгүй юм.

Тухайлбал: Улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт гаргасан боловч түүний гүйцэтгэлийг Төрийн аудитын тухай хууль, ЗЕХ-ийн Наймдугаар бүлэгт заасан захиргааны шийдвэр гүйцэтгэлийн журам, ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.2-т зааснаар хангуулах чиг үүрэгтэй атал прокурорын байгууллагад хандан түүгээр нэхэмжлэл гаргуулахаар чиг үүргээ шилжүүлж буй, түүнийг прокурор хүлээн авч буй буруу практик байна.

Мөн үүний нэг адил тохиолдол төрийн албаны зөвлөл (салбар зөвлөл) нь төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар халсан, чөлөөлсөн, шилжүүлсний улмаас төрд учирсан хохирлыг нэхэмжлүүлэхээр прокурорт хүсэлт гаргаж байгааг Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан чиг үүргээ хууль бусаар шилжүүлсэн гэж үзнэ.

Бусад тохиолдолд хуулиар нэхэмжлэх эрхийг олгоогүй, эсхүл “нөхөн төлүүлнэ” хэмээн үр дүн бий болгосон байх чиг

үүрэг ногдуулсан боловч тус үр дүнд шууд нэхэмжлэл гаргаж хэрэгжүүлэхээр хуульчлан заагаагүй бол прокурорт хүсэлт гарган шийдвэрлүүлэх боломж нээлттэй.

Прокурорын байгууллага болон шүүх дээрх байдлаар чиг үүргээ хууль зөрчин шилжүүлсэн эсэхэд дүгнэлт өгөлгүй шийдвэрлэсэн байна.

Хууль бусаар чиг үүргээ прокурорт шилжүүлсэн тохиолдолд ИХШХШтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.5-д “нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэж заасан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарах боломжтой байна.

2.4 ХОХИРОЛ ХҮЛЭЭСЭН БАЙГУУЛЛАГА ӨӨРӨӨ НЭХЭМЖИЛСЭН ТОХИОЛДОЛ

Жишээ 11: *Говь-Алтай аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11/ШШ2019/00361 дүгээр шийдвэр.*

Хэргийн товч агуулга:

Хариуцагч Зоонозын өвчин судлалын дарга С.Б нь 2017 онд С.Ц-г сахиул, галч албан тушаалаас чөлөөлсөн. Завхан аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, аймгийн Давж заалдах шатны шүүхийн магадлалаар ажилтан С.Ц-г ажил, албан тушаалд нь эргүүлэн томилж, ажилгүй байсан хугацааны цалин 4,650,000 төгрөгийг ханган шийдвэрлэж, учирсан хохирлыг тухайн байгууллагаас олгосон байна. Говь-Алтай аймгийн Төрийн аудитын газраас тус төвийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, удирдлагын буруутай шийдвэрээс болж, байгууллагын төсвийг хорогдуулсан гэж акт тавьсан байна.

Улмаар Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвөөс Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн дарга С.Б-д холбогдуулж байгууллагад учруулсан гэм хорын хохиролд 4,650,000 төгрөг гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан байна.

Шийдвэрийн агуулга:

Анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэж, шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болжээ.

Шийдвэрийн үндэслэл:

Нэхэмжлэгч Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь нэхэмжлэл гаргах эрхтэй болох нь хэргийн үйл баримтаар нотлогдоогүй, нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзэж шийдвэрлэсэн.

Хариуцагч С.Б нь Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн даргаар ажиллахдаа ажил олгогчийг төлөөлж шийдвэр гаргах эрхтэй этгээд мөн бөгөөд бүрэн эрхийнхээ хүрээнд ажилтныг ажлаас чөлөөлсөн тушаал нь эрх зүйн хувьд алдаатай байсныг шүүх тогтоож, нэхэмжлэгчийн ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх нөхөх олговрыг байгууллагаас гаргуулан ажилтанд олгохоор шийдвэрлэсэн нь С.Б-г хууль бус санаатай буюу болгоомжгүй үйлдлээр байгууллагад гэм хор учруулсан гэж үзэх үндэслэлгүй юм.

Ажил олгогч Говь-Алтай аймгийн Эрүүл мэндийн газар нь хариуцагч С.Б-тэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын талаар гэрээ байгуулснаар байгууллагад учруулсан эд хөрөнгийн хариуцлагыг хүлээлгэхээр ажил олгогч байгууллага шаардах эрхтэй ба энэ тохиолдолд хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад хамааралтай бөгөөд Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв тухайн байгууллагын төсөвт учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр

шаардах эрхтэй болох нь хэргийн үйл баримтаар нотлогдон тогтоогдохгүй байна²² гэж үзжээ.

Дүн шинжилгээ:

Энэ тохиолдолд Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь өөрийн байгууллагын даргаар ажиллаж байгаа С.Б-д холбогдуулан байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг гаргасан нь эрх зүйн хувьд сонирхолтой байна.

Байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд тус байгууллагын гаргаж буй нэхэмжлэлд гарын үсэг зурж нэхэмжлэл гаргана. Тус тохиолдолд байгууллагын итгэмжлэлгүй төлөөлөх эрх бүхий этгээд С.Б нь нэхэмжлэл гаргах эрхийг итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн байгууллагын хуулийн мэргэжилтэнд шилжүүлж олгосон. Харин тус хэргийн хариуцагч нь С.Б өөрөө юм. Өөрөөр хэлбэл, өөрөө өөрийнхөө эсрэг нэхэмжлэл гаргасан шинжтэй.

Албаны чиг үүргийн хүрээнд нэхэмжлэгч бөгөөд хувь хүнийхээ хувьд тус нэхэмжлэлийн хариуцагч байх боломжгүй. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно” гэж зааснаар хориглосон үйл ажиллагаа юм. Байгууллагын дарга С.Б нэхэмжлэлд гарын үсэг зурах эрхээ итгэмжлэлээр шилжүүлсэн хэдий ч тус итгэмжлэл түүнийг өөрийнхөө эсрэг нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлсэн гэж үзэхээс чөлөөлөхгүй. Учир нь байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд хэдийд ч итгэмжлэлээ хүчингүй болгох, нэхэмжлэлээс татгалзах, эвлэрэх зэрэг ИХШХШТХ-д заасан бүхий л эрхийг эдэлнэ.

²² Говь-Алтай аймаг дахь сум дундын ИХАШШ-ийн 2019.11.04-ний өдрийн 11/ШШ2019/00361 дүгээр шийдвэр.

Ийм атал Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д зааснаар эрх нь хязгаарлагдсан этгээдээс гаргасан нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн нь үндэслэлгүй.

Тус тохиолдолд ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1-д “Шүүгч дараах тохиолдолд захирамж гарган нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана: 65.1.5-д нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэж заасан зохицуулалтыг хэрэглэх боломжтой байсан гэж үзэж байна.

Байгууллагыг төлөөлж нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд тус байгууллагын дарга мөн боловч тус тохиолдолд өөрийнхөө эсрэг байгууллагаа төлөөлөх эрх хуулиар хязгаарлагдсан байна.

Төрийн аудитын газраас (хөндлөнгийн) санхүүгийн тайланд аудит хийж, удирдлагын буруутай шийдвэрээс болж, байгууллагын төсөв хохироосон гэж акт гарган, нөхөн төлүүлэх шаардлага тавьсныг биелүүлэх үүднээс хэлбэр төдий нэхэмжлэл гаргаж хариуцагчаар татагдах этгээд нь өөрийн доод шатны албан тушаалтнууддаа итгэмжлэл өгөх зэргээр төлөөлүүлэн өөрийн эсрэг оролцуулж байгаагаас тухайн маргаанд шударгаар мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэн оролцох боломж бага юм.

Хөдөлмөрийн харилцаа, төрийн албаны зарчимд ч тэр аль алинд нь удирдах удирдуулах, захирах захирагдах зарчим үйлчилдэг мөн тухайн байгууллагын удирдлага нь шийдвэр гаргах эрх мэдэл бүхий албан тушаалтан байдаг (ажилд авах, чөлөөлөх гэх зэрэг) учир түүний удирдлага дор ажиллаж байгаа ажилтан өөрөөс нь авсан итгэмжлэлийн үндсэн дээр удирдлагынхаа эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шударгаар байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах боломжгүй. Ийм ашиг сонирхлын зөрчил үүсэх тул ЗЕХ-ийн

103 дугаар зүйлийн 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан.

ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5 болон ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасан зохицуулалтууд захиргааны байгууллагын хохирлоо буруутай албан тушаалтнаас шаардах эрхийг тодорхойлсон заалт юм. Харин тус шаардах эрхийг хэн бодитоор хэрэгжүүлэх эрхтэй болохыг ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан.

ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.2-т “Шүүгч энэ хуулийн 65.1-д заасан захирамждаа уг нэхэмжлэлийг хэрхэн мэдүүлэх, эсхүл шүүх түүнийг хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж өгнө” гэж заасны дагуу шүүхээс тус нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзахдаа ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2-т заасан этгээд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг дурдах боломжтой байна.

Шүүх маргааныг шийдвэрлэсэн шийдлийн хувьд өмнө дурдаж байсанчлан төрийн албан хаагчийн буруу шийдвэрийн улмаас учруулсан гэм хорыг нөхөн төлүүлэх асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулиар нарийвчлан зохицуулсан атал Хөдөлмөрийн тухай хуулийн “Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ”-тэй холбогдох зохицуулалтыг авч хэрэглэсэн алдаа давтагдаж байгааг дурдъя.

Жишээ 12. *Багануур дүцргийн ИХАШШ-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 103/ШШ2021/00256 дугаар шийдвэр.*

Хэргийн товч агуулга:

Хариуцагч Б.Б, Ч.Б, Б.Т нар нь иргэн Ц.Г-г буруу оношилж, буруу эмчилсэн үйлдлийн улмаас эрүүл мэндэд нь 21,870,452

төгрөгийн хохирол учирсан гэж үзэн тус дүүргийн шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 103/ШШ2021/00072 дугаар шийдвэрээр Багануур дүүргийн эрүүл мэндийн төвөөс тус мөнгөн дүнг гаргуулахаар шийдвэрлэжээ. Улмаар Багануур дүүргийн Эрүүл мэндийн төвөөс ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасныг үндэслэн хууль бус үйлдлийн улмаас байгууллагад учирсан хохирлыг улсын тэмдэгтийн хураамжийн хамт 22,137,754 төгрөгийг гаргуулахаар нэхэмжлэл гаргажээ.

Шүүхийн шийдвэр:

Шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхийн шийдвэр гарснаар хуулийн хүчин төгөлдөр болжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл:

Анхан шатны шүүх нэхэмжлэгч байгууллагыг ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасны дагуу байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнуудаас шаардах эрхтэй гэж дүгнэсэн ч бодитоор тухайн байгууллагад хохирол учраагүй байхад хариуцагч нараас гэм хорын хохирол гаргуулахаар нэхэмжилсэн нь хуульд нийцэхгүй²³ гэж үзжээ. Учир нь нэхэмжлэгч байгууллага бодитоор шүүхийн шийдвэрийн дагуу Ц.Г-д төлбөр төлөөгүй болох нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон байна.

Дүн шинжилгээ:

Шүүх нэхэмжлэгчийг шаардах эрхтэй гэж дүгнэсэн бөгөөд тухайн тохиолдолд хохирол хүлээсэн гэх байгууллага өөрөө нэхэмжлэл гаргасан. Гэтэл тус байгууллагад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиг үүргийг ЗЕХ-ийн 103.2-т зааснаар дээд

²³ Багануур дүүргийн ИХАШШ-ийн 2021.07.26-ны өдрийн 103/ШШ2021/00256 дугаар шийдвэр.

шатны дотоод Аудитын нэгжид хариуцуулсан. Хуулиар шаардах эрхийг хэрэгжүүлэх эрхтэй субъектийг нэрлэн заасан атал шүүх тус агуулгаар дүгнэлт өгөлгүй нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болжээ.

ИХШХШТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.2-т “Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ” гэж заасан. Албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлсний улмаас төрийн байгууллагад учирсан хохирлыг шаардах эрх бүхий этгээд нь ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь хэсэгт зааснаар “Бусдын нэрийн өмнөөс төлөөлөн” нэхэмжлэл гаргаж буй нэхэмжлэгч байна.

Энэ тохиолдолд өөрийн нэрийн өмнөөс гаргасан нэхэмжлэлийг ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.5-д “Нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан” гэж заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах нөхцөл үүсэж байна.

Нэхэмжлэлийн шаардлага байгууллагын төсөвт учирсан хохирлыг гаргуулахаар чиглэгдэж байгаа тохиолдолд хохирол нь бодитоор учирсан эсэх асуудал юун түрүүнд хөндөгдөнө. Хуульд заасан өөрт учирсан хохирол түүний хэмжээ нь тухайн байгууллагын бусдад нөхөн төлсөн төлбөрийн дүнгээр тодорхойлогдоно.

Гэтэл шүүхийн шийдвэрээр хариуцагч нарын буруутай үйлдлийг тогтоож, нэхэмжлэгч байгууллагаас 21,870,452 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн ч тус мөнгөн дүнг байгууллагаас зохих этгээдэд шилжүүлээгүй атлаа байгууллагын төсөвт хохирол учирсан гэж үзэн, нэхэмжлэл гаргасан нь учир дутагдалтай болжээ.

Учир нь ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-д заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэж заасан бөгөөд байгууллагаас шаардах эрхийг хэрэгжүүлэхийн тулд “гэм хорыг арилгасан байх”, “үүний улмаас тус байгууллагад өөрт нь хохирол учирсан байх” урьдач нөхцөлүүдийг хангагдсан байхыг шаарджээ.

Шүүхээс хэргийн үйл баримтыг дүгнэсэн нь үндэслэл бүхий болсон боловч нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна. Учир нь энэ тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй байсан.

Жишээ 13: *Баянзүрх дүүргийн ИХАШШ-ийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №101/ШШ2020/00642 дугаар шийдвэр.*

Хэргийн товч агуулга:

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс хариуцагч Г.Ц-д холбогдуулан гаргасан нэхэмжлэлдээ ЦЕГ-ын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газраас цэргийн алба хаасны тэтгэврийн хувь тэнцүүлэн тогтоолгон авч байгаа иргэдийн цэргийн албанаас чөлөөлөгдсөн тушаалын үндэслэлийг шалгасан шалгалтаар Л.Г нь 2008 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс цэргийн алба хаасны хувь тэнцсэн тэтгэвэр тогтоолгохдоо цэргийн албанаас Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргын 1992 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар тушаалаар “ар гэрийн гачигдлаар” халагдсан байсныг “эрүүл мэндийн учир” халагдсан гэж хуурамч лавлагаа гарган тэтгэвэр тогтоох нөхцөлийг бүрдүүлэн, улмаар Нийгмийн

даатгалын санд 8,820,900 төгрөгийн хохирол учруулжээ.

БСЧДЭХАШШ-ийн шүүхийн шүүгчийн 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 2622 дугаар шүүхийн шүүгчийн захирамжид Г.Ц гэгч нь 9 иргэн (эдгээр иргэдийн нэг нь Л.Г)-д архивын хуурамч лавлагаа гарган өгч хууль бусаар цэргийн албан хаагчийн хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсгэсэн. Улмаар нийт 99,628,180 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт Г.Ц-г гэм буруутай гэж үзсэн боловч тус хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Сүхбаатар аймаг дахь Сум дундын ИХАШШ-д Л.Г-д холбогдуулан нэхэмжлэл гаргасан боловч тус шүүхийн 2017 оны 09 дүгээр 22-ны өдрийн 392 дугаартай шийдвэрээр “Нийгмийн даатгалын санд учруулсан гэм хор 8,820,900 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Иймд Г.Ц нь хууль бусаар архивын хуурамч лавлагаа гарган өгч, хууль бусаар цэргийн албан хаагчийн хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсгэсэн нийт 99,628,180 төгрөгийн хохирол учруулжээ. Уг хохирлоо нөхөн төлөхөө яллагдагч Г.Ц нь илэрхийлснийг нь захирамжид дурдаж, мөн улсад учирсан хохирлыг түүнээс нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсан.

Иймд Г.Ц-ээс Нийгмийн даатгалын санд учруулсан 8,820,900 төгрөгийг гаргуулж өгнө үү? гэж нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ тодорхойлжээ.

Шүүхийн шийдвэр:

Хариуцагч Г.Ц нь тухайн хохирлын мөнгийг хариуцах үндэслэлгүй гэж үзэж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл:

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1-02 тоот улсын байцаагчийн актаар Л.Г-ийн тэтгэвэр олголтыг түдгэлзүүлэн зогсоож, хуурамч бичиг баримт бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгосон шалтгаанаар тэтгэвэр тогтоолгосон хугацаанд олгосон 8,820,900 төгрөгийг буцаан гаргуулахаар акт тогтоож байжээ. Тус маргааныг Сүхбаатар аймаг дахь Сум дундын ИХАШШ 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 39 дугаартай шийдвэрээр хянан шийдвэрлэж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, зохигч тус шийдвэрт давж заалдах шатны журмаар гомдол гаргаагүй, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болжээ.

Нэхэмжлэгч өөрт учирсан хохирол гэж тодорхойлсон 8,820,900 төгрөгийг хариуцагчаас гаргуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж, Г.Ц-г иргэний хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулжээ.

Батлан хамгаалах төв архивын лавлагааг үндэслэн иргэн Л.Г-д өндөр насны тэтгэвэр олгосон нь хууль бус байсан асуудлаар түүний үр дагаврыг хариуцагч Г.Ц-д холбогдуулан гаргасан нь үндэслэлгүй байна. ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.1-д заасны дагуу “Ажиллагсад хөдөлмөрийн гэрээ буюу албан тушаалын дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх явцад гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээрээ бусдад учруулсан гэм хорын хариуцлагыг түүнийг ажиллуулж байгаа ажил олгогч хүлээнэ” гэсэн агуулга бүхий шууд хариуцагчид холбогдуулан нэхэмжилсэн эрх зүйн зохицуулалтын хувьд хариуцагчид үл хамаарах бөгөөд хариуцагч нь иргэний буюу эрх зүйн этгээдийнхээ хувьд уг хохирлыг нэхэмжлэгчийн өмнө хариуцах этгээд болохгүй.

Иймд нэхэмжлэгч нь хариуцагч Г.Ц Батлан хамгаалахын төв архивын орлогч даргын хувьд албан үүргээ гүйцэтгэх явцдаа

гаргасан шийдвэр нь Нийгмийн даатгалын санд 8,820,900 төгрөгийн хохирол учруулсан гэж үзэж, түүнийг иргэний нь хувиар хариуцагчаар тодорхойлж нэхэмжилснийг ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.2-т нийцээгүй үндэслэлээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.²⁴

Дүн шинжилгээ:

Шүүх нэхэмжлэлийг иргэний хэрэг хэмээн үзэж иргэний хэрэг үүсгэн, маргааныг хянан шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна. Учир нь “Нийгмийн даатгалын хэлтсийн 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1-02 тоот улсын байцаагчийн актаар Л.Г-д тэтгэвэр олгохыг түдгэлзүүлэн зогсоож, хуурамч бичиг баримт бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгосон шалтгаанаар тэтгэвэр тогтоолгосон хугацаанд олгосон 8,820,900 төгрөгийг буцаан гаргуулахаар акт тогтоож байжээ” гэж дурджээ. Нийгмийн даатгалын тухай хуулийн 25, 26-р зүйлд Нийгмийн даатгалын байцаагчийн эрх хэмжээг тодорхойлсон бөгөөд 25.1.3-д “Нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад” гэж заажээ. Нийгмийн даатгалын улсын байцаагчаас төлбөр тогтоосон акт тавьсан бөгөөд түүнтэй холбогдуулан төлбөр хариуцах этгээд маргаагүй бол тус актыг ЗЕХ-ийн 8-р зүйл болон ИХШХШтХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д зааснаар гүйцэтгүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл, тус төлбөр барагдуулах ажиллагаа шүүхийн журмаар явагдах иргэний эрх зүйн маргаан биш байна.

Харин тус тохиолдолд ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.2 заалт хэрэглэгдэхгүй. Учир нь тус хохирол нь төрийн байгууллагад бусдын гэм буруутай үйлдлийн улмаас шууд учирсан хохирол байна.

ЗЕХ-ийн 103.2, 103.3-д заасан нэхэмжлэх эрхийг тодорхойлсон байгууллагууд нь захиргааны байгууллагыг төлөөлж

²⁴ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.02.07-ны өдрийн №101/ШШ2020/00642 дугаар шийдвэр.

үйл ажиллагаа явуулж байсан өөрийн албан хаагчийн буруутай үйлдэл, шийдвэрийн улмаас учирсан хохирлыг байгууллага нөхөн төлж барагдуулах, үүний улмаас өөрийн байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаасаа гаргуулж авах тухай харилцаанд үйлчилнэ.

Харин төрийн болон аливаа байгууллагад учруулсан шууд гэм хорыг иргэний эрх зүйн ерөнхий зарчмаар тухайн төрийн байгууллага нэхэмжлэх эрх нээлттэй юм.

Үйл баримтын дагуу Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Г.Ц-г гэм буруутай болохыг тогтоосон. Иймд шүүхээр тогтоосон гэм буруугийн асуудлыг дахин шүүхээр нотлох шаардлагагүй тул гэм буруутай этгээдийг хариуцагчаар тогтоох нь зүйтэй.

Гэтэл шүүхээс нэхэмжлэгчийн шүүхэд хандах, гэм хорын улмаас учирсан хохирлоо буруутай этгээдээр арилгуулах боломжийг хязгаарлажээ. Шүүхээс нэхэмжлэгч өөрт учирсан хохирол гэж тодорхойлсон 8,820,900 төгрөгийг хариуцагчаас гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг гаргахдаа хариуцагч Г.Ц-г иргэний хувиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулжээ. Батлан хамгаалахын төв архивын лавлагааг үндэслэн иргэн Л.Г-д өндөр насны тэтгэвэр олгосон нь хууль бус байсан асуудлаар түүний үр дагаврыг хариуцагч Г.Ц-д холбогдуулан гаргасан нь үндэслэлгүй байна.

ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 болон ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д заасны дагуу төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтыг энэ тохиолдолд шүүх хэрэглэх боломжгүй. Учир нь уг хуулийн зохицуулалтын урьдчилсан нөхцөл төр бусдад учирсан хохирлыг барагдуулсан байхыг шаардах ба тус тохиолдолд төр өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх харилцаа юм.

Иймд ИХ-ийн 498 дугаар зүйлд заасан зохицуулалт бус тус хуулийн 497 дугаар зүйлд заасан гэм хорын ерөнхий зохицуулалтаар шаардах эрх үүссэн тул энэ зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой.

Нөгөө талаар нэхэмжлэгч шаардах эрх, шаардах эрхийн үндэслэлийг шүүхэд тайлбарлах, холбогдох нотлох баримтаа өгөх үүрэгтэй ба хууль зүйн зохицуулалтыг үнэн зөв тодорхойлох үүрэг хүлээхгүй учир нь шүүхээс хууль хэрэглээний хувьд шийдвэр гаргах үүрэг хүлээдэг тул нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлийн хүрээнд хэргийг шийдвэрлэнэ.

Гэтэл шүүх нэхэмжлэгчийг хууль зүйн шаардлага буруу тодорхойлсон 498 дугаар зүйлийн 1-д заасан харилцаа талуудын хооронд үүсээгүй гэдэг байдлаар тайлбарлаж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа нь төр өөрт учирсан хохирлыг нэхэмжлэх боломжгүй болгож байна.

ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасны дагуу албан тушаалтан, төрийн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас бусдад учирсан хохирлыг төр хариуцан арилгах тухай зохицуулалтыг шууд хэрэглэх боломжтой тул шүүхээс нэхэмжлэх эрх, түүний хууль зүйн үндэслэлийг буруу тодорхойлсон байна.

Дүгнэлт

Судалгаанд авагдсан хохирол хүлээсэн байгууллага өөрөө нэхэмжлэл гаргасан гурван тохиолдолд бүгдэд нь иргэний хэрэг үүсгэж хянан шийдвэрлэжээ. Үүгээр нэхэмжлэгч байгууллагыг нэхэмжлэл гаргах, шаардах эрхтэй гэж дүгнэсэн байна. Харин бүх тохиолдолд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Үүнээс дүгнэхэд аудитын байгууллага болон нэхэмжлэгч байгууллагын алдаатай нэхэмжлэл болон шүүхийн хууль хэрэглээний алдаа аль аль нь байна гэж үзлээ.

Говь-Алтай аймгийн Зооноз судлалын төвийн нэхэмжлэлтэй хэрэгт “аудитын шалгалт орж буруу халсны улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр акт тавьсан” гэж дурджээ. Тус тохиолдолд аудитын байгууллага төлбөр тогтоосон актаа хэрэгжүүлэх үүргийг өөрөө хүлээх атал тус актаар хохирлыг нөхөн төлөх буруутай этгээд болох байгууллагын дарга санаачлан шүүхэд хувь хүн өөрийнхөө эсрэг нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, улмаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хэд хэдэн хууль зөрчиж байна. Үүнд:

1. Хяналт шалгалтад хамрагдагч байгууллага “төлбөр тогтоосон акт”-ын биелэлтийг хангах арга хэмжээ авсан нь ЗЕХ-ийн “84.1. Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ: 84.1.1. Захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага; 84.1.2. Дээд шатны захиргааны байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийг анхан шатны захиргааны байгууллага; 84.1.3. Хуулиар тусгайлан эрх олгосон цагдаагийн болон мэргэжлийн байгууллага” гэж тус тус заасныг зөрчсөн;
2. Төрийн байгууллагыг төлөөлж өөрийнхөө эсрэг нэхэмжлэл гаргасан нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг

сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн;

3. Хууль зөрчсөн ашиг сонирхлын зөрчилтэй болон “улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт” гарсан атал түүнийг гүйцэтгэх эрх хэмжээгүй байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг шүүх хүлээн авч шийдвэрлэсэн.

Мөн төрийн байгууллагаас нэхэмжлэл гаргахдаа албан хаагчийн буруутай шийдвэр үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг өөрийн байгууллагаас тэргүүн ээлжид нөхөн төлөх үүргээ биелүүлээгүй буюу өөрийн байгууллагад нь хохирол учраагүй байтал гэм хорыг нэхэмжилсэн нь үндэслэлгүй. Тухайн тохиолдолд нэхэмжлэл гаргаж буй байгууллага мэргэжил, арга зүйн алдаа гаргасан гэж үзэхээр байна.

Иймд төрийн байгууллагыг өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх талаар мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах шаардлагатай байгаа нь тодорхой байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төрийн байгууллагын албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх харилцаанд шүүхээс захирамж, шийдвэртээ нэхэмжлэгчийн шаардах эрхийн талаар дийлэнх тохиолдолд тухайлан дүгнээгүй байна. Иймээс нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэснийг нэхэмжлэл гаргах эрхтэй гэж тодорхойлсон хэмээн үзэж дүгнэлээ.

Дүн шинжилгээнд авагдсан шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэрүүдэд дурдаж байгаа үйл баримт болон шүүхийн хууль хэрэглээ, түүний үндэслэлүүдээс нэгтгэн дүгнэхэд төрийн байгууллага албан тушаалтны буруутай шийдвэр үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр нөхөн төлж, өөрт үүссэн хохирлыг буруутай этгээдээс нөхөн төлүүлэх харилцаанд хохирол хүлээсэн байгууллага, аудитын байгууллага, прокурор, Төрийн албаны зөвлөл, шүүх нь хууль хэрэглээний нэгдсэн ойлголтод хүрээгүй байх тул хууль хэрэглээний болон процессын алдаа гарсаар байна.

Энэ нь дараах шалтгаан нөхцөлөөс үүдсэн байна.

Нэг. Хууль тогтоомжийн асуудал:

Хууль эрх зүйн зохицуулалтын холбогдох заалтыг тодорхой бус, холбогдох хуулийн уялдаа холбоо бүдэг, олон өөр байдлаар ойлгогдож байгаагаас төрд учруулсан хохирлыг

нөхөн төлүүлэх нэхэмжлэгчийн шаардах эрхийг тодорхойлоход төвөгтэй нөхцөл үүсэж байна.

ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар” гэж хоёрдмол утгатай зохицуулснаас болж, яг тухайн нэхэмжлэлд шаардах эрхийг тодорхойлоход дараах асуудал үүсэж байна:

1. Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр хэмээн хамтатган томьёолсон тул “төрийн ашиг сонирхол зөрчигдсөн”, “нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн” аль ч тохиолдолд шүүхээс төрийн байгууллагын хүсэлт шаардаж байна. Төрийн байгууллагын (төрийн) ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд төрийн байгууллагаас прокурорт хүсэлт гаргаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно. Гэтэл нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд тухайлбал “төрийн нийтийн зориулалттай өмч болох ан амьтан хууль бусаар агнах” зэрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон нөхцөлд буруутай этгээдээс нийтийн ашиг сонирхлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэхдээ төрийн байгууллагаас заавал хүсэлт авах (ямар төрийн байгууллага хүсэлт гаргах нь тодорхойгүй) шаардлага үүсэж, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах боломжгүй болж байна.
2. Хуульд “эсхүл өөрийн санаачилгаар” гэж зохицуулсан хэдий ч ямар тохиолдолд өөрийн санаачилгаар оролцуулах талаар нарийвчлан зохицуулаагүй. Тус асуудлыг “Прокурорын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлт, эсхүл

өөрийн санаачилгаар захиргааны болон иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор, эсхүл гуравдагч этгээдээр оролцоно” гэж зохицуулсан бөгөөд төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр оролцох, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн бол төрийн байгууллагын хүсэлт болон өөрийн санаачилгаар оролцох боломжтой байдлаар зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, төрийн ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд өөрийн санаачилгаар оролцохгүй байдлаар зохицуулсан байна. Гэтэл тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д “Прокурор өөрийн санаачилгаар төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах ажиллагааг хэрэгжүүлж байгаа тохиолдолд итгэмжлэлгүйгээр оролцоно” гэж заасан нь буцаад төрийн ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд өөрийн санаачилгаар оролцож болох мэтээр зөрчилдсөн зохицуулалт хийжээ.

Хоёр. Хууль хэрэглээний асуудал:

Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардаж буй байгууллагууд хууль хэрэгжүүлэхдээ дараах нийтлэг асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1. Хохирол нөхөн төлүүлэх үүрэг хүлээсэн аудитын байгууллага хяналт шалгалт явуулж, төлбөр тогтоосон улсын байцаагчийн акт тавьсан боловч тус төлбөрийг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах аргыг сонгож байна. Гэтэл “Төрийн аудитын тухай хууль”-д заасан болон ЗЕХ-ийн Наймдугаар бүлэгт зааснаар захиргааны шийдвэрийг биелүүлэх аргуудаас сонгон актын биелэлтийг хангуулах эсвэл ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-д зааснаар улсын байцаагчийн төлбөр тогтоосон актад үндэслэн шүүхээр гүйцэтгэх хуудас бичүүлэх байдлаар хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой. Тус

аргыг сонгоогүй улмаас аудитын байгууллага нэгэнт хүчин төгөлдөр актын биелэлтийг хангуулж, чиг үүргээ хэрэгжүүлэх хялбаршуулсан боломжийг өөрсдөө үгүйсгэж байна. Үүний үр дүнд нь цаг хугацаа алдах, хүндрэл чирэгдэл үүсэх, актаар шийдвэрлэсэн асуудал тус бүрийг нягтлан шалгах, шүүхийн ачааллыг бий болгох зэрэг сөрөг үр дагавар гарч байна.

2. Хохирол нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх чиг үүрэг бүхий байгууллагууд тийнхүү өөрийн нэхэмжлэх чиг үүргийг ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасныг ашиглаж прокурорын байгууллагад шилжүүлэх, Тухайн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг прокурорын байгууллага төлөөлөн хэрэгжүүлэх тохиолдол нийтлэг байна. ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар чиг үүргийг шилжүүлэхийг хориглоно. Гэтэл прокурорын байгууллага төрийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн л бол төрийн ашиг сонирхлыг хамгаалж, тус байгууллагын өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж буй буруу жишиг тогтоосон. Үүнд хуулиар тус байгууллага хохирол нөхөн төлүүлэх үүрэг хүлээсэн эсвэл нэхэмжлэх үүрэг хүлээсэн эсэхийг ялгаатай авч үзэхэд ихээхэн анхаарах ёстой. Учир нь хохирол нөхөн төлүүлэх үүргийг хуулиар хүлээсэн бол тус хохирлыг нөхөн төлүүлэх аргаа сонгох боломжийг хуулиар олгосон гэж үзнэ. Харин “шүүхийн журмаар нэхэмжлэх”, “төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах” зэргээр шүүхэд нэхэмжлэл гаргах чиг үүргийг хуулиар тодорхойлсон бол хуулиар хүлээсэн чиг үүргээ прокурорт шилжүүлсэн гэж үзнэ. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасан тул төрийн жинхэнэ албан хаагчийг буруу халсан, чөлөөлсөн шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг зөвхөн Төрийн албаны зөвлөл нэхэмжлэхээр байна.

3. Албан хаагчийн буруутай шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн төрийн байгууллага өөрөө нэхэмжлэл гарган шийдвэрлүүлжээ. ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1 болон ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5-д зааснаар “хохирол хүлээсэн байгууллага буруутай албан хаагчаасаа учирсан хохирлыг нөхөн төлүүлэх” эрхийг тодорхойлсон бол тус эрхийг хэрэгжүүлэх субъектийг тухайн хохирол хүлээсэн захиргааны байгууллагын дээд шатны дотоод аудитын нэгж гэж тодорхойлжээ. Хэрэв тийм байгууллага байхгүй бол төрийн аудитын төв байгууллага тус чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

Шүүх энэ төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний дараах асуудал үүссэн байна. Үүнд:

1. Буруутай албан тушаалтнаас байгууллагад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр гаргасан улсын байцаагчийн актад “гүйцэтгэх хуудас” бичүүлэхээр гаргасан хүсэлтийг “шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх гүйцэтгэх хуудас”-тай адилтган шийдвэрлэсэн.
2. Улсын байцаагчийн төлбөр тогтоосон хүчин төгөлдөр актын хэрэгжилтийг хангахаар шүүхэд хандаж улсын байцаагч (аудит)-аас гаргасан нэхэмжлэлийг иргэний маргаан хэмээн хүлээн авч шийдвэрлэсэн. Аудитын байгууллагын төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр тогтсон актыг хэрхэн баталгаажуулах талаар шүүхүүд өөр өөр ойлголттой байна. Шүүх зарим тохиолдолд ИХПХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1, 184.2-т заасан заалтыг удирдлага болгож, хүсэлтээр актыг шууд албадан гүйцэтгүүлэх нь зүйтэй гэсэн байдлаар, зарим тохиолдолд буруутай албан тушаалтанд холбогдуулж, шүүхэд нэхэмжлэл гаргах нь зүйтэй гэсэн хоёр өөр байр суурьтай байгаа нь энэ талаарх харилцаанд ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

3. Улсын байцаагчийн актыг албадан гүйцэтгүүлэх тухай ИХШХШТХ-ийн 184 дүгээр зүйлийн 184.1-ийн дагуу гүйцэтгэх хуудас бичихээс үндэслэлгүй татгалзаж буй нь Аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсан шийдэл болж байна.
4. Төрийн албаны зөвлөлийг төрд учирсан хохирлыг буруутай этгээдээс нөхөн төлүүлэхээр шаардах эрхийг 2017 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулиар анх олж авсан мэтээр дүгнэлт хийсэн байна. Тус тохиолдолд 2002 оны Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2-т заасан “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах” гэж зааснаар төрийн албан хаагчийн төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах эрх Төрийн албаны зөвлөлд байсныг харгалзан үзээгүй байна.
5. Прокурорын гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ прокурор төр болон нийтийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөн ИХХША-д оролцохдоо бүх тохиолдолд төрийн байгууллагын хүсэлтэд үндэслэн уг ажиллагааг эхлүүлнэ гэх нийтлэг ойлголттой байна. Тухайн тохиолдолд “Прокурорын тухай хууль”-ийн 20.1-д зааснаар төрийн ашиг сонирхлыг хамгаалж буй бол төрийн байгууллагын хүсэлтээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалж буй бол санаачилгаараа болон хүсэлтээр оролцох зохицуулалтыг харгалзан үзэж шийдвэрлээгүй байна. Мөн шүүх прокурорын гаргаж буй нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ тус тохиолдолд прокурор нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр төлөөлөн хамгаалж нэхэмжилж байна уу? эсвэл, төрийн ашиг сонирхлыг хамгаалахаар нэхэмжлэл гаргаж байна уу? гэдгийг ялгаж дүгнээгүй “төр, нийтийн ашиг сонирхол” гэж

нэгдсэн байдлаар хэрэглэх нь нийтлэг байна.

6. Хууль зөрчсөн төлөөлөл бүхий нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ИХШХШтХ-аас өөр хуулийг хэрэглэхгүй байгаа нь нийтлэг байна. Тухайлбал, төрийн байгууллагыг төлөөлж өөрийнхөө эсрэг нэхэмжлэл гаргасан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтад “Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно” гэж заасныг зөрчиж өөрийнхөө эсрэг гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэсэн. Мөн тухайн байгууллага төрд учирсан хохирлыг шүүхэд хандан нэхэмжлэх чиг үүрэг өөрт нь олгосон байхад тус чиг үүргийг прокурорын байгууллагад шилжүүлж, ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэжээ.
7. Шүүх тухайн захиргааны байгууллагын “шаардах эрх”, “шүүхэд нэхэмжлэл гаргах чиг үүрэг буюу эрх”-ийг ялгамжтай авч үзэж, дүгнээгүйгээс төрийн байгууллагын тус хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг салбарын хуулиар өөр байгууллага албан тушаалтанд ногдуулсан атал тус этгээдээс бус өөр этгээдээс гаргасан нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн нийтлэг асуудал байна.
8. Мөн ЗЕХ-ийн 103 дугаар зүйлийн 103.1, ИХ-ийн 498 дугаар зүйлийн 498.5, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2 заалт болон бусад хууль тогтоомжоор нарийвчлан заасан төрийн албан хаагчийн

буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх харилцаанд Хөдөлмөрийн тухай хуулийн “хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчийн эд хөрөнгийн бүрэн болон зарим хариуцлага”-ын зохицуулалтыг авч хэрэглэсэн нь ИХ-ийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж заасан зарчмыг зөрчиж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Эрх зүйн баримт бичиг

1. Гаалийн тухай хууль, 2008
2. Захиргааны ерөнхий хууль, 2016
3. Иргэний хууль, 2002
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002
5. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
6. Нийгмийн халамжийн тухай хууль, 2012
7. Прокурорын тухай хууль, 2017
8. Төрийн албаны тухай хууль, 2002, 2017
9. Төрийн аудитын тухай хууль, 2020
10. Төсвийн тухай хууль, 2011
11. Хөдөлмөрийн тухай хууль, 1999

Б. Ном, товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Б.Улсболд, “Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь”, УБ., 2020
2. Нийслэлийн Прокурорын газар, “Авлига урьдчилан сэргийлэх, шалгах, хянан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт онол практикийн бага хурлын илтгэлүүд, судалгааны тайлан, УБ., 2021
3. Хууль зүйн үндэсний хүрээлэн “Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдлээс учирсан гэм хорыг арилгаж байгаа байдал” судалгааны тайлан, УБ., 2009
4. Шүүхийн ерөнхий зөвлөл, “Шүүн таслах ажиллагааны тайлан” УБ., 2018-2020

В. Цахим хуудас

1. www.shuukh.mn
2. www.legalinfo.mn
3. www.supremecourt.mn
4. www.judcouncil.mn
5. www.legaldata.mn

Д. Шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж

1. Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 129/ШШ2022/00089 дүгээр шийдвэр,
2. Архангай аймгийн Сум дундын ИХАШШ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 129/ШЗ2022/00418 дугаар хүсэлт шийдвэрлэх тухай шүүгчийн захирамж
3. Багануур дүүргийн ИХАШШ-ийн 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 103/ШШ2021/00256 дугаар шийдвэр
4. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн №101/ШШ2020/00642 дугаар шийдвэр
5. Баян-Өлгий аймгийн Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 212/МА2020/00075 дугаар магадлал
6. БЗДИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 101/ШШ2019/03027 дугаар шүүхийн шийдвэр
7. Говь-Алтай аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11/ШШ2019/00361 дүгээр шийдвэр
8. Говь-Алтай аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн 2021 оны .05 дугаар сарын .20-ны өдрийн 133/ШШ2021/00196 дугаар шийдвэр,
9. Дархан-Уул аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 2097 дугаартай шүүгчийн захирамж
10. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 209 дугаар магадлал

11. Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар магадлал
12. Сүхбаатар аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний.01.04-ний өдрийн 147/ШЗ2022/00045 дугаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж
13. Увс аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дугаар 555 дугаартай захирамж
14. Увс аймаг дахь Сум дундын ИХАШШ-ийн шүүгчийн 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн дугаар 1378 дугаартай захирамж
15. УДШ-ийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2021/01246 дугаар тогтоол
16. ХУДИХАШШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02620 дугаартай шийдвэр

2

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



ГОМБОДОРЖИЙН ЦЭЦГЭЭ

"Хуулийн байшин" ТББ-ын тэргүүн, судлаач.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. Хууль зүйн магистр зэрэгтэй.

Хууль зүйн дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар ажилласан туршлагатай.



УМААРАНГИЙН МӨНХЦЭЦЭГ

ХЗДХЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн.

МУИС-ийн Худалдааны их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2008-2020 онд Улсын бүртгэлийн байгууллагад ажиллаж байсан туршлагатай.

Судлаач:

Г.Цэцгээ

У.Мөнхцэцэг

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	103
УДИРТГАЛ	104
НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР СУДАЛГАА	109
1.1. Өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхийг даалгасан шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ	112
1.2. Өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.....	137
1.3 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан бичгийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлсэн нь буруу гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ.....	169
1.4. Нэгдсэн дүн шинжилгээ	172
НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ	185
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	189

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
МУШТХ	Монгол Улсын шүүхийн тухай хууль
НЗХАШШ	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх
НШШГА	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБЕХ	Улсын бүртгэлийн ерөнхий хууль
УДШ	Улсын дээд шүүх
ҮХЭХБтХ	Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭХЭУБТХ	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль
ЭХӨЭТХЭХБЭУБТХ	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

УДИРТГАЛ

Өмчлөх эрх нь хүний жам ёсны, халдашгүй негатив эрх учраас түүнд өөрийн гэсэн хамгаалалт байх ёстойг эрх зүйн судлаачид, онолчид цаг ямагт сануулсаар иржээ.¹ Өмчлөгч нь өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэгжүүлэх, өөрийн өмчлөлийн эд хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах, бусад этгээдийн нөлөөллийг үгүйсгэх эрхтэй билээ. Өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэснээр албан ёсны болгож, хууль ёсоор хамгаалагдах нөхцөл бүрдэнэ. Өмчлөх эрх албан ёсны болсноор өмчлөгч өмчлөх эрхээ хэрэгжүүлж, өмчлөлийн зүйлийнхээ үр ашгийг хүртэх боломжтой болох юм.

Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах² эрхтэй. Түүнчлэн ИХ-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно.³ Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүсэх учраас улсын бүртгэлд бүртгүүлээгүй бол тухайн эзэмшигчид өмчлөх эрх үүсэхгүй.⁴ Гэхдээ үүнийг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэснээр өмчлөх

¹ Г.Агар-Эрдэнэ, “Хувийн өмчийн онол”. УБ., 2009 он, 139 дэх тал.

² Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл.

³ “Иргэний хууль”. 2002 он. 110 дугаар зүйлийн 110.1 дэх заалт

⁴ Ж.Оюунтунгалаг “Иргэний эрх зүй I”. Ерөнхий анги УБ., 2020 он. 153 дахь тал.

эрх олгож байгаа мэт ойлгож болохгүй бөгөөд хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангаж, өөрөөр хэлбэл үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой аливаа эрх болон түүний үнэ цэнийг албан ёсны бүртгэлээр тодорхойлно гэсэн үг юм.

Улсын бүртгэлийн үүднээс анхдагч аргаар өмчлөх эрх үүсэх тохиолдлуудад: 1/. Өмчлөгчийн өөрийн хөрөнгөөр шинээр барьж босгосон (өөрөө болон бусдаар гүйцэтгүүлсэн) үл хөдлөх хөрөнгө; 2/. Өмнө нь өмчлөгчтэй байсан боловч өмнөх өмчлөгч нь өмчлөх эрхээсээ татгалзсан, өмчлөх эрхээ алдсан, эсвэл өмчлөгч нь тодорхойгүй, түүнийг олж тогтоох боломжгүй хөрөнгийг анхдагч аргаар өмчилж болно. Харин үүсмэл аргаар өмчлөх эрх үүсэх тохиолдлуудад: 1/. Өмнөх өмчлөгч нь өөрийн хүсэл зоригийн дагуу гэрээ хэлцэл хийж өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх тохиолдлууд орно. 2/. Өмнөх өмчлөгчийн хүсэл зоригоос үл хамааран эд хөрөнгө өмчлөх эрхийг шилжүүлэх тохиолдол бас байж болно. Жишээ нь: Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр эд хөрөнгө хураан авах, албадан дуудлага худалдаагаар худалдах гэх мэт.

“Иргэний хууль (1994 он)”-д “Үл хөдлөх хөрөнгийг түүний байгаа газарт орших төрийн эрх бүхий байгууллага хуульд заасны дагуу бүртгэнэ⁵” гэсэн заалт орж байсан бол хожим нь “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль” батлагдсанаар манай улсад үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг 1997 оноос хойш улсын бүртгэлд бүртгэж иржээ. “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай (1997 он)”, “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай (2003 он)”, “Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2009 он)”-д улсын бүртгэлд бүртгэх эрхийн төрлийг тодорхойлохдоо өмчлөх эрх ба өмчлөх эрхтэй холбоотой бусад эрх гэсэн агуулгыг илэрхийлсэн байдаг хэдий ч эдгээр хуульд үл хөдлөх эд хөрөнгө гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусдын

⁵ “Иргэний хууль (1994 он)”-ийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт.

өмчлөлд шилжих, эрх бүхий байгууллагын шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх тохиолдлуудыг улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл хэмээн зохицуулсан байдаг.

Харин шинэчлэн найруулсан “Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018 он)” болон “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018 он)”-д эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэг төрөл нь эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл⁶ байх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх,⁷ үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх⁸ -ээр зохицуулсан байна.

УБЕХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.4.2-т зааснаар улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай шийдвэр гаргах эрх бүхий этгээд нь улсын бүртгэгч юм. Ийнхүү эрх бүхий этгээд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхээ Улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлтийг хуульд заагаагүй үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, хүлээн авсан ч Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж буцаах зэргээр жинхэнэ (шударга) өмчлөгчийн эрхэд халдах, хохироох явдал цөөнгүй гаргадаг. Түүнчлэн улсын бүртгэгч нар ижил асуудлаар өөр өөр шаардлага тавьдаг, ялгаатай баримт бичиг шаарддаг гэх иргэдийн гомдол санал ч цөөнгүй байдаг.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик баримтаас⁹ харахад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан мэдүүлэг хүсэлтийн нэлээд хувийг бүртгэхээс татгалзан буцаадаг байна. Тухайлбал:


⁶ “Улсын бүртгэлийн ерөнхий хууль (2018 он)”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт.

⁷ “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018 он)”-ийн 10 дугаар зүйл.

⁸ “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018 он)”-ийн 11 дүгээр зүйл.

⁹ <https://burtgel.gov.mn/> УБЕГ-ын жил тутмын статистик мэдээ.

График 1. Хүлээн авсан, бүртгэсэн, буцаасан мэдүүлгийн харьцуулалт



Дээрх тоон үзүүлэлтээс харахад жилд хүлээн авсан мэдүүлгийн дунджаар 3.8 хувийг Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзан буцаасан байна. Үүнээс гадна улсын бүртгэлийн байгууллагад хандсан мэдүүлэг хүсэлтийг албан ёсоор хүлээн авахаас татгалзах явдал нэлээд байх боловч энэ тоо улсын бүртгэлийн байгууллагаас гардаггүй байна. Нэгэнт улсын бүртгэлийн байгууллага бүртгэхээс татгалзсан шийдвэрийг албан ёсоор гаргаагүй (хүлээж аваагүй учраас бүртгэхээс татгалзсан шийдвэр албан ёсоор гардаггүй) учраас энэ тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагын эс үйлдэлд гомдол гаргаж эрхээ хамгаалж чадахгүй байна гэж үзэхээр байна.

Ийнхүү үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд учирч байгаа бэрхшээл, түүний учир шалтгааныг тодруулах, мөн шүүх өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэсэн байдлыг судлан шинжлэх нь өмчлөгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн байгууллага, ажилтан хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж байгаа захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шинжилж дүгнэхдээ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн www.shuukh.mn хуудсанд байршуулсан 2016-2020 онд эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлд буруу бүртгэсэн үйлдэл, бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүйтэй холбоотой 200 орчим хэрэг маргааныг захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн 347 шийдвэрийг судлав.

Тэдгээрээс захиалгаар бариулсан болон бусад орон сууцны өмчлөх эрхийг бүртгүүлэхтэй холбоотой, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд өмчлөх эрхээ бүртгүүлэхийг шаардсан нэхэмжлэлийн шаардлага бүхий нийт 108 шийдвэрийг сонгож, түүнээс 10 захиргааны хэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан бичгийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлсэн бүртгэлийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий 1 захиргааны хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг сонгон авч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс 2015 онд боловсруулсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу шинжилж дүгнэлээ.

Шүүхийн шинжилж дүгнэх шийдвэрийг сонгохдоо

- Харьцангуй олон тохиолддог;
- Хууль хэрэглээнд жишиг тогтоохуйц ач холбогдол бүхий;
- Маргаан үүссэн нөхцөл байдал ижил буюу ойролцоо байх;
- Төсөөтэй шаардлага бүхий нэхэмжлэлийг ялгамжтай шийдвэрлэсэн тохиолдол;
- Хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн буюу шүүхийн шийдвэр хуулийн хувьд хүчин төгөлдөр болсон байх;
- Давж заалдах, хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн байх зэрэг шалгуурыг баримталлаа.

НЭГ. ШҮҮХИЙН ПРАКТИК

Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой хэрэг маргааныг “1/. Өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүйтэй холбоотой, 2/. Улсын бүртгэлд хууль, журам зөрчиж бүртгэсэн үйлдэлтэй холбоотой” гэж ангилж болох юм.

Өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүйтэй холбоотой маргааны агуулгыг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Орон сууц захиалгаар бариулах гэрээгээр орон сууц авсан өмчлөгчийн эрхийг бүртгэхтэй холбоотой маргаан: Үүнийг дотор нь: 1/. Орон сууцны барилгыг гүйцэтгэгч компани дуусаагүй барилгаар өөрийн өмчлөлд бүртгүүлж, барьцаанд тавьсан, эрх бүхий этгээдийн шийдвэрээр тухайн барилгын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг хориглосны улмаас бүртгэхээс татгалзсан; 2/. Барилгын гүйцэтгэгч компани ашиглалтад орсон барилгыг захиалагч нарын өмчлөлд бүртгүүлэхээр улсын бүртгэлийн байгууллагад материал ирүүлэхдээ дутуу, зөрүүтэй ирүүлсэн гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзсан; 3/. Бусад гэж ангилж болохоор байна.
- Өмчлөх эрхийг гэрээ, хэлцлээр шилжүүлж бүртгүүлэх тохиолдолд тухайн үл хөдлөх хөрөнгө барьцаалагдсан


байсантай холбоотой маргаан;

- Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиар байхгүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзсан маргаан;
- Бусад.

Улсын бүртгэлд хууль, журам зөрчиж бүртгэсэн гэх үндэслэлээр улсын бүртгэлийг хүчингүй болгуулахтай холбоотой маргааны агуулга нь:

- Өмч хувьчлалын маргаан;
- Газрын маргаан;
- Өв залгамжлалын маргаан;
- Хамтран өмчлөх эрхийн маргаан;
- Орон сууцны дундын өмчлөлийн талбайг дангаар өмчилж бүртгүүлсэн;
- Үл хөдлөх хөрөнгийг давхардуулан бүртгэсэн гэх мэт шалтгаантай байна.

Өмчлөх эрхийн улсын бүртгэлтэй холбоотой нийт 347 шүүхийн шийдвэрийг судлан үзэхэд, “дуусаагүй барилга байхад барилгын компанийн өмчлөлд бүртгүүлж, барьцаанд тавьсан”, “барьцааны гэрээ бүртгэлтэй”, “эрх бүхий байгууллагаас эрхийг түдгэлзүүлсэн” гэх үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсантай холбоотой маргааныг шийдвэрлэсэн 108 шүүхийн шийдвэр байна. Үүнээс “МК” ХХК-ийн барьсан барилгатай холбоотой 36 хэрэг маргааны 63 шийдвэр, “М” ХХК-ийн барьсан барилгатай холбоотой 8 хэрэг маргааны 19 шийдвэр, “Г вилл” хотхоны барилгатай холбоотой 8 хэрэг маргааны 9 шийдвэр, бусад 13 өөр өөр өмчлөгчид холбогдох 17 шүүхийн шийдвэр байна.



Шүүхээс “МК” ХХК-тай холбоотой 36 хэрэг маргааны 63 шийдвэрийн 87.3 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 9.5 хувийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож, 3.8 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна. “М” ХХК-д холбогдох нийт 8 хэрэг маргааны 19 шийдвэрийн 84.21 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 16.79 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж тус тус шийдвэрлэсэн байна. “Г вилл” хотхонд нийт 8 хэрэг маргааны 9 шийдвэрийн 66.67 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 33.34 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж тус тус шийдвэрлэсэн байна. Бусад 13 өөр өөр өмчлөгчид холбогдох нийт 13 хэрэг маргааны 17 шийдвэрийн 47.06 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 29.41 хувийг нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг ханган, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож, 23.53 хувийг нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн байна.

Удиртгал хэсэгт дурдсан шалгуураар сонгон авч шинжилж дүгнэсэн эдгээр хэрэг маргааны олонх нь маргааны зүйл болох орон сууцыг “дуусаагүй барилга байхад барилгын компанийн өмчлөлд бүртгүүлж, барьцаанд тавьсан, эрх бүхий байгууллагаас эрхийг түдгэлзүүлсэн” гэсэн ижил нөхцөлөөс үүссэн болохыг дурдах нь зүйтэй. Сонгон авсан шүүхийн шийдвэр тус бүрийг шинжилж дүгнэсний үндсэн дээр асуудал, ач холбогдлыг тодорхойлж, нэгдсэн дүгнэлт гаргахыг зорилоо.

1.1. ӨМЧЛӨХ ЭРХИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХИЙГ ДААЛГАСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Жишээ 1: “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэж олгосон гэрчилгээг хүчингүй болгож, өмчлөгчөөр Г.Г-г бүртгэж гэрчилгээ олгохоос татгалзсан үйлдлийг хууль бус болохыг тогтоон, Г-ийн өмчлөлд бүртгэж гэрчилгээ олгохыг УБЕГ-т даалгуулахтай холбоотой хэрэг.¹⁰

Хэргийн үйл баримт:

Иргэн Г 2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр “МК” ХХК-тай “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулан, Хан-Уул дүүргийн ... тоот өрөө орон сууц, мөн байрны зоорины давхрын авто зогсоолын хамт захиалан, орон сууц болон авто зогсоолын төлбөрийг бүрэн төлжээ.

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 102/ШШ2016/00704 дугаар захирамжаар орон сууц болон авто зогсоолын хууль ёсны өмчлөгчөөр иргэн

¹⁰ НЗХАШШ, 2016 оны 08 дугаар сарын 03. Дугаар 558

Г-г тогтоосон байна. Энэхүү шүүгчийн захирамжийг үндэслэн Г нь 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдөр орон сууцны өмчлөх эрхийг хууль ёсны өмчлөгч болох өөрийн нэр дээр улсын бүртгэлд бүртгүүлэн, гэрчилгээ олгохыг хүсэж, уг хүсэлтэд хууль ёсны өмчлөгч болохыг нотлох бүхий л баримт бичгүүдийг хавсарган өгчээ.

Хариуцагч улсын бүртгэлийн байгууллага: Хан-Уул дүүргийн ... тоот, аялал жуулчлалын зориулалттай ... мкв талбайтай 4 өрөө бүхий үл хөдлөх хөрөнгийг холбогдох нотлох баримтыг үндэслэн, 90 хувийн гүйцэтгэлтэйгээр 2010 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “МК” ХХК (РД: 2714728)-ийн өмчлөлд эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт бүртгэн өмчлөх эрхийн гэрчилгээ олгосон байна. “У” банктай байгуулсан 2010 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ЗГ0002/100319 тоот зээлийн гэрээ, 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ЗНГ0003/100519/1/ тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ЗБГ0003/100519 тоот барьцааны гэрээ тус тус бүртгэлтэй байна.

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 56 тоот тогтоол болон Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2010 оны 1/109011/10599 тоот албан бичгүүдээр “МК” ХХК-ийн өмчлөлийн Хан-Уул дүүргийн ... тоот байруудыг битүүмжилсэн байна.

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 08 дугаар сарын 26-ны 4740 дугаар захирамжаар “МК” ХХК-ийн эд хөрөнгийг битүүмжилжээ.

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д “Улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох”, 18.1.10-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж,

улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийхийг хориглоно”, ЭХӨЭТХЭХБЭУБТХ¹¹-ийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 20.1.4-д заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол өмчлөгчийн эрхийг хязгаарласан этгээдийн шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна”, тус тус заасан байдаг. Мөн ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэснийг тус тус үндэслэн барьцаалагч болох “У банк” ХХК, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны зөвшөөрөлгүйгээр, “Тухайн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэх боломжгүй” гэж үзэн бүртгэхээс татгалзсан.

Шийдвэрлэсэн байдал:

ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 13, 14 дүгээр зүйлд заасныг баримтлан Г-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, “Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар”-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт эрхийн улсын бүртгэлийн ... дугаар бүхий Хан-Уул дүүрэг дэх ... орон сууц, мөн байрны 157 дугаар автомашины зогсоолыг “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн бүртгэл болон ... дугаартай үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож, уг орон сууц, автомашины зогсоолыг Г-ийн өмчлөлд бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрчилгээ олгохыг даалгасан байна.

Г нь 2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр “МК” ХХК-тай “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах, худалдан

¹¹ Энэхүү хууль 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий хуулиар хүчингүй болж, мөн оны 11 дүгээр сарын 01-ээс үйлчлэл нь зогссон.

авах гэрээ”-г байгуулан, орон сууц болон авто зогсоолын төлбөрийг бүрэн төлсөн. Гэтэл 2010 оны 05 дугаар сарын 12-ны өдөр маргааны зүйл болох орон сууц болон зогсоолыг 90 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй үл хөдлөх хөрөнгөөр “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэн өмчлөх эрхийн гэрчилгээ олгосон байна. Хариуцагчийн тайлбарт “У банк” ХХК-тай байгуулсан 2010 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ЗГ0002/100319 тоот зээлийн гэрээ, 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ЗНГ0003/100519/1/ тоот зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ, 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн ЗБГ0003/100519 тоот барьцааны гэрээ тус тус бүртгэлтэй байна” гэж дурдсан.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: “Гуравдагч этгээд “У банк ХХК “Цаг хугацааны хувьд барьцааны гэрээнээс хойно шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгч нь өмчлөгч болсон” гэж байгаа ч нэхэмжлэгч нь “МК” ХХК-тай 2009 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 164 дугаар “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээ” байгуулж, Хан-Уул дүүрэг дэх... тоот ... мкв талбай бүхий 4 өрөө орон сууцыг мөн ... дугаар авто зогсоолын хамт захиалан гэрээний дагуу нэхэмжлэгч Г зохих төлбөрийг бүрэн төлж, барагдуулсан болох нь нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан бичгийн нотлох баримтууд болох кассын орлогын ордерууд болон гуравдагч этгээд “МК” ХХК-ийн шүүхэд бичгээр гаргасан тайлбараар няцаагдаж байна. ... Гуравдагч этгээд “МК” ХХК нь “У банк” ХХК-д 2010 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Зээлийн барьцааны гэрээ”-ээр барьцаалсан үйлдэл нь буруу боловч тухайн зээлийн гэрээг 2 сарын хугацаатай байгуулан, зээлийн нэмэлт гэрээгээр 5 сарын хугацаагаар буюу 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл хугацааг сунгаж байсан байх ба хавтас хэрэгт авагдсан бичгийн нотлох баримт болох “Зээлийн дансны хуулга”-аар “МК” ХХК нь 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдөр төлж дуусгасан болох нь тогтоогдож байхад УБЕГ-ын

эд хөрөнгийн эрхийн бүртгэлд Г-ийн эд хөрөнгийг бүртгэхгүй байгаа нь үндэслэлгүй байна” гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт “...гэрээ байгуулан төлбөрийг бүрэн төлж барагдуулснаар түүний өмчлөх эрх үүсэх бөгөөд энэхүү орон сууцаа өмчлөх эрх үүссэний дараа “МК” ХХК, “У банк” ХХК-ийн хооронд байгуулсан зээлийн барьцааны гэрээг нэхэмжлэгчийн оролцоогүйгээр хийж, ашиг сонирхлыг нь авч үзэлгүй бүртгэсэн атлаа үүсэж буй үр дагаварт түүнийг хамаатуулж байгаа нь ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “бүртгэл үнэн зөв байх” гэх зарчим зөрчигдсөн байна” гэж дүгнэсэн нь үндэслэл бүхий байна.

Харин нэхэмжлэгч Г.Г болон “МК” ХХК-ын хооронд “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулан, орон сууц болон автомашины зогсоолын төлбөрийг бүрэн төлснөөс хойш “МК” ХХК-ийн өмчлөлд 90 хувийн гүйцэтгэлтэй бүртгэгдсэн байгааг анхаарах ёстой. Нэхэмжлэлийн шаардлагад ч “...орон сууц, мөн байрны ... дугаар автомашины зогсоолыг “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн бүртгэл болон ... дугаартай үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох...” гэж дурдсан байдаг.

Шүүх “МК” ХХК-ийн өмчлөлд 90 хувийн гүйцэтгэлтэй бүртгэсэн бүртгэл хууль ёсны байсан эсэхэд дүгнэлт өгөөгүй. “МК” ХХК нь бусдын өмчлөлд шилжүүлэхээр гэрээ хийж, төлбөрийг бүрэн авсан үл хөдлөх хөрөнгийг өөрийн өмчлөлд бүртгүүлсэн нь, улмаар барьцаанд тавьсан нь иргэний эрх зүйн өмчийн халдашгүй байдлын зарчим, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэл үнэн зөв байх¹² зарчимд нийцээгүй бөгөөд “Мэдүүлэг гаргагч нь мэдүүлэг, түүнд хавсаргах баримт

¹² ЭХӨТХЭХБЭУБТ хууль (2003 он) 5 дугаар зүйлийн 5.1.2

бичгийг үнэн зөв гаргах үүрэгтэй...”¹³ гэсэн хуулийн заалтыг зөрчсөн байх боловч шүүх энэ талаар ямар нэгэн дүгнэлт хийгээгүй байна.

Формал шаардлагын хувьд авч үзвэл, шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт: “...Гуравдагч этгээд “МК” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Г 2016 оны 7 дугаар сарын 20-ны өдөр шүүх хуралдаанд гаргасан хариу тайлбартаа: “...Иргэн Г нь 2009 оны 07 дугаар сарын 17-ны өдөр 164 дугаар “Орон сууц захиалгаар бариулах гэрээ”-г байгуулж, Хан-Уул дүүргийн ... байрны бүх төлбөрийг төлж барагдуулсан. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 102/ШШ/2016/704 дүгээр захирамжаар Г-г хууль ёсны өмчлөгчөөр тогтоосон. ... Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэлтэй гэж үзэж байна. Г.Г-ийн нэр дээр орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээ бичигдэхэд татгалзах зүйлгүй” гэсэн байна. Гэтэл үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч Г нь Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын “МК” ХХК-ийн нэр дээр эрхийн улсын бүртгэлийн Y-2206013630 дугаарт бүртгэсэн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000103623 дугаартай гэрчилгээг хүчингүй болгож, Хан-Уул дүүргийн ... тоотод байрлах ... м.кв, 4 өрөө орон сууцны өмчлөгчөөр иргэн Г-г бүртгэж, гэрчилгээ олгохоос татгалзсан үйлдлийг хууль бус гэж хариуцагч “МК” ХХК болон “У банк” ХХК-ний барьцааны гэрээ бүртгэлтэй тул нэхэмжлэл үндэслэлгүй гэж маргажээ” гэж томъёолсон нь найруулгын хувьд ойлгомжгүй байна.

¹³ ЭХӨТХЭХБЭУБТ хууль (2003 он) 13 дугаар зүйлийн 13.9

Жишээ 2: “МК” ХХК-ийн нэр дээр бүртгэгдсэн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж, “Блю Скай” хотхоны 44В байрны 126 тоот авто зогсоолын улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгож, тус 44В байрны 126 тоот авто зогсоолын улсын бүртгэлийг иргэн Ө.Г-ийн нэр дээр бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоон, өмчлөх эрхийн улсын бүртгэлийг Ө.Г миний нэр дээр бүртгэн, гэрчилгээ олгохыг Хан-Уул дүүргийн Бүртгэлийн хэлтэст даалгаж өгнө үү” гэсэн нэхэмжлэлийн шаардлага бүхий захиргааны хэрэг.¹⁴

Хэргийн үйл баримт:

Ө.Г 2009 оны 08 дугаар сарын 08-ны өдөр “МК” ХХК-тай “Автомашинны зогсоол худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулан Хан-Уул дүүргийн ... зоорийн давхрын ... тоот автомашины зогсоолыг захиалж, гэрээний үнийг бүрэн төлснөөр тус компанитай “Тооцоо нийлсэн акт” үйлдэж, автомашины зогсоолыг өөрийн эзэмшил, ашиглалтад хүлээн авчээ.

Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 101/ШШ2016/01494 дугаартай шүүгчийн захирамжаар хариуцагчийн зөвшөөрлийг баталсан. Ө.Г нь Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн газарт хандахад 2016 оны 03 дугаар сарын 09-ний өдөр “К банк” ХХК-ийн барьцаанд байгаа тул бүртгэх боломжгүй гэсэн бүртгэхээс татгалзсан хариуг өгсөн, мөн Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт гомдол гаргахад 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдөр бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй гэх хариу өгсөн.

Хан-Уул дүүргийн ... байрны ... тоот авто зогсоолыг 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “МК” ХХК нь эрхийн улсын бүртгэлд өөрийн нэр дээр 90 хувийн гүйцэтгэлтэйгээр

¹⁴ НЗХАШШ-ийн шийдвэр. 2016 оны 08 дугаар сарын 24. Дугаар 590

бүртгүүлсэн. Гуравдагч этгээд “МК” ХХК “..нэхэмжлэгчийн гаргасан шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Ө.Г-ийн нэр дээр Хан-Уул дүүргийн ... байрны зоорийн давхарт байрлах ... тоот авто зогсоолын эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ бичигдэхэд татгалзах зүйлгүй болно” гэдэг.

Гуравдагч этгээд “К банк” ХХК “... 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “МК” ХХК-ийн өмчлөлд ... дүгээр байрны тоот тус бүрийн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ олгогдсон учир тус банк өмнө байгуулсан гэрээг шинэчлэн байгуулж, 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Т07/141 тоот “Зээлийн барьцааны гэрээ”-ээр ... дүгээр байрны ... тоот автомашины зогсоолуудыг нэг бүрчлэн барьцаалсан байна.

Ө.Г нь 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Баянгол, Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 01/ШШ2016/01494 тоот шүүгчийн захирамжаар маргаан бүхий үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болсноос үзэхэд энэ нь тус банкны 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 07/141 тоот “Зээлийн барьцааны гэрээ”-ний дагуу үүссэн барьцааны эрхээс хойш бий болсон үр дагавар байна.

“... иймд нэхэмжлэгч Ө.Г-ийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү!” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал:

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 19 дүгээр зүйлийн 19.2, 24 дүгээр зүйлийн 24.4, 24.8-д заасныг тус тус баримтлан Ө.Г-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Хан-Уул дүүргийн ... байрны зоорийн давхрын ... тоот авто зогсоолын өмчлөгчөөр Ө.Г-г бүртгэн, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгохыг ОӨУБЕГ-т даалгасан.

Шүүх ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-

т “Эрх ашиг нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх” гэж зааснаар эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулахын тул барьцаалагчаас зөвшөөрөл авсан байхыг шаардана, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д “Улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж гэрчилгээ олгохыг хориглоно” гэсэн үндэслэлээр хариуцагч Улсын бүртгэлийн байгууллага Ө.Г-ийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан хэдий ч барьцаалагч буюу гуравдагч этгээд “К банк” ХХК нь “Барьцааны эрхийг хөндөхгүйгээр буюу барьцааны эрхийг хадгалах байдлаар өмчлөгчийг өөрчилж бүртгэхэд татгалзах зүйлгүй” хэмээн зөвшөөрсөн, өөрөөр хэлбэл барьцаалагч зөвшөөрсөн гэсэн үг. Түүнчлэн ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т зааснаар “Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн тул нэхэмжлэгчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхээ хэрэгжүүлэх боломжийг хязгаарлах, зөрчих үндэслэлгүй” гэж дүгнэсэн байна.

Түүнчлэн нэхэмжлэгч Ө.Г нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр маргааны зүйл болох автомашины зогсоолын өмчлөгчөөр тогтоогдсон тул ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “Мэдүүлэг гаргагч тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол бүртгэхээс татгалзана” гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул мөн зүйлийн 14.2-т “Бусад үндэслэлээр бүртгэхээс татгалзахыг хориглоно” гэж зааснаар татгалзсан нь үндэслэлгүй, түүнчлэн мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д зааснаар “Шүүхийн шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдсөн” гэж үзэхээр байх тул 24.8-д “... хариуцагч байгууллага мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор эрхийн улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулж, өмнөх гэрчилгээг хүчингүй болгож, шинэ өмчлөгчид эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно” гэж зааснаар өмчлөгчөөр бүртгэн, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгохыг даалгах үндэслэлтэй гэж дүгнэжээ.

Харин “МК” ХХК-ийн “К банк” ХХК-ийн өмнө хүлээсэн барьцаагаар хангагдах зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ хэвээр үлдсэн бөгөөд барьцааны гэрээтэй холбоотой маргаан нь иргэний хэргийн шүүхийн харьяаллын маргаан бөгөөд уг маргааныг иргэний шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой болохыг дурдах нь зүйтэй гэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүх нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрээр өмчлөгчөөр тогтоогдсон гэдгийг гол үндэслэл болгон хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд ингэхдээ барьцааны эрхийг хэвээр үлдээх шийдлийг сонгосон байна.

Барьцаалагч “К банк” ХХК нь “МК” ХХК-тай байгуулсан дээрх барьцааны гэрээнүүд нь ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1, 156.2, ҮХЭХБтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтууд болон “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн бүртгэл”-ийн журамд заасан зохицуулалтын дагуу бүртгэгдсэн, хүчин төгөлдөр гэрээнүүд юм. ... Нөгөөтээгүүр нэхэмжлэгч Ө.Г нь 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 01/ШШ2016/01494 тоот шүүгчийн захирамжаар маргаан бүхий үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болсноос үзэхэд энэ нь тус банкны 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 07/141 тоот “Зээлийн барьцааны гэрээ”-ний дагуу үүссэн барьцааны эрхээс хойш бий болсон үр дагавар байна. ... нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэсэн байхад шүүх “барьцааны эрхийг хөндөхгүйгээр буюу барьцааны эрхийг хадгалах байдлаар өмчлөгчийг өөрчилж бүртгэхэд татгалзах зүйлгүй” хэмээн барьцаалагч зөвшөөрсөн гэж дүгнэсэн нь эргэлзээ төрүүлж байна.

Гуравдагч этгээд “К банк” ХХК: “...нэхэмжлэгч Ө.Г-ийн

өмчлөх эрх нь тус банкны барьцааны эрхээс хойно үүссэн учир “МК” ХХК-ийн өмчлөх эрхийг Ө.Г-д шилжүүлэн бүртгэхэд ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэж заасны дагуу “К банк” ХХК-аас зөвшөөрөл авахыг бүртгэлийн байгууллага (Бүртгэгч) мэдүүлэг гаргагчаас шаардах эрхтэй байна” гэж тайлбарласан. Барьцаалагч маргааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг Ө.Г-ийн өмчлөлд шилжүүлж, улсын бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй. Гэтэл шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэж заасныг баримталсан нь ойлгомжгүй байна.

Жишээ 3: *НЗХАШШ-ийн 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 438 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч, нэхэмжлэгчийн давж заалдах гомдлын дагуу Баянзүрх дүцэргийн 1 дүгээр хороо, ... гудамж, ... хороолол, 105 дугаар байрны 306 тоот орон сууц, ... тоот зогсоолыг Д.О-ын өмчлөлд бүртгэхийг даалгуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий, ОӨУБЕГ-т холбогдох захиргааны хэрэг.*¹⁵

¹⁵ ЗХДЗШШ-ийн магадлал. 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр. Дугаар 22/МА2017/0607

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэгч О нь “ЭЭЖК” ХХК-тай Баянзүрх дүүргийн ... дугаар байранд 3 өрөө орон сууц болон ... автомашины зогсоолыг 2008 онд хийгдсэн орон сууц захиалгаар бариулах гэрээг нэр сольж байгуулах замаар Б-ээс худалдан авчээ. Өмчлөгчөөр О-г бүртгэхээс татгалзсан үйлдлийг хууль бусад тооцож, улмаар бүртгэж, гэрчилгээ олгохыг ОӨУБЕГ-т даалгах шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч ОӨУБЕГ нь: Уг үл хөдлөх хөрөнгийг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад нь “ЭЭЖК” ХХК өмчлөлд бүртгүүлсэн, барьцааны гэрээ бүртгэлтэй, НШШГА-аас захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзжээ.

НЗХАШШ уг маргааныг хянан хэлэлцээд, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.6, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.2, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.5, УБЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2, 18 дугаар зүйлийн 18.1.10-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: “...Хариуцагчийн шүүхэд ирүүлсэн зээлийн болон барьцааны гэрээг харахад “ЭЭЖК” ХХК нь зөвхөн 60 хувийн гүйцэтгэлтэй, дуусаагүй барилгыг банканд барьцаалсан байхад нэхэмжлэгчийн шаардлагад байгаа 100 хувийн гүйцэтгэлтэй ... байрны ... тоот орон сууцыг барьцаалсан гэж үзээд ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19.2, 20.1.4 дэх заалтыг баримтлан шийдвэр гаргасан нь үндэслэлгүй байна. ... Анхан шатны шүүхийн хурлын тэмдэглэлд гуравдагч этгээд “ЭЭЖК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал А-ын өгсөн барьцааны гэрээ дуусгавар болсон талаар мэдүүлэг байдаг. Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч ч энэ талаар үгүйсгээгүй, гагцхүү барьцаа дуусгавар болсон талаар албан бичиг ирээгүй, эсвэл шүүхээр шийдвэрлэгдээд, нэг тогтоол гарсан байдаг гэсэн тодорхойгүй зүйлүүд шүүх хурал дээр

ярьсан. Энэ үүднээсээ “Зоос банк”-ны эрх хүлээн авагчийг хуралд зайлшгүй оролцуулах шаардлагатай байсан” хэмээн давж заалдах гомдол гаргажээ.

Шийдвэрлэсэн байдал:

ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр зүйлийн 19.1.1-д заасныг тус тус баримтлан О-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

Шүүх “Нэхэмжлэгч О нь “ЭЭЖК” ХХК-тай Баянзүрх дүүргийн ... дугаар байранд 3 өрөө орон сууц болон ... авто зогсоолыг 2008 онд хийгдсэн орон сууцны захиалгаар бариулах гэрээг нэр сольж байгуулах замаар 2010 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Б-ээс худалдан авсан байна. Өөрөөр хэлбэл, ... тоот орон сууц, ... тоот автомашины зогсоол нь 2008 онд Б-т (сүүлд шилжүүлэн авсан О-д) өмчлөх эрх нь шилжсэн хойно 2010 онд бүртгүүлсэн барьцааг үндэслэн О(Б)-ын өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй юм.

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж, улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх” улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хориглох болон ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Шүүх, арбитр, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр гарсан” гэж заасан нь зөвхөн зээлийн барьцаанд хамаарах 60 хувийн гүйцэтгэлтэй барилгад хамаарах юм.

“Нэхэмжлэгч О-ын өмчлөх эрх нь “ЭЭЖК” ХХК барьцааны бүртгэл хийлгэхээс өмнө буюу гуравдагч этгээд “З банк” болон “Х банк”-ны барьцааны эрхээс цаг хугацааны хувьд түрүүлж үүссэн болох нь тогтоогдож байна” гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүх “Нэхэмжлэгчийн өмчлөх эрх нь барьцааны эрхээс өмнө үүссэн, барьцааны эрх болон, эрх хязгаарласан тэмдэглэлүүд нь 60 хувийн гүйцэтгэлтэй барилгад хамаарах бөгөөд 100 хувийн гүйцэтгэлтэй барилгын шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй” гэж дүгнэсэн. Энэхүү нөхцөл байдал нь нэхэмжлэгчийн өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзах үндэслэл болгож буй УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д заасан нөхцөлд хамаарахгүй тухай тодорхой, үндэслэл бүхий дүгнэлт өгчээ.

Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангасан. Формаль шаардлагын хувьд магадлал бичвэрийн хувьд ойлгомжтой, тодорхой байна.

Жишээ 4:¹⁶ *Баянзүрх дүүргийн ... тоот орон сууц, ... тоот автомашины зогсоолыг Б.Г-ын нэр дээр бүртгэхийг хариуцагч УБЕГ-т даалгах.*¹⁷

Хэргийн үйл баримт:

Б.Г нь “Э” ХХК-тай 2008 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Орон сууц захиалгаар бариулах” тухай гэрээ байгуулж, Баянзүрх дүүргийн ... байрны ... тоот орон сууц, ... тоот зогсоолыг авахаар тохирсон. 2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр төлбөрийг бүрэн барагдуулсан. Үүнээс хойш орон сууц, автомашины зогсоолыг ашиглаж байгаа, зохих баримтыг бүрдүүлэн удаа дараа улсын бүртгэлийн байгууллагад хандсан боловч өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзсан. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 дугаар

¹⁶ Энэхүү маргаан нь Жишээ 7-д дурдсан маргаан болохыг онцолж байна. (хэргийн оролцогчид, маргааны зүйл бүгд ижил)

¹⁷ НЗХАШШ, 2019 оны 05 дугаар сарын 08. Дугаар 280

сарын 20-ны өдрийн байгаа 02161 дүгээр захирамжаар “Г-г өмчлөгч болохыг тогтоосон... тул бүртгэхийг даалгаж өгнө үү” гэж нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч Улсын бүртгэлийн байгууллага: Уг барилгыг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад нь “Э” ХХК өөрийн өмчлөлд бүртгүүлж, “З банк” ХХК болон БНСУ-ын “Х банк”-д барьцаалан, барьцаат зээлийн гэрээг бүртгүүлсэн. НШШГА болон цагдаагийн байгууллагаас удаа дараагийн албан бичгээр захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн. ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна”, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын Ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийхийг хориглоно” гэж заасан тул барьцаалагчийн зөвшөөрөл, НШГА болон цагдаагийн байгууллагын эрх сэргээсэн тухай албан бичиг ирээгүй байхад иргэн Г-ийн өмчлөлд бүртгэх боломжгүй хэмээн маргасан.

Шийдвэрлэсэн байдал:

2009 оны УБЕХ ийн 18 дугаар зүйлийн 18.1.10, 2003 оны ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 2018 оны УБЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.1.1, 2018 оны ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Г-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Баянзүрх дүүргийн ... орон сууцны хорооллын ... дугаар байрны ... тоот ... мкв талбайтай орон сууц болон мөн байрны ... тоот зогсоолыг тус

тус Г-ын нэр дээр бүртгэхийг хариуцагчид даалгасан.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: “Нэхэмжлэгч Г Баянзүрх ... байрны ... тоот ... мкв ..өрөө байр болон ... дугаар авто зогсоолыг захиалан бариулахаар 2008 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 77 дугаар Орон сууц захиалгаар бариулах тухай гэрээг Э ХХК, “З банк” ХХК-тай байгуулсан байна.

Нэхэмжлэгч нь нэхэмжлэлдээ “...2008 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Э” ХХК-д гэрээний төлбөр 45,000 мянган ам.долларыг төлсөн, мөн гэрээнд заасны дагуу үлдэгдэл төлбөр 179,025 мянган ам.долларыг 2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр төлж төлбөрийг бүрэн барагдуулсан нь хэрэгт авагдсан бичгийн нотлох баримтуудаар тогтоогдож байна.”,

“Мөн Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 02161 дүгээр захирамжаар хариуцагч “Э” ХХК нь нэхэмжлэгч Б.Г-ыг маргаан бүхий объектуудын өмчлөгч мөн болохыг хүлээн зөвшөөрсөн.” (НЗХАШШ-ийн 2017 оны 08 дугаар сарын 28-ны 632 дугаар шийдвэр гарснаас хойш зөвхөн энэ нөхцөл нэмэгдсэн),

“ЭХЭУБХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Иргэн, хуулийн этгээд УБЕХ-ийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу Эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ” гэж заажээ.

“ЭХЭУБТХ-ийн 8 дугаар зүйлд мэдүүлэг хүлээн авахаас татгалзах үндэслэлийг заасан бөгөөд хариуцагч Улсын бүртгэлийн ерөнхий газраас Г-ын мэдүүлгийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргасныг буруутгах үндэслэлгүй боловч БНСУ-ын “Х банк”-ны нэхэмжлэлтэй “Э” ХХК-д холбогдох иргэний хэрэгт орон сууц захиалгаар бариулах тухай 13 гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан байх бөгөөд уг хүчин төгөлдөр бусад тооцуулах 13 гэрээнд нэхэмжлэгч Б.Г-ын гэрээ багтсан байдаг.

“Э” ХХК нь Баянзүрх дүүргийн ... байршилтай барилгыг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад нь 2006 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт өөрийн өмчлөлд бүртгүүлж, улмаар энэхүү 11 давхар, нийт 6,305.64 мкв талбай бүхий 60 хувийн гүйцэтгэлтэй барилгыг барьцаалсан “З банк” ХХК болон БНСУ-ын “Х банк”-тай байгуулсан “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ”-г Эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн болох нь мөн хариуцагч, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын тайлбар, улсын бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан мэдүүлэг, түүнд хавсаргасан баримтууд, барьцааны гэрээ зэрэг хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Уг барьцааны гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор БНСУ-ын “Х банк”-аас Бондын төлөгдөөгүй үндсэн төлбөр 15,521,585,030 вон, алданги 7,760,792,515 воныг тус тус гаргуулах, барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах, орон сууц захиалгаар бариулах тухай 13 гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай үндсэн нэхэмжлэлийг “Э” ХХК-д холбогдуулан Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхэд гаргаж, шийдвэрлэгдсэн бөгөөд давах болон хяналтын шатны шүүхээр хянагдсан.

УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 554 дүгээр тогтоолоор Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 3224/Б дугаартай шийдвэр, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 337 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, “Э” ХХК-аас 12,228,377,545 вон, өмгөөлөгчийн хөлс 30,000 ам.доллар тус тус гаргуулах, барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах, орон сууц захиалгаар бариулах тухай 13 гэрээг хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай БНСУ-

ын “Х банк”-ны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1, 65 дугаар зүйлийн 65.1.3-д зааснаар ... цогцолборын орон сууц, авто машины өмчлөгчөөр тогтоолгохыг хүссэн бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд нарын нэхэмжлэлтэй хэргийг хэрэгсэхгүй болгож, бие даасан шаардлагыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байх бөгөөд уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон байна. НЗХАШШ-ийн 2017 оны 08 дугаар сарын 28-ны 632 дугаар шийдвэр гарах үед энэ нөхцөл байсан боловч шүүх үүнд дүгнэлт хийгээгүй байдаг.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэвэл “Э” ХХК нь ... цогцолборын ... дугаар байрыг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад нь “З банк” ХХК болон БНСУ-ын “Х банк”-нд барьцаалсан байх бөгөөд уг компани нь дээрх орон сууцны өмчлөх эрхийг нэхэмжлэгчид шилжүүлэхийг зөвшөөрсөн, түүнчлэн уг барилга нь бүхэлдээ бүрэн баригдаж дууссан, уг барилгыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр “З банк” ХХК болон БНСУ-ын “Х банк”-нд барьцаалсан барьцааны гэрээ улсын бүртгэлд бүртгэгдээгүй, УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 554 дүгээр тогтоолоор “Э” ХХК-аас БНСУ-ын “Х банк”-нд төлөх төлбөргүй гэж үзэж, БНСУ-ын “Х банк”-ны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байх тул иргэн Б.Г нь .. дугаар байрны .. тоот, ... өрөө ... мкв орон сууц болон мөн байрны ... тоот автомашины зогсоолын өмчлөх эрхийг ИХ-ийн 182 дугаар зүйлийн 182.1-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх эрхтэй бөгөөд хариуцагчийн “Э” ХХК-ийн орон сууцыг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн гэх үндэслэл, тайлбарыг гаргаж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Түүнчлэн дээрх албан бичигт дурдагдсан барилга нь тухайн үед 60 хувийн гүйцэтгэлтэй, дуусаагүй барилга байсан, “Э” ХХК нь зөвхөн 60 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилгын

өмчлөгчөөр бүртгэгдсэн, уг албан бичгээр ашиглалтад орсон 100 хувийн гүйцэтгэлтэй ... дугаар байрны барилгыг бүхэлд нь шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан гэж үзэх үндэслэл хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдохгүй байх тул УБЕХ (2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр)-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт зөрчигдсөн гэж үзэхгүй, харин 103 дугаар барилга нь бүхэлдээ нэг этгээдийн өмч биш, нийтийн зориулалттай орон сууцны барилга бөгөөд сууц бүрийг өөр өөр этгээд дангаар өмчлөх боломжтой байх тул “Нэхэмжлэгч нь ... цогцолборын ... дугаар байрны ... тоот, ... өрөө ... мкв орон сууц болон мөн байрны ... тоот автомашины зогсоолын дангаар өмчлөх эрх үүссэн” гэж үзнэ.

ЭХЭУБТХ (2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр)-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Барьцаалбарын хууль ёсны эзэмшигч, эсхүл барьцаалагчийн хүсэлт, эсхүл шүүх, арбитрын шийдвэрийг үндэслэн барьцааны эрхийг дуусгавар болгоно” гэж заасан.

Иймд “Нэхэмжлэгч Г Баянзүрх дүүргийн ... орон сууцны хорооллын ... дугаар байрны .. тоот ... мкв талбайтай орон сууц болон мөн байрны ... тоот зогсоолыг тус тус Г-ын нэр дээр бүртгэхийг хариуцагчид даалгах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэх нь зүйтэй” гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт дурдсанаас үзэхэд хариуцагч УБЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарт “Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд байрлах ... цогцолборын ... дугаар байрыг холбогдох нотлох баримтыг үндэслэн 60 хувийн гүйцэтгэлтэйгээр “Э” ХХК (2823632)-ийн өмчлөлд Эрхийн улсын бүртгэлийн Ү... дугаарт бүртгэсэн байх бөгөөд “З банк” болон БНСУ-ын “Х банк”-тай байгуулсан барьцаат зээлийн гэрээ бүртгэлтэй байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2009 оны 1/6542, 1/9731, 11/13253; 2012 оны 2/4309, 2/5394, 2/9693, 2/10559; 2013 оны 2/2931, 2/2236; 2014 оны 2/1449, Цагдаагийн ерөнхий газрын Улсын мөрдөн байцаах газрын 2010 оны 10/5-701 тоот албан бичгүүдийг үндэслэн захиран зарцуулах эрхийг нь түдгэлзүүлсэн байна. “Э” ХХК нь тухайн орон сууцаа барьцаалан “З банк” ХХК болон БНСУ-ын “Х банк”-аас зээл авсан бөгөөд барьцаат зээлийн гэрээ нь өнөөдрийн байдлаар албан ёсоор дуусгавар болоогүй байна. Тухайн орон сууцны захиран зарцуулах эрхийг эрх бүхий байгууллагуудаас удаа дараа түдгэлзүүлсэн байх тул захиран зарцуулах эрхийг сэргээсэн тухай албан бичиг, барьцаалагчдын зөвшөөрөл, шүүх, арбитрын шийдвэргүйгээр Эрхийн улсын бүртгэлд дур мэдэн өөрчлөлт оруулах боломжгүй байна” гэж, Гуравдагч этгээд “З банк”-ны итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарт “Э” ХХК-ийн ... орон сууцны цогцолборыг бариулах санхүүжилтийг БНСУ-ын хөрөнгө оруулагч талууд тэдгээрийг төлөөлөн “Х банк”, нөгөө талаас “З банк” ХХК оролцон олон талт гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу тус орон сууцны цогцолборын дуусаагүй барилгын гэрчилгээг БНСУ-ын хөрөнгө оруулагч тал давхар барьцаалсан.

Түүнчлэн “Х банк”-ны ипотекийн шаардах эрхийг холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэн шийдвэрлэхийг хүсэж байна. Иймд хариуцагч Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас шүүхэд холбогдох хууль тогтоомжид дурдсанаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохоор гаргасан хариу тайлбарыг “З банк” дэмжиж байгаа болно” гэжээ.

Хариуцагч, гуравдагч этгээд нарын тайлбараас үзэхэд барьцааны эрхийг дуусгавар болгох талаар барьцаалагч хүсэлт гаргаагүй, эрх хязгаарласан тусгай тэмдэглэл хүчинтэй хэвээр байна. Гэвч шүүх УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 554

дүгээр тогтоолоор Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 3224/Б дугаар шийдвэр, Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 337 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, “Э” ХХК-аас 12,228,377,545 вон, өмгөөлөгчийн хөлс 30,000 ам.доллар тус тус гаргуулах, барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах, орон сууц захиалгаар бариулах тухай 13 гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулах тухай БНСУ-ын “Х банк”-ны нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосныг үндэслэн барьцааны эрхийг дуусгавар болгох боломжтой, мөн барилгыг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад хийсэн эрхийн хязгаарлалт нь 100 хувийн гүйцэтгэлтэй барилгын шилжилт хөдөлгөөнийг бүхэлд нь хязгаарласан гэх үндэслэл тогтоогдохгүй байна гэж дүгнэсэн. Энэ нь ЭХЭУБТХ (2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр)-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Барьцаалбарын хууль ёсны эзэмшигч, эсхүл барьцаалагчийн хүсэлт, эсхүл шүүх, арбитрын шийдвэрийг үндэслэн барьцааны эрхийг дуусгавар болгоно” гэсэн зохицуулалтыг хэрэглэх нөхцөлийг зөв, үндэслэлтэй тодорхойлсноос гадна иргэний эрх зүйн өмчийн халдашгүй байдлын зарчимд нийцэж байгаа бөгөөд ижил төстэй маргааныг шийдэхэд ач холбогдол бүхий шийдэл болжээ.

Формаль шаардлагын хувьд Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлийг зааж, зохицуулсан хуулийн заалтуудаас гадна хангахгүй байх үндэслэлийг зааж зохицуулсан хуулийн заалтуудыг баримталсан нь оновчгүй байна. Тухайлбал: УБЕХ (2009 оны 06 дугаар сарын 25-ны өдөр)-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10 болон “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж хөдөлгөөн хийх”-ийг хориглох; ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “Шүүх, арбитр, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх

байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр гарсан бол Эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийх” –гэсэн заалтуудыг баримталсан нь эргэлзээ төрүүлж байна.

Жишээ 5: *НЗХАШШ-ийн 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 128/ШШ2020/0297 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлоор, С-ийн нэхэмжлэлтэй, УБЕГ-т холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцжээ.*

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэгч С нь 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдөр ...хаягт байрлах орон сууцны өмчлөх эрхийг “Үл хөдлөх эд хөрөнгө бэлэглэлийн гэрээ”-ний үндсэн дээр Г.С-т шилжүүлснийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгожээ.

С нь иргэн А болон “Д Ф ББСБ” ХХК-тай байгуулсан 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн ӨШГ 16/08/01 тоот “Өр шилжүүлэх гэрээ” болон 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 14/12/146 тоот “Зээлийн гэрээ”, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн ЗНГ 14/12/146 тоот “Зээлийн нэмэлт өөрчлөлтийн гэрээ”-нүүдийн үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон уг орон сууцыг барьцаалан, 2016 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Зээлийн барьцааны гэрээ”-г байгуулан 2016 оны 08 дугаар сарын 12-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх нь С-гээс Г.С-т холбогдуулан гаргасан “Үл хөдлөх эд хөрөнгө бэлэглэлийн гэрээ”-г цуцалж, хүчингүй болгуулах нэхэмжлэлийг 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 101/ШШ2017/03289 дүгээр шийдвэрээр хангаж, уг гэрээг хүчингүйд тооцож, бэлэглэлийн зүйл болох орон сууцыг

бэлэглэгч С-ийн өмчлөлд буцаан олгохоор шийдвэрлэжээ.

НШШГГ-аас уг шүүхийн шийдвэрийг гүйцэтгүүлэхээр 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 2/18942 дугаар албан бичгээр уг орон сууцны өмчлөгчөөр С-г бүртгэн шинээр гэрчилгээ олгохыг УБЕГ-ын Хан-Уул дүүргийн Бүртгэлийн хэлтэст мэдэгдсэн, мөн нэхэмжлэгч С 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Хан-Уул дүүргийн Бүртгэлийн хэлтэст хандан тус орон сууцны өмчлөгчөөр бүртгүүлэхээр мэдүүлэг гаргасан.

Улсын бүртгэгч “... гэрчилгээг эх хувиар авчрах” шаардлага тавьж бүртгэхээс татгалзсан байна.

С нь бүртгэхээс татгалзсан үйлдлийг хууль бус болохыг тогтоолгох, өмчлөгчөөр бүртгэхийг даалгах шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч нь гэрчилгээг эх хувиар авчрах, эсвэл ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.5-д “Шүүх, арбитрын шийдвэрээр өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэхэд улсын бүртгэлийн гэрчилгээг хураан авах боломжгүй болсон”, 5.7-д “Энэ хуулийн 5.5.5-д заасан тохиолдолд мэдүүлэг гаргагчийн өргөдөл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан бичгийг үндэслэн гэрчилгээг дахин олгоно” гэж заасан шаардлагыг хангасан байх ёстой гэж маргасан.

НЗХАШШ “Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй” гэж үзэн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Шийдвэрлэсэн байдал:

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, УБЕХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Улсын бүртгэгч нь үйлчлүүлэгчид хууль бус шаардлага тавих, ... үндэслэлгүйгээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах” болон ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.5-д “Шүүх, арбитрын шийдвэрээр өмчлөх

эрхийг шилжүүлэн бүртгэхэд улсын бүртгэлийн гэрчилгээг хураан авах боломжгүй болсон”, 11 дүгээр зүйлийн 11.3-д “Шүүх арбитрын шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрчлөгдөж байгаа бол өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрх олж авч байгаа этгээд мэдүүлэг гаргах ба мэдүүлэгт шүүх, арбитрын шийдвэрийг хавсаргана” гэсэн заалтуудыг тус тус баримтлан С-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, бүртгэхээс татгалзсаныг хууль бус болохыг тогтоож, С-ийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхийг даалгаж шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүх: Нэхэмжлэгч С нь мэдүүлэгт хавсаргавал зохих шүүхийн шийдвэр, бусад баримтыг бүрдүүлсэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас холбогдох албан бичгийг хариуцагч улсын бүртгэлийн байгууллагад ирүүлсэн байхад хууль, журмаар шаардаагүй баримтыг шаардан бүртгэхээс татгалзаж, гэрчилгээ олгоогүй нь УБЕХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “улсын бүртгэгч нь ... үйлчлүүлэгчид хууль бус шаардлага тавих, зүй бусаар харьцах, үндэслэлгүйгээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзахыг хориглоно” гэх заалтыг зөрчсөн байна.

Улсын бүртгэгчээс татгалзсан үндэслэлээ “гэрчилгээний эх хувь хавсаргаагүй” гэж тайлбарласан, анхан шатны шүүх уг тайлбарыг үндэслэлтэй гэж үзэхдээ ББСБ-д гэрчилгээ хадгалагдаж байгаа нь дээрх хуульд заасан “хураан авах боломжгүй” нөхцөл биш гэж үзсэн нь дээрх хуулийн агуулгад нийцэхгүй.

Учир нь энэхүү маргааны хувьд өмчлөгч өөрчлөгдөөгүй үед зөвхөн гэрчилгээ дахин олгох тухай ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.1-д заасан гэрчилгээ, гэмтэж хуучирсантай адил буюу өмчлөгч нь хуучин гэрчилгээгээ хураалгах боломжтой асуудал биш, шүүхийн шийдвэрээр үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч өөрчлөгдсөнийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх

захиргааны үйл ажиллагаатай холбоотой бөгөөд энэ талаар дээрх хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-д зааснаар хавсаргах баримтыг тусгайлан зохицуулсан байна.

Түүнчлэн Засгийн газрын 2018 оны 397 дугаар тогтоолоор батлагдсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 6.5-д “Шүүх, арбитрын шийдвэр, албадан дуудлага худалдаа, барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэл хангуулах замаар үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэнийг бүртгэхдээ “ЭХЭУБТХ-ийн 11-р зүйлийн 11.3, 11.4, 11.5, 11.6-д заасан журмыг баримтална” гэж зааснаас өөрөөр “мэдүүлэгт гэрчилгээний эх хувь хавсаргах” талаар зохицуулаагүй” гэж дүгнэсэн нь хуулийн зохицуулалтыг тухайн үйл баримтын хувьд зөв тайлбарлан хэрэглэсэн, үндэслэл бүхий дүгнэлт болжээ.

Дүн шинжилгээ:

“Шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх, агуулга хэлбэрийн хувьд хуульд заасан шаардлагыг¹⁸ хангасан, хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд жишиг болохуйц ач холбогдолтой шийдвэр” гэж үзэж байна. Энэхүү тохиолдол нь удиртгал хэсэгт дурдсанчлан хуулийн зохицуулалтыг зөв ойлгож, хэрэглээгүйн улмаас хуульд заагаагүй үндэслэлээр бүртгэхээс татгалзан өмчлөгчийг чирэгдүүлэх, хохироох нөхцөл бий болдог тохиолдлуудын нэг юм. Шүүхийн шийдвэрийн дүгнэлт нь ЭХЭУБТХ-ийн холбогдох зохицуулалтыг улсын бүртгэгч, захиргааны байгууллага цаашид зөв хэрэглэж хэвшихэд нөлөөлөхүйц ач холбогдолтой байна.

¹⁸ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйл.

1.2. ӨМЧЛӨХ ЭРХИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗСАН НЬ ҮНДЭСЛЭЛТЭЙ ГЭЖ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Жишээ 6: ЗХАШШ-ийн 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 84 дүгээр шийдвэрийг эс зөвшөөрч гуравдагч этгээд “К банк” ХХК-ийн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлоор, Ч-ын нэхэмжлэлтэй, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцсэн.¹⁹

Хэргийн үйл баримт:

Иргэн Ч “Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, ... хаягт байрлах ... хотхоны ... тоот, ... мкв талбай бүхий 4 өрөө орон сууц, ... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолын өмчлөх эрхийн гэрчилгээг Ч миний нэр дээр гаргаж өгөхийг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газарт даалгах” нэхэмжлэл гаргасан.

Анхан шатны шүүх ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 24 дүгээр зүйлийн 24.4, МУШТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасныг тус тус баримтлан иргэн Ч-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Хан-Уул дүүргийн ... хотхоны ... тоотод байрлах, 4 өрөө орон сууц, ... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолыг Ч-ын нэр дээр улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгохыг ОӨУБЕГ-т даалгаж шийдвэрлэжээ.

Нэхэмжлэгч Ч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ: “... Ч миний бие “МК” ХХК-тай гэрээ байгуулж Хан-Уул дүүргийн ... хаягт байрлах .. хотхоны .. байрны ... тоот ... мкв талбай бүхий 4 өрөө орон сууц, .. байрны зоорины давхарт байрлах .. тоот автомашины зогсоолыг захиалан бариулж, төлбөр тооцоог бүрэн барагдуулсан билээ.

¹⁹ ЗХДЗШШ-ийн магадлал, 2017 оны 04 дүгээр сарын 06. Дугаар 221/МА2017/0265

Орон сууц захиалах гэрээний дагуу “МК” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тул нэхэмжлэгч нарын зүгээс Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн шүүхэд хандсан бөгөөд тус шүүхийн шүүгчийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 102 тоот захирамжаар миний биеийг дээрх үл хөдлөх хөрөнгүүдийн хууль ёсны өмчлөгчөөр тогтоосон болно...” гэжээ.

Хариуцагч УБЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч: “Иргэн Ч-ын нэхэмжлэлд дурдсан Хан-Уул дүүргийн ... тоот 90 хувийн гүйцэтгэлтэй аялал жуулчлалын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт, “МК” ХХК-ний өмчлөлд бүртгэгдсэн байх бөгөөд 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн “У банк”-тай байгуулсан ЗГ0002/100319 тоот барьцаат зээлийн гэрээ бүртгэлтэй байна. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2010 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 1/10901 тоот, 2010 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/10599, 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1/16085 тоот албан бичгээр тус тус захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн байна.

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206014142 дугаарт бүртгэлтэй Хан-Уул дүүргийн ... дугаар байрны зоорины давхрын .. тоот 90 хувийн гүйцэтгэлтэй автомашины зогсоолын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь “МК” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байх бөгөөд 2007 оны 08 дугаар сарын 01, 2010 оны 09 дүгээр сарын 2-ны өдрийн “К банк”-тай байгуулсан 07/141 тоот барьцаат зээлийн гэрээ бүртгэлтэй байна. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны захирамжаар захиран зарцуулах эрхийг нь тус тус түдгэлзүүлсэн байна.

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8, 18.1.10 дахь заалт, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, ҮХЭХБтХ-ийн 32.1 дэх заалт, 32.2 дахь заалтуудыг үндэслэн “Хан-Уул дүүргийн ... байрны ... тоот орон сууц, ... байрны зоорины давхрын .. тоот зогсоолын

гэрчилгээнүүдийг хүчингүй болгох боломжгүй” гэж маргасан.

Гуравдагч этгээд “К банк” ХХК-ийн гүйцэтгэх захирал А: Тус банк нь 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдөр доор дурдсан хөрөнгүүдийг барьцаалсан байна. Үүнд:

“МК” ХХК-ийн өмчлөлийн ... тоот улсын бүртгэлийн дугаартай, ... тоот гэрчилгээний дугаартай, Хан-Уул дүүрэг, ... тоотод байрлах 1,692 мкв талбай бүхий 55 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга, ...Харин 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “МК” ХХК-ийн өмчлөлд ... дүгээр байрны тоот тус бүрийн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ олгогдсон учир тус банк өмнө байгуулсан гэрээг шинэчлэн байгуулж, 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Т07/141 тоот “Зээлийн барьцааны гэрээ”-ээр ... дүгээр байрны 1-205 тоот автомашины зогсоолыг нэг бүрчлэн барьцаалсан юм. Гэтэл “МК” ХХК нь иргэн Ч-тай 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах худалдан авах гэрээ”-г байгуулж, тус банкны барьцаанд бүртгэлтэй хөрөнгө болон Хан-Уул дүүрэг ... хотхоны ... дүгээр байрны .. тоот автомашины зогсоолыг худалдсан байна. Энэ нь ҮХЭХБтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна” гэж заасныг мөн ИХ-ийн 170 дугаар зүйлийн 170.6-д “Өмчлөгч нь ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй” гэсэн зохицуулалтуудыг илтэд зөрчсөн хууль бус хэлцэл юм.

Нөгөөтээгүүр нэхэмжлэгч Ч нь 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 102/ШШ2016/00776 тоот шүүгчийн захирамжаар маргаан бүхий үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болсноос үзэхэд энэ нь тус банкны 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Т07/141 тоот “Зээлийн

барьцааны зээлийн гэрээ”-ний дагуу үүссэн барьцааны эрхээс хойш бий болсон үр дагавар байна... нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.”

Гуравдагч этгээд “МК” ХХК-ийн захирал Б.Ч шүүхэд ирүүлсэн хариу тайлбартаа: “...иргэн Ч нь 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр манай компанитай “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж тус гэрээгээр .. тоот, ...4 өрөө орон сууц болон ... тоот автомашины зогсоолыг худалдан авч төлбөр тооцоог бүрэн барагдуулсан.

Иймд “МК” ХХК-ийн зүгээс “Нэхэмжлэгчийн гаргасан шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд Ч-ын нэр дээр ...эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ бичигдэхэд татгалзах зүйлгүй болно” гэжээ.

Гуравдагч этгээд “У банк” ХХК-ийн гүйцэтгэх захирал Э: “Зээлийн барьцааны гэрээг байгуулах үед нэхэмжлэгчийн маргаж буй Хан-Уул дүүрэг, ... хотхоны ... байрны ... тоот 4 өрөө үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ 2010 оны 05 дугаар сарын 12-ны өдөр “МК” ХХК-ийн нэр дээр гарч, өмчлөгчөөр “МК” ХХК бүртгэгдсэн байсан. “У банк” ХХК ЭХӨӨТХЭХБЭУБТХ-ийн 7.1-д “Эрхийн улсын бүртгэл үнэн зөв байна...” гэж заасны дагуу улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн 17 тоот орон сууцыг барьцаалж, улсын бүртгэлийн байгууллагад барьцааны эрхээ бүртгүүлж, баталгаажуулсан... нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Гуравдагч этгээд “К банк” ХХК давж заалдах гомдолдоо: “Шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсний улмаас шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангаагүй. ... Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 084 тоот шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал:

“Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 84 дүгээр шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь” гэснийг “нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг” гэж өөрчилж, “... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолыг” гэсэн хэсгийг хасаж, “2. УБЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.4, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 19 дүгээр зүйлийн 19.2, 28 дугаар зүйлийн 28.1-д тус тус заасныг баримтлан нэхэмжлэлийн “Хан-Уул дүүргийн ... хаягт байрлах ... хотхоны ... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолын үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг Ч-ын улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгохыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгах” шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэсэн 2 дахь заалт нэмж; 2 дахь заалтын дугаарыг 3 болгон “3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т заасныг баримтлан нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас 35,100 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгосугай” гэж тус тус өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж, гуравдагч этгээд “К банк” ХХК-ийн давж заалдах гомдлыг хангасугай” гэж шийдвэрлэсэн.

Гуравдагч этгээд “К банк” ХХК “...Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 084 тоот шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэж гомдол гаргасан.

Давж заалдах шатны шүүх: Нэхэмжлэгч Ч нь “МК” ХХК-тай Хан-Уул дүүргийн ... хаягт байрлах ... хотхоны .. байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашин зогсоолыг

худалдах, худалдан авах гэрээ байгуулж, төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Учир нь “МК” ХХК нь Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт хандаж, 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Хан-Уул дүүргийн ... хаягт байрлах ... хотхоны ... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашин зогсоолыг 90 хувийн гүйцэтгэлтэйгээр Эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт тус тус бүртгүүлж гэрчилгээ авсан байна. Улмаар “МК” ХХК нь 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Т07/141 дугаар “Зээлийн барьцааны гэрээ”-ий барьцааны зүйлд маргаан бүхий автомашины зогсоолыг “К банк” ХХК-д барьцаалсан байна.

Нэхэмжлэгчийг 2016 онд 175 тоот авто зогсоолын өмчлөх эрхийг бүртгүүлэхээр улсын бүртгэлийн байгууллагад хандах үед уг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх “МК” ХХК-ийн нэр дээр 2010 оны 05 сард бүртгэгдсэн байсан бөгөөд уг өмчлөх эрхийг 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр “К банк” ХХК-д барьцаалсан нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 28 дугаар зүйлийн 28.1; УБЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5.4, ИХ-ийн 182 дугаар зүйлийн 182.1 (түүнтэй холбоотой бусад эрх) дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэн байжээ.

Тиймээс хариуцагчаас мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9-д зааснаар мэдүүлгийг хүлээн авахаас татгалзсаныг захиргааны хууль бус үйлдэл гэж дүгнэх боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т зааснаар 175 тоот автомашины зогсоолын өмчлөгчийн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт хийхийн өмнө үүний улмаас барьцааны эрх нь хөндөгдөх “К банк” ХХК-аас зөвшөөрөл ирүүлсэн тохиолдолд бүртгэхийг улсын бүртгэлийн байгууллагад хуулиар үүрэг болгосон байна гээд маргаж буй 175 тоот автомашины зогсоолын өмчлөгчөөр Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны

шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 776 дугаар шийдвэрээр Ч-ыг тогтоосон нь барьцаалагчийн зөвшөөрөлгүй улсын бүртгэлийг өөрчлөх үндэслэл болохгүй гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, ДЗШШ 175 тоот зогсоолыг өмчлөх эрх 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “МК” ХХК-д үүссэн, барьцааны эрх 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр “К банк” ХХК-д үүссэн. Үүнээс хойш буюу 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Иргэний хэргийн шүүхийн 776 дугаар шийдвэрээр Ч-г өмчлөгчөөр тогтоосон нь барьцаалагчийн зөвшөөрөлгүй улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, Ч-г өмчлөгчөөр бүртгэх үндэслэл болохгүй гэж дүгнэсэн байна.

Харин гуравдагч этгээдийн давж заалдах гомдолд “... тухайн орон сууц болон автомашины зогсоолын улсын бүртгэлд “К банк”-ны барьцааны эрх 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн бүртгэлтэй байсан” гэж дурдсан. Анхан шатны шүүхийн шийдвэрт дурдсанаас үзэхэд Ч нь 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “МК” компанитай “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах худалдан авах гэрээ” байгуулж орон сууц болон автомашины зогсоолын үнийг бүрэн төлсөн байна. Үүнийг хэрхэн дүгнэсэн нь тодорхойгүй байна.

Магадлалын “Хянавал” хэсэгт “...гуравдагч этгээд “К банк” ХХК-ийн давж заалдах гомдлын хүрээнд хэргийг хянаж анхан шатны шүүхийн шийдвэрийн “... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолтой холбогдох хэсгийг” хүчингүй болгуулах гомдлыг хангаж, шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэв” гэж дурдаад “Тогтоох” хэсэгт “... 84 дүгээр шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтын “нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь” гэснийг “нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг” гэж өөрчилж, “... байрны зоорины давхарт байрлах ... тоот автомашины зогсоолыг” гэсэн хэсгийг хасаж, “....175 тоот автомашины зогсоолын үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг Ч-ын улсын бүртгэлд

бүртгэж, гэрчилгээ олгохыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгах” шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай.” гэсэн 2 дахь заалт нэмж”, “... тус тус өөрчилж, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээж, гуравдагч этгээд “К банк” ХХК-ийн давж заалдах гомдлыг хангасугай” гэжээ.

Дүн шинжилгээ:

ДЗШШ-ийн магадлалаар ... тоот автомашины зогсоолыг Ч-ын нэр дээр үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгохыг даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон өөрчлөлт оруулснаар Анхан шатны шүүхийн шийдвэрийн орон сууцыг Ч-ын нэр дээр үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгохыг даалгасан хэсэг хүчинтэй хэвээр үлдэж байна. Магадлалд гуравдагч этгээдийн давж заалдах гомдлын зарим хэсгийг хангаагүй үндэслэлд дүгнэлт хийгээгүй, гуравдагч этгээд зөвхөн ... тоот автомашины зогсоолтой холбоотой гомдол гаргасан мэт ойлгогдохоор дүгнэжээ.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн “Хэрэгт хамааралтай бөгөөд хуульд заасан арга хэрэгслээр олж авсан, хэрэгт авагдсан ба шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж, шүүхээр судлан шинжлэгдсэн нотлох баримтаар хэрэгт ач холбогдол бүхий бүх нөхцөл байдал тогтоогдсон хийгээд эдгээр нөхцөл байдлын талаар шүүхийн бүрэн, бодитой дүгнэлтийг агуулсан шийдвэр үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангана”²⁰ гэснийг хангаагүй гэж дүгнэж байна.

Түүнчлэн анхан шатны шүүхийн шийдвэрт “Мөн Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын дэд дарга бөгөөд Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын ерөнхий бүртгэгчийн 2004 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 50 дугаар журмын 1 дүгээр хавсралтаар

²⁰ “Шүүхийн шийдвэрийн тухай” УДШ-ийн тогтоолын 2.2. 2006 он. Дугаар 21.

баталсан “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийг хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.10-д “... Дуусаагүй барилгын өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд анхны удаа бүртгүүлснээс хойш тухайн барилгыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулах хүртэл гүйцэтгэлийн явцаар эд хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн гэсэн үндэслэлээр эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно”, 4.11-д “...Дуусаагүй барилгыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дуусгаж, ашиглалтад оруулсан тохиолдолд дуусаагүй барилгын өмчлөх эрхийн хувийн хэрэг, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрчилгээг сольж олгоно” гэж тус тус зохицуулж өгсөн байх бөгөөд дуусаагүй барилгыг 2 удаа бүртгэж, дуусаагүй 90 хувийн гүйцэтгэлтэй барилгад дахин гэрчилгээ олгосон нь дээрх журамд нийцээгүй байна” гэж дүгнэсэн ба үүнд дараагийн шатны шүүхүүд ямар нэгэн дүгнэлт хийгээгүй байна.

Магадлалын бичвэрийн хувьд ойлгомжтой, тодорхой, бүрэн байж чадаагүй, үндэслэх хэсгийг “Хянавал” гэж тодорхойлсон ба “Шүүх шийдвэрийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй...”²¹ гэснийг хангаагүй байна.

Харин УДШ-ийн 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 270 дугаар тогтоолд: Ч нь 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “МК” ХХК-тай орон сууц болон автомашины зогсоолыг худалдан авахаар “Орон сууц захиалагчтай байгуулах худалдах худалдан авах гэрээ”-г байгуулжээ. Гэвч нэхэмжлэгчийн байгуулсан гэрээнээс өмнө “МК” ХХК нь 2007 оны 8 дугаар сарын 01-ний өдөр “К банк” ХХК-тай “Зээлийн гэрээ”, “Зээлийн барьцааны гэрээ”-г тус тус байгуулсан байх бөгөөд улмаар барьцаа хөрөнгөд Хан-Уул дүүрэг...-ийн урд талд зээлээр санхүүжүүлэн барих 5 блок, 120 айлын орон сууцны

²¹ “Шүүхийн шийдвэрийн тухай” УДШ-ийн тогтоолын 3.3. 2006 он. Дугаар 21.

барилга, газар, дэд бүтэц, 205 автомашины зогсоол болон бусад хөрөнгө багтжээ.

Дараа нь гэрээний талууд 2010 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр дээрх 2007 оны “Зээлийн барьцааны гэрээ”-г шинэчлэн байгуулахдаа барьцаа хөрөнгөд ... байрны автомашины зогсоолыг барьцаалсан байх бөгөөд түүнд нэхэмжлэгчийн ... хотхоны ... байрны зоорины давхарт байрлах ...тоот автомашины зогсоол орсон байна. Харин нэхэмжлэгчээс өмчлөгчөөр бүртгэхийг шаардаж буй ... хотхоны ... тоотод байрлах 4 өрөө орон сууцыг “МК” ХХК нь 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “У банк” ХХК-тай байгуулсан “Зээлийн гэрээ”-ний үүргийн гүйцэтгэлд барьцаалжээ.

Дээрхээс дүгнэвэл, автомашины зогсоолын хувьд “МК” ХХК нь дуусаагүй барилгын өмчлөгч байх үедээ буюу нэхэмжлэгчтэй гэрээ байгуулахаас өмнө “К банк”-ны барьцаанд тавьсан бол, харин орон сууцны хувьд тэрээр нэхэмжлэгчид худалдсанахаа дараа “У банк” ХХК-ийн барьцаанд тавьжээ” гэж ойлгомжтой, цэгцтэй дүгнэлт хийсэн нь ДЗШШ-ийн шийдвэрийн дутагдалтай байдлыг залруулсан шинжтэй болжээ.

Жишээ 7:²² *Баянзүрх дүцргийн 1 дүгээр хороо, ... гудамж, ... хороолол, 103 дугаар байрны 304 тоот орон сууц, ... тоот гараашийг Б.Г-ын нэр дээр бүртгэж, гэрчилгээ олгохыг даалгах нэхэмжлэлтэй хэрэг.*²³

Хэргийн үйл баримт:

Б.Г нь “Э” ХХК-тай 2008 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Орон сууц захиалгаар бариулах” тухай гэрээ байгуулж,

²² Энэхүү шийдвэр нь шүүхийн шийдвэрийн цахим сан <https://www.shuukh.mn> -д хүчинтэй төлөвт байгаа бөгөөд үүнтэй холбоотой дараагийн шатны шүүхийн шийдвэр олдоогүй болно. Жишээ 4-ийг харна уу.

²³ НЗХАШШ, 2017 оны 08 дугаар сарын 28. Дугаар 632.

Баянзүрх дүүргийн ... дугаар байрны ... тоот орон сууц, ... тоот зогсоолыг авахаар тохирсон. 2008 оны 05 дугаар сарын 20-ны өдөр төлбөрийг бүрэн барагдуулсан. Үүнээс хойш орон сууц, зогсоолыг ашиглаж байгаа, зохих баримтыг бүрдүүлэн удаа дараа улсын бүртгэлийн байгууллагад хандсан боловч өмчлөх эрхийг бүртгэхээс татгалзаж байгаа тул бүртгэхийг даалгаж өгнө үү гэж нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч Улсын бүртгэлийн байгууллага: Уг барилгыг 60 хувийн гүйцэтгэлтэй байхад нь “Э” ХХК өөрийн өмчлөлд бүртгүүлж, “З банк” болон БНСУ-ын “Х банк”-нд барьцаалан, барьцаат зээлийн гэрээг бүртгүүлсэн. НШШГА болон цагдаагийн байгууллагаас удаа дараагийн албан бичгээр захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн. ЭХӨЭТХЭХБЭУБТХийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна”, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.10, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын Ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийхийг хориглоно” гэж заасан тул барьцаалагчийн зөвшөөрөл, НШШГА болон цагдаагийн байгууллагын эрх сэргээсэн тухай албан бичиг ирээгүй байхад иргэн Б.Г-ийн өмчлөлд бүртгэх боломжгүй хэмээн маргасан.

Шийдвэрлэсэн байдал:

“ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.9, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтад тус тус заасныг баримтлан...” нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон.

Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт: “Туравдагч этгээд “Э” ХХК шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлийн хариу тайлбартаа: “Иргэн Б.Г нь “Э” ХХК-тай 2008 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр “Орон сууц худалдах худалдан авах тухай гэрээ” байгуулсан ба энэхүү гэрээний дагуу төлбөрөө бүрэн төлсөн. Иймд ... нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрч байна” гэснийг дурдсан.

Мөн шийдвэрийн үндэслэх хэсэгт “Нэхэмжлэгч Б.Г нь 2008 оны 04 дүгээр сарын 09 ний өдөр 77 дугаартай “Орон сууц захиалгаар бариулах гэрээ”-г “Э” ХХК -ийг төлөөлж К, “З банк” ХХК-г төлөөлж Д нартай тоот байр болон тоот автомашины зогсоолыг захиалан бариулахаар байгуулж, гэрээний үнийг 100 хувь төлж барагдуулсан байна” гэж дүгнэсэн. Дээрхээс үзэхэд Б.Г нь тухайн орон сууц болон гараашийг өмчлөгч мөн эсэх талаар маргаангүй байна.

Гэтэл шүүх “ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан “Тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болохыг баттай нотолсон баримт байхгүй бол”, мөн зүйлийн 14.1.9-д заасан “Мэдүүлэгт дурдсан, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан эрхийг урьд нь өөр этгээдийн нэр дээр эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тэр нь хүчинтэй байгаа бол мэдүүлгийг хүлээн авахаас татгалзаж буцаана”, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно”, 18.1.8-д “Улсын бүртгэлд өмнө бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох” гэж тус тус зааснаас үзвэл хариуцагч захиргааны байгууллагаас мэдүүлгийг буцааж, бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүй хууль зөрчөөгүй гэж шүүх үзлээ.

Түүнчлэн нэхэмжлэгч хууль ёсны өмчлөгч болохыг тогтоолгохоор Иргэний хэргийн шүүхэд хандаагүй, ингэснээр тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болох нь баттай тогтоогдоогүй гэж үзэхээр байх тул “...Эм” ХХК-ийн өмчлөлд

бүртгэгдсэн тухайн бүртгэл хууль ёсны бөгөөд хүчинтэй... эрх бүхий байгууллагуудаас шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосон” гэсэн үндэслэлээр нэхэмжлэгчийн өмчлөлд бүртгэхээс татгалзсан хариуцагчийн үйлдлийг буруутгах үндэслэлгүй, энэ нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол...” мэдүүлгийг хүлээн авахаас татгалзана гэж заасантай нийцэж байна” гэж дүгнэжээ.

Дүн шинжилгээ:

Талууд өмчлөлийн талаар маргаагүй, иргэний шүүхэд хандаагүй байхад шүүх “өмчлөгч болох нь баттай тогтоогдоогүй гэж үзэхээр байх тул “Э” ХХК-ийн өмчлөлд бүртгэгдсэн тухайн бүртгэл хууль ёсны бөгөөд хүчинтэй... эрх бүхий байгууллагуудаас шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосон” гэсэн үндэслэлээр нэхэмжлэгчийн өмчлөлд бүртгэхээс татгалзсан хариуцагчийн үйлдлийг буруутгах үндэслэлгүй, энэ нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол...” мэдүүлгийг хүлээн авахаас татгалзана гэж заасантай нийцэж байна” гэсэн нь учир зүйн алдаатай, эргэлзээ төрүүлэхүйц дүгнэлт болжээ.

“ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.9-д “Мэдүүлэгт дурдсан, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан эрхийг урьд нь өөр этгээдийн нэр дээр эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тэр нь хүчинтэй байгаа бол мэдүүлгийг хүлээн авахаас татгалзаж буцаана”, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно”, 18.1.8-д “Улсын бүртгэлд өмнө бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох”, 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол

нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэж тус тус заасан. Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Шүүх, арбитр, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр гарсан бол улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийх”, 20.5-д “Өмчлөгчийн эрхийг хязгаарласан этгээдийн шийдвэрээр өөрчлөлт оруулах”-аар заасан байдаг.

Тухайн тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдийн өмчлөлд 60 хувийн гүйцэтгэлтэйгээр бүртгэлтэй, барьцаалагдсан, эрх бүхий этгээдээс эрхийг түдгэлзүүлсэн байгаа бөгөөд энэ нь нэхэмжлэгч Б.Г-ийн өмчлөх эрхтэйг үгүйсгэх нотолгоо болохгүй. Харин Б.Г өмчлөх эрхээ бүртгүүлэхийн тулд “Э” ХХК-ийн өмчлөлийг бүртгэлд өөрчлөлт орсноор хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох барьцаалагч болон эрх түдгэлзүүлсэн этгээдийн зөвшөөрөл, шийдвэрийг авсан байх шаардлагатай байна.

Гэтэл шүүх “өмчлөгч гэдэг нь баттай нотлогдохгүй” гэж дүгнэсэн, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэгт ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол...” гэсэн заалтыг баримталсан нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг²⁴ хангаагүй байна.

Шүүхийн шийдвэрийн бичвэр, найруулгын хувьд шаардлага хангаж байгаа боловч “Орон сууц захиалгаар бариулах” тухай гэрээний оролцогч талууд гэрээний үүрэг бүрэн биелэгдсэн, худалдан авагч тал орон сууц, гараашаа өөрийн эзэмшилд шилжүүлэн авч ашиглаж байгаа, худалдагч тал төлбөр тооцоо

²⁴ “Шүүхийн шийдвэрийн тухай” УДШ-ийн тогтоолын 2.1,2.2. 2006 он. Дугаар 21.

дууссан гэдгийг нотолсон, ингэснээр өмчлөгчийн өмчлөх эрхийн талаар ямар нэг маргаангүй байхад өмчлөх эрхийг заавал Иргэний хэргийн шүүхээр тогтоолгох шаардлагатай мэтээр үзэж дүгнэлт хийсэн нь буруу байна.

Жишээ 8: Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Баянзүрх дүүргийн Бүртгэлийн хэлтсээс Б-ны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргаж өгөхгүй байгаа эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоож, Баянзүрх дүүрэг ... байрлах ... орон сууцны цогцолборын .. дугаар байрны зоорины давхрын ... тоот, ... мкв үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг Б-ийн нэр дээр гаргуулахыг БЗД-ын УБХ-т даалгах шаардлага бүхий захиргааны хэрэг.²⁵

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэгч Б шүүхэд гаргасан нэхэмжлэл болон шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: “Нэхэмжлэгч Б миний бие нь 2010 оны 2 дугаар сарын 01-ний өдөр “Э” ХХК-тай үл хөдлөх эд хөрөнгө “Худалдах, худалдан авах тухай” П/05-14 тоот гэрээ байгуулан Баянзүрх дүүргийн ... байрлах ... орон сууцны цогцолборын ... дугаар байрны .. тоот зоорины давхрын ... мкв талбай бүхий объектыг 1 мкв үнэ нь 148,150 төгрөг байхаар тооцож, нийт 12,000,000 төгрөгөөр худалдан авсан боловч одоог хүртэл уг объектынхоо “Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ”-г гаргуулж авч чадахгүй байна. Учир нь ОӨУБЕГ болон Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст 2012 оноос хойш удаа дараа хандсан боловч янз бүрийн шалтаг шалтгаан тоочсоор миний өмчлөх эрхийн гэрчилгээг гаргаж өгөхгүй олон жил чирэгдүүлж байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох тухай нэхэмжлэл гаргаж байна” гэжээ.

²⁵ НЗХАШШ, 2017 оны 10 дугаар сарын 27. Дугаар 785.

Б болон “Э” ХХК-ийг төлөөлж, Ү нар Баянзүрх дүүргийн ... хотхоны ... дугаар байрны доор байрлах зоорийн давхрын .. мкв талбай бүхий объектыг 2010 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн П/05-14 дугаартай “Зоорийн давхар худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж улмаар “Э” ХХК-ийн захирал Ү 2013 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 121 дүгээр албан бичгээр УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газарт дээрх зоорийн давхрын өмчлөгчөөр Б-г бүртгүүлэх хүсэлт гаргасан байна.

Хариуцагч Баянзүрх дүүргийн Бүртгэлийн хэлтэс “...ут орон сууцыг бүхэлд нь “Э” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн, тоот тус бүрээр нь иргэний өмчлөлд салгаж бүртгэх боломжгүй, “З банк” болон БНСУ-ын “Х банк”-нд барьцаалсан барьцаат зээлийн гэрээ бүртгэлтэй байна ... эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт бүртгэгдсэн орон сууцны барилгыг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, Улсын мөрдөн байцаах газар, Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн албан бичгүүдийн дагуу захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн...тул бүртгэж, өмчлөлд шилжүүлэх боломжгүй” гэж бүртгэхээс татгалзжээ.

Шийдвэрлэсэн байдал:

Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.9, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

Энэхүү маргааныг шийдвэрлэсэн шийдэл ба үндэслэл нь Жишээ 7-той адил байгааг дурдаж байна.

“Э” ХХК нь Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороонд байрлах “Голден вилл” цогцолборын 105 дугаар байрыг 60 хувийн гүйцэтгэлтэйгээр бүхэлд нь 2006 оны 12 дугаар сарын 18-ны өдөр эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт өөрийн өмчлөлдөө бүртгүүлж, улмаар 2007 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр “Э”

ХХК нь “З банк” болон БНСУ-ын “Х банк”-тай дээр дурдсан үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ байгуулсан. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2009 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 1/6542, 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1/13253, 2012 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 2/4309, 2012 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 2/5394, 2012 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 2/969, 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 2/10559, 2013 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 2/2236, 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2/1449 дугаар албан бичгүүдээр уг үл хөдлөх хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн байдаг.

Хариуцагч дээрх үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан.

Шүүх шийдвэр гаргахдаа ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д “Мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол”, 14.1.9-д “Мэдүүлэгт дурдсан, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан эрхийг урьд нь өөр этгээдийн нэр дээр эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тэр нь хүчинтэй байгаа бол”, УБЕХ (2009 он)-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д “ Улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох” гэсэн заалтыг баримталсан. Тодруулбал, нэхэмжлэгч Б-ийн өмчлөх эрх хангалттай нотлогдохгүй байна мөн уг үл хөдлөх хөрөнгө өөр этгээдийн өмчлөлд бүртгэлтэй, тэр нь хүчинтэй байна гэж дүгнэсэн.

Дүн шинжилгээ:

Нэхэмжлэгч өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгож (өөрөөр хэлбэл, бүртгэхээс татгалзсан үндэслэлийг эс зөвшөөрсөн), бүртгэж, гэрчилгээ гаргахыг даалгуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Хариуцагч өмнө бүртгэгдсэн бүртгэлээс нэхэмжлэгчийн шаардаж буй хэсгийг салгаж бүртгэх боломжгүй,

учир нь барьцааны гэрээний бүртгэл, эрх хязгаарласан тусгай тэмдэглэлүүд хүчинтэй байгаа гэсэн үндэслэлээр бүртгэл хийхээс татгалзсан байдаг.

Шүүх “ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.9-д заасан мэдүүлэгт дурдсан, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан эрхийг урьд нь өөр этгээдийн нэр дээр эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тэр нь хүчинтэй байгаа бол мэдүүлгийг хүлээн авахаас татгалзаж буцаана, УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно, 18.1.8-д улсын бүртгэлд өмнө бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох” гэж тус тус зааснаас үзвэл хариуцагч захиргааны байгууллагын бүртгэхээс татгалзсан эс үйлдэхгүйг хууль зөрчөөгүй гэж үзлээ” гэж дүгнэсэн нь үндэслэл бүхий байна. Харин “ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болохыг баттай нотолсон баримт байхгүй бол” гэснийг үндэслэл болгосон, “Түүнчлэн нэхэмжлэгч шүүх хуралдаан дээр ...уг эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгохоор иргэний хэргийн шүүхэд хандаж байгаагүй ... гэж тайлбарласнаас үзэхэд нэхэмжлэгч Б нь ... мкв талбай бүхий объектын өмчлөгч болох нь тогтоогдохгүй байна” гэж дүгнэсэн нь ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлийн 106.5-д “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй” гэсэнтэй нийцээгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна. Учир нь өмчлөх эрхийн талаар маргаагүй, “Тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч болохыг баттай нотолсон баримт байхгүй” гэсэн үндэслэлээр бүртгэхээс татгалзаагүй.

Хариуцагчийн барьцааны гэрээний бүртгэл болон эрх хязгаарласан тусгай тэмдэглэлүүд хүчинтэй байгаа тул бүртгэх боломжгүй гэсэн татгалзлын үндэслэлд шүүх ямар

нэг дүгнэлт өгөөгүй. Тухайлбал, хариуцагчийн тайлбарт “ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” хэмээн заасан байдаг. “Э” ХХК нь тухайн орон сууц болон зогсоолын барилгыг барьцаалан “З банк” болон БНСУ-ын “Х банк”-аас зээл авсан бөгөөд тухайн барьцаат зээлийн гэрээ нь өнөөдрийн байдлаар албан ёсоор дуусгавар болоогүй байна” гэж тодорхой дурдсан.

Гэтэл шүүхийн шийдвэрийн “Үндэслэх нь” хэсэгт: “Иймд “Э” ХХК-ийн өмчлөлд бүртгэгдсэн тухайн бүртгэл хууль ёсны бөгөөд хүчинтэй, эрх бүхий байгууллагуудаас шилжилт хөдөлгөөн хийхийг хориглосон гэсэн үндэслэлээр нэхэмжлэгчийн өмчлөлд бүртгэхээс татгалзсан хариуцагчийн үйлдлийг буруутгах боломжгүй, энэ нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч нь тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлох баримт байхгүй бол... мэдүүлгийг хүлээн авахаас татгалзана гэж заасантай нийцэж байна” хэмээн логик алдаатай дүгнэлт хийжээ.

Мөн “...Энэхүү шүүхийн шийдвэр нь Б-ыг Баянзүрх дүүргийн ... хотхоны .. дугаар байрны .. тоот зоорины давхрын ... мкв талбай бүхий үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгоход саад болохгүйг дурдах нь зүйтэй” гэжээ.

Энэ тохиолдолд “Шүүх, тухайн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч гэдгийг баттай нотлохын тулд Иргэний шүүхээр өмчлөгч мөн болохоо тогтоолгох шаардлагатай гэж ойлгогдохоор дүгнэсэн нь үндэслэлгүй бөгөөд харин хариуцагчийн татгалзлын үндэслэл нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн

14.1.1 дэх заалтаас гадна мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т “Үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай шийдвэр гарсан;” бол тусгай тэмдэглэл хийх”, 20.3-д “Энэ хуулийн 20.1.2-т заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна” гэсэн зохицуулалттай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт хийсэн бол шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх²⁶ хуулийн шаардлагад илүү нийцэх байжээ” гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Шүүхийн шийдвэрийн бичвэр, найруулгын хувьд шаардлага хангаж байгаа боловч өмчлөгчийн өмчлөх эрхийн талаар ямар нэг маргаангүй, “Өмчлөх эрхийг баттай нотлох баримт байхгүй” гэсэн үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаагүй байхад өмчлөх эрхийг заавал иргэний хэргийн шүүхээр тогтоолгох шаардлагатай мэтээр үзэж дүгнэлт хийсэн нь буруу байна.

Жишээ 9: “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн улсын бүртгэл болон гэрчилгээг хүчингүй болгож, иргэн Л-ийг өмчлөгчөөр бүртгэж гэрчилгээ олгохоос татгалзсаныг хууль бус болохыг тогтоон, дээрх автомашины зогсоолыг Л-ийн өмчлөлд бүртгэж, гэрчилгээ олгохыг ОӨУБЕГ-т даалгах шаардлага бүхий захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн НЗХАШШ-ийн 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 120 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон гуравдагч этгээд “Кб” ХХК-ийн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлоор, Л-ийн нэхэмжлэлтэй, ОӨУБЕГ-т холбогдох захиргааны хэрэг.²⁷

²⁶ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дах заалт.

²⁷ ЗХДЗШШ-ийн 2018 оны 05 сарын 10-ны өдрийн 221/МА2018/0278 тоот магадлал

Хэргийн үйл баримт:

НЗХАШШ “МК” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн улсын бүртгэл болон гэрчилгээг хүчингүй болгож, иргэн Л-ийг өмчлөгчөөр бүртгэж гэрчилгээ олгохоос татгалзсаныг хууль бус болохыг тогтоон, дээрх автомашины зогсоолыг Л-ийн өмчлөлд бүртгэж, гэрчилгээ олгохыг ОӨУБЕГ-т даалгах шаардлага бүхий ОӨУБЕГ-т холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцээд бүртгэж, гэрчилгээ олгохоос татгалзсан үйлдлийг хууль бус болохыг тогтоож, нэхэмжлэгчийн өмчлөлд бүртгэж, гэрчилгээ олгохыг даалгаж шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийг хариуцагч ОӨУБЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч болон гуравдагч этгээд “Кб” ХХК-ийн төлөөлөгч эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан.

Нэхэмжлэгч Л нь: “2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “М” ХХК-тай 80 дугаартай Орон сууц захиалан гүйцэтгэх гэрээг байгуулсны үндсэн дээр Хан-Уул дүүргийн ... хотхоны ... тоот орон сууцыг тус байрны зоорины давхрын .. тоот автомашины зогсоолын хамт захиалан гэрээний үнийг бүрэн төлснөөр “М” ХХК-тай тооцоо нийлсэн акт үйлдэж, орон сууц болон авто машины зогсоолыг өөрийн эзэмшил, ашиглалтад хүлээн авсан. “М” ХХК нь нэхэмжлэгчийн орон сууцны гэрчилгээг гарган өгсөн атлаа, автомашины зогсоолын өмчлөх эрхийн гэрчилгээ болон холбогдох материалыг гаргаж өгөөгүй тул шүүхэд автомашины зогсоолын өмчлөгчөөр тогтоолгох нэхэмжлэл гаргасан бөгөөд Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 101/ШШ2016/0175 дугаартай шүүгчийн захирамжаар хариуцагчийн зөвшөөрлийг баталсан. Үүний дагуу Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн газарт хандахад 2016 оны 03 дугаар сарын 20-ны өдөр “Кб” ХХК-ийн барьцаанд байгаа тул бүртгэх боломжгүй гэсэн татгалзсан хариуг өгсөн. ... “М” ХХК-ийн өмчлөлд бүртгэгдсэн Хан-Уул дүүргийн ... хотхоны байрны ... тоот автомашины зогсоолын

... дугаартай улсын бүртгэл болон түүнийг баталгаажуулан олгосон өмчлөх эрхийн улсын бүртгэлийн ... дугаартай гэрчилгээг хүчингүй болгож, өмчлөгчөөр иргэн Л-ийг бүртгэж, гэрчилгээ олгохыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгаж өгнө үү” гэж нэхэмжлэл гаргасан.

Хариуцагч: 90 хувийн гүйцэтгэлтэй авто зогсоолыг 2010 оны 05 дугаар сарын 13-ны өдөр “М” ХХК-ийн өмчлөлд бүртгэж, гэрчилгээ олгосон байна. “КБ” ХХК-тай байгуулсан 2007 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Т07/141 тоот зээлийн гэрээ, 2007 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн нэмэлт гэрээ, 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн нэмэлт гэрээ, 2010 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн нэмэлт гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар дээрх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан 2010 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Т07/141 тоот барьцааны гэрээ бүртгэлтэй байна.

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2010 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 56 тоот тогтоол болон Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2010 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/10599 тоот албан бичгээр “М” ХХК-ийн өмчлөлийн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн тойруу, тоот байруудыг битүүмжилсэн байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2/16085 тоот албан бичгээр захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн.

Иймээс “УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д зааснаар улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгохыг хориглоно, 18 дугаар зүйлийн 18.1.10-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийхийг хориглоно”, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20.3,

20.5-д заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр, өмчлөгчийн эрхийг хязгаарласан этгээдийн шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна, 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэж тус тус заасны дагуу өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэх үндэслэлгүй байна” гэж маргасан.

НЗХАШШ хэргийг шийдвэрлэхдээ “Барьцааны эрхийг бүртгэсэн нь буруу, маргаан бүхий автомашины зогсоол нь захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн шийдвэрүүдэд хамааралгүй, өмчлөгчөөр бүртгэлтэй байгаа “МК” ХХК нь шилжүүлэн бүртгэхийг зөвшөөрсөн” гэж дүгнэсэн.

Шийдвэрлэсэн байдал:

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.8 болон ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.9, 19 дүгээр зүйлийн 19.2-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Л-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, хариуцагч ОӨУБЕГ болон гуравдагч этгээд “Кб” ХХК-ийн давж заалдах гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

ЗХДЗШШ нь “Өмнө бүртгэгдсэн өмчлөх эрх, барьцааны гэрээг бүртгэсэн бүртгэл хүчинтэй, өмчлөх эрхийн бүртгэл өөрчлөгдсөнөөр эрх хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөх барьцаалагчийн зөвшөөрлийг аваагүй тохиолдолд уг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэлийг нэхэмжлэгч Л-ийн нэр дээр бүртгэхээс татгалзсан хариуцагчийн үйлдэл нь хуульд нийцсэн байна.

Хэдийгээр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн

Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 101/ШШ2016/01754 дүгээр захирамжаар хариуцагчийн зөвшөөрлийг баталсан ч маргаж буй үл хөдлөх эд хөрөнгийн анхны өмчлөгчөөр “МК” ХХК-ийг бүртгэсэн бүртгэл хүчинтэй, уг үл хөдлөх хөрөнгийг гуравдагч этгээдийн барьцаанд бүртгэсэн бүртгэл мөн хүчинтэй байхад нэхэмжлэгчийн өмчлөлд бүртгэхийг хариуцагчид даалгаж шийдвэрлэх боломжгүй” гэж дүгнэсэн.

Дүн шинжилгээ:

ДЗШШ нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан үндэслэл хуульд нийцэж байгаа эсэхийг үнэлсэн байх бөгөөд үндэслэл бүхий зөв дүгнэлт өгсөн байна.

Гэвч уг маргаанд ач холбогдол бүхий зарим баримтыг үнэлээгүй орхисон байна. Тухайлбал: 1/. Нэхэмжлэгч Л нь 2007 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “МК” ХХК-тай “Орон сууц, гарааш захиалгаар гүйцэтгэх гэрээ” байгуулж, төлбөрийг бүрэн төлсөн. 2/. “МК” ХХК нь 2007 оны 08 дугаар сарын 01-ний өдөр Т07/141 тоот гэрээгээр автомашины 205 зогсоолын дуусаагүй барилгыг барьцаалсан. 3/. 2010 оны 09 дүгээр 02-ны өдөр зээлийн барьцааны гэрээг шинэчлэн байгуулсан ба энэ үед автомашины зогсоолын барилгыг 90 хувийн гүйцэтгэлтэй болгон улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, гэрчилгээг шинэчлэн олгосон. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч Л-тэй гэрээ байгуулж, төлбөрийг авснаас хойш “МК” ХХК-ийн өмчлөлд 90 хувийн гүйцэтгэлтэйгээр бүртгэж, барьцааны гэрээг шинэчлэн байгуулсан байна. Мөн Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Барьцаалагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна”²⁸ гэсэн зохицуулалт энэ үед хүчингүй болсон байсан.

²⁸ Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

Шүүхийн шийдвэр бичвэрийн хувьд цэгцтэй, ойлгомжтой, шүүхийн шийдвэрт тавих формаль шаардлагыг хангасан байна.

Жишээ 10: Хан-Уул дүүрэг ... дугаар байрны ... тоот орон сууц болон ... тоот автомашины зогсоолын үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг Э-ийн нэр дээр гаргуулахыг ХУД-ын УБХ-т даалгах шаардлага бүхий захиргааны хэрэг.²⁹

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэлд дурдсанаар: “Э нь 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр “М” ХХК-ийн Хан-Уул дүүрэг... хаягт орших .. айлын орон сууцны хотхоны ... тоот ... мкв 3 өрөө, 30 хувийн гүйцэтгэлтэй орон сууцыг ... тоот зогсоолын хамтаар худалдан авахаар тохиролцож, “Захиалгаар орон сууцны барилгын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж, гэрээний дагуу байр болон зогсоолын төлбөрийг бүрэн төлж барагдуулж, улмаар түлхүүрийг гардан авч, орон сууцандаа өнөөдрийг хүртэл амьдарч байна.

“М” ХХК нь дээр дурдсан гэрээний 4.1-д заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй тул Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 183/ШШ2018/01665 дугаартай шийдвэрээр Хан-Уул дүүргийн ...-р байр .. тоот орон сууц, ... тоот зогсоолын хамтаар “У банк”-ны зээлийн барьцаанаас чөлөөлөхийг болон үл хөдлөх эд хөрөнгүүдийн өмчлөх эрхийг Э-д шилжүүлэн өгөхийг “М” ХХК-д даалгасан шийдвэр гаргасан.

²⁹ НЗХАШШ, 2020 оны 09 дүгээр сарын 29. Дугаар 128/ШШ2020/0618

Шүүхийн шийдвэр гарснаас хойш өнөөдрийг хүртэл үл хөдлөх хөрөнгөнүүдийн өмчлөх эрхийн гэрчилгээ гараагүй, иргэн Э-ийн өмчлөх эрх зөрчигдсөөр байсан тул Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандахад 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 7/2677 тоот дугаартай албан бичгээр “дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хандан бүртгүүлэх тухай” хариу өгсөн болно.

Гэтэл Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газраас тусгай тэмдэглэлийг хүчингүй болгосон шийдвэрийг хавсаргах шаардлагатай, мөн “У банк” ХХК-ны барьцаатай хэвээр нь өмчлөх эрхээ бүртгүүлэх боломжтой гэсэн. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас Улаанбаатар хотын банкны барьцаа хөрөнгө тул захиран зарцуулах эрхийг сэргээхгүй гэсэн тус тус хариу өгсөн.”

Хариуцагч улсын бүртгэлийн байгууллага: Хан-Уул дүүргийн ... тоот 30 хувийн гүйцэтгэлтэй орон сууцны барилга нь 2011 онд “М” ХХК-ийн өмчлөлд бүртгэгдэж, мөн онд “У банк”-тай барьцааны гэрээ байгуулж, барьцаат зээлийн гэрээг бүртгүүлсэн байна.

Өнөөдрийн байдлаар дээрх эд хөрөнгийн барьцааны гэрээний бүртгэл дуусгавар болоогүй байгаа бөгөөд дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны шийдвэрийн дагуу Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2014 оны 1/11612, 2017 оны 3/18537, 2018 оны 4/3591 тоот албан бичгээр захиран зарцуулах эрхийг тус тус түдгэлзүүлсэн байна.

ЭХЭУБТХ³⁰-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Барьцаалбарын хууль ёсны эзэмшигч, эсхүл барьцаалагчийн хүсэлт, эсхүл шүүх, арбитрын шийдвэрийг үндэслэн барьцааны эрхийг дуусгавар болгоно” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.4-д “Шүүх, арбитр,

³⁰ 2018 оны 11 дүгээр сарын 01-ээс хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн.

прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр гарсан бол тусгай тэмдэглэл хийнэ” гэж; 30.5-д “Энэ хуулийн 30.1.4-д заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн тусгай тэмдэглэлийг хүчингүй болгоно” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1.1-д “Бүртгүүлэхээр мэдүүлсэн эрх нь энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан тусгай тэмдэглэлээр хориг тавьсан эрх, хязгаарын хүрээнд хамаарч байгаа бол улсын бүртгэгч бүртгэхээс татгалзана” гэж заасан тул иргэн Э-ийн өмчлөх эрхийг өнөөдрийн байгаа нотлох баримтын хүрээнд барьцаагүйгээр бүртгэх боломжгүй юм...” гэжээ.

Гуравдагч этгээд “У банк” ХХБ шүүхэд бичгээр ирүүлсэн тайлбартаа: “...М” ХХК нь “У банк”-тай 2011 оны 7 дугаар сарын 27-ны өдөр №ЗГ0001/110727 тоот “Зээлийн гэрээ”, №ЗБГ0001/110727 тоот “Зээлийн барьцааны гэрээ”, 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр №ЗНГ0001/111124(1) тоот “Зээлийн нэмэлт гэрээ”, №ЗБГ0002/111124 тоот “Зээлийн барьцааны гэрээ”-үүдийг байгуулан 3,476,493,640.00 төгрөгийг сарын 1.35 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатайгаар зээлж авсан.

Дээр дурдсан барьцааны гэрээний дагуу нэхэмжлэлд дурдагдаж буй ... тоот хаягт байрлах ... мкв талбай бүхий ... өрөө орон сууц, мөн байрны ... тоот хаягт байрлах автомашины зогсоол нь банкны барьцаанд бүртгэлтэй хэвээр байгаа бөгөөд дээрх шүүхийн шийдвэрийн дагуу албадан гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр заавал биелэгдэнэ. “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.1 “...барьцааны зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлнэ”-д зааснаар барьцааны зүйлийн

өмчлөгч солигдсон нь барьцааны эрх дуусгавар болох, хүчингүй болох үндэслэлгүйг дурдах нь зүйтэй байна.

Иймд, нэхэмжлэгч Э нь Улсын бүртгэлийн ... дугаартай, Хан-Уул дүүрэг ... хотхоны ... дугаар байрны ... тоот хаягт байрлах ... мкв талбай бүхий 3 өрөө орон сууцны болон мөн байрны ... тоот хаягт байрлах авто зогсоолын өмчлөх эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр шилжүүлэн авсан нь уг үл хөдлөх хөрөнгүүдийг барьцаанаас чөлөөлөх үндэслэл болохгүй талаар шүүхийн шийдвэрт дурдаж өгнө үү...” гэжээ.

Шийдвэрлэсэн байдал:

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1,18.1.8,18.1.10, 19 дүгээр зүйлийн 19.2, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.2, 20.1.4, 20.3, 20.5-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Э-ээс ХУД-ын УБХ-т холбогдуулан гаргасан “Хан-Уул дүүрэг ... дугаар байрны ... тоот орон сууц болон ... тоот зогсоолыг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг Э-ийн нэр дээр гаргуулахыг ХУД-ын УБХ-т даалгах тухай” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон.

“М” ХХК-ийг Хан-Уул дүүргийн ... дугаарт байршилтай аялал жуулчлал цогцолборын зориулалттай 3,564 мкв талбайтай, 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй үл хөдлөх эд хөрөнгийн хууль ёсны өмчлөгчөөр эрхийн улсын бүртгэлийн ... дугаарт бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн ...дугаар гэрчилгээг 2011 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хариуцагчаас олгосон байна.

“У банк” ХХК (цаашид ХХБ) “М” ХХК-тай ... сая төгрөгийг ... зээлдэхээр харилцан тохиролцож 2011 оны 7 дугаар сарын 27-ны өдөр ЗГ0001/110727 дугаар гэрээг байгуулсан ба мөн өдрийн зээлийн барьцааны ЗБГ0001/110727 дугаар гэрээгээр

эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн ... дугаартай Хан-Уул дүүргийн ... дугаарт байршилтай аялал жуулчлал цогцолборын зориулалттай 3,564 мкв талбайтай, 30 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилгын болон 2,717 мкв талбайтай, 95 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй автомашины зориулалттай барилгын гэрчилгээ болон ирээдүйд хийгдэх гүйцэтгэлийн хамт барьцаалжээ.

Харин иргэн Э нь “М” ХХК-тай 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Хан-Уул дүүргийн ... хаягт орших ... орон сууцны хотхоны ... тоот, ... м.кв, 3 өрөө, 30 хувийн гүйцэтгэлтэй орон сууц болон ... тоот автомашины зогсоолын хамт худалдаж авахаар “Захиалгаар орон сууцны барилгын ажил гүйцэтгэх” №1А/17 дугаар гэрээг байгуулсан байх бөгөөд уг гэрээний дагуу Э орон сууц, автомашины зогсоолын төлбөрийг төлсөн болох нь “М” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 1А/17 дугаар “Төлбөр барагдуулсан тухай” тодорхойлолтоор тогтоогдож байна.

Гэвч хэрэгт авагдсан нотлох баримтаас үзвэл нэхэмжлэгч Э нь 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр “М” ХХК-тай “Захиалгаар орон сууцны барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан нь цаг хугацааны хувьд “М” ХХК-ийн өмчлөх эрх, түүнчлэн “ХХ банк” ХХК-ийн барьцааны эрх үүссэнээс хойш байгуулсан аж.

Өөрөөр хэлбэл, “М” ХХК нь маргаж буй үл хөдлөх хөрөнгүүдийн өмчлөгч байх үедээ буюу нэхэмжлэгчтэй гэрээ байгуулахаас өмнө эдгээр хөрөнгийг зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлд “ХХ банк”-нд барьцаалсан байна. ... Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 4010 дугаар шийдвэр, мөн шүүхийн 2014 оны 5 дүгээр сарын 07-ны өдрийн 6408 дугаар “Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай” шүүгчийн захирамжийн дагуу “М”

ХХК-ийн буюу түүн дотор нэхэмжлэгч Э-ийн үл хөдлөх хөрөнгийг эрхийн гэрчилгээний хамт битүүмжилжээ. Харин нэхэмжлэгч Э нь дээрх үйл баримтаас хойш Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 102/ШШ2016/00821 дугаар шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 4 дүгээр сарын 01-ний 637 дугаар магадлал, Монгол УДШ-ийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 001/ХТ2016/00621 дугаар тогтоол зэргээр Хан-Уул дүүрэг ... дугаар байр, .. тоот орон сууц болон ... тоот автомашины зогсоолын хууль ёсны өмчлөгчөөр тогтоогдсон болно” гэж дүгнэсэн байна.

Үүнээс үзэхэд шүүх барьцааны эрх болон эрх хязгаарласан үйлдэл нь өмчлөгчийн өмчлөх эрх үүсэхээс өмнө үүссэн гэснийг үндэслэл болгосон байна.

Дүн шинжилгээ:

УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно”, 18.1.8-д “Улсын бүртгэлд өмнө нь бүртгэгдсэн эрх нь хүчинтэй байхад дахин бүртгэж, гэрчилгээ олгох”, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэж тус тус заасны дагуу маргаж буй үл хөдлөх хөрөнгүүд өөр өмчлөгчид бүртгэлтэйн зэрэгцээ барьцааг бүртгүүлсэн улсын бүртгэл хүчинтэй байгаа тохиолдолд нэхэмжлэгч Э-ийн нэр дээр маргаж буй үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг гаргаж өгөхийг даалгах хууль зүйн үндэслэлгүй юм.

Түүнчлэн барьцааны гэрээгээр барьцаалагдсан хөрөнгүүдийн захиран зарцуулах эрхийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/11612 дугаар албан бичгээр түдгэлзүүлсэн байх тул УБЕХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно”, 18.1.10-д “Улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай Улсын ерөнхий бүртгэгч, хууль хяналтын байгууллагын шийдвэрийг зөрчиж улсын бүртгэлд өөрчлөлт, хөдөлгөөн хийх” гэж заасан бүртгэлийн үйл ажиллагаанд хориглох нөхцөл байдал тогтоогдсоны улмаас эрхийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан хариуцагчийн үйлдэл нь хуульд нийцсэн гэж үзнэ. Учир нь ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.2, 20.1.4-д “үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхийн шийдвэр”, “шүүх, арбитр, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарласан шийдвэр” тус тус гарсан тохиолдолд эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийхээр заасны дагуу дээрх үл хөдлөх хөрөнгөд хамаарах шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас өмчлөгчийн эрхийг хязгаарласан шийдвэр гарсан бөгөөд мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д “Энэ хуулийн 20.1.2-т заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна”, 20.5-д “Энэ хуулийн 20.1.4-д заасан үндэслэлээр тусгай тэмдэглэл хийсэн бол өмчлөгчийн эрхийг хязгаарласан этгээдийн шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна” гэж тус тус заасныг хариуцагч хэрэгжүүлэн ажиллажээ” хэмээн дүгнэсэн нь үндэслэлтэй байна.

Харин “Туравдагч этгээд “ХХБ”-ны өмчлөх болон барьцааны эрх нь дээрх байдлаар нэхэмжлэгчийн шаардах эрх үүсэхээс өмнө үүсэж, хүчин төгөлдөр болсон байх тул” гэж дүгнэхдээ уг барилга нь 30 хувийн гүйцэтгэлтэй байхдаа “М” ХХК-ийн өмчлөлд бүртгэгдсэн, “М” ХХК нь 100 хувийн

гүйцэтгэлтэй барилгын өмчлөх эрхийн бүртгэлд дээрх бүртгэлийг шууд хамааруулж болох эсэхэд дүгнэлт хийгээгүй. Үүнтэй холбоотойгоор “Захиалгаар орон сууцны барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан байхад, 2014 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 4010 дугаар шийдвэр, мөн шүүхийн 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 6408 дугаар “Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах тухай” шүүгчийн захирамжийн дагуу үл хөдлөх хөрөнгийг эрхийн гэрчилгээний хамт битүүмжилсэн, нэхэмжлэгч Э нь дээрх үйл баримтаас хойш иргэний хэргийн шүүхээр хууль ёсны өмчлөгчөөр тогтоогдсон гэж дүгнэсэн нь өмчлөгчийн шаардах эрх хэзээ үүссэн талаар тодорхойгүй байдал үүсгэж байна. Энэ нь хэдийгээр захиргааны шүүхийн хянан хэлэлцэх асуудал биш гэж үзэж болох боловч эрх хэзээ үүссэнтэй холбоотой дүгнэлтийг нэгэнт хийж, шийдвэрийн үндэслэл болгож байгаа билээ.

Нэхэмжлэлд “...Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандахад 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 7/2677 тоот дугаартай албан бичгээр “Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст хандан бүртгүүлэх тухай” хариу өгсөн болно...” гэж дурдсан. Мөн хариуцагч ЭХЭУБТХ-ийн холбогдох заалтуудыг үндэслэл болгож нэхэмжлэлд хариу тайлбар өгсөн. Үүнээс үзэхэд улсын бүртгэлд бүртгүүлэхээр хандсан болон бүртгэхээс татгалзсан үйл явдал 2020 онд буюу 2018 оны 11 дүгээр сарын 01-ээс хойш болсон гэж ойлгогдож байна.

Улсын бүртгэлийн багц хууль, түүний дотор УБЕХ, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль 2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэн батлагдаж, 2018 оны 11 дүгээр сарын 01-ээс хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн.

Шүүх дүгнэлт хийх, шийдвэр гаргахдаа хүчин төгөлдөр бус хуулийн заалтуудыг буюу 2009 оны УБЕХ, 2003 оны

ЭХӨӨТХЭХБЭУБТХ-ийн холбогдох заалтуудыг баримталснаар хууль хэрэглээний алдаа гаргаж, шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх³¹ хуулийн шаардлагыг зөрчсөн байна.

Шүүхийн шийдвэр бичвэрийн хувьд цэгцтэй, ойлгомжтой байгаа боловч хүчингүй болсон хуулийг үндэслэл болгосон, баримталсан нь шүүхийн шийдвэрт тавигдах формаль шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

1.3 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧГИЙГ ҮНДЭСЛЭН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛСЭН НЬ БУРУУ ГЭЖ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Жишээ 11: СХД-ийн ... хаягт байрлах орон сууцыг “Х” ХХК-ийн өмчлөлд бүртгэсэн үйлдлийг илт хууль бус болохыг тогтоолгож, гэрчилгээг хүчингүй болгуулах шаардлага бүхий захиргааны хэрэг.³²

Хэргийн үйл баримт:

Нэхэмжлэгч Н, А нарын СХД-ийн ... тоот хаягт байрлах 1 өрөө орон сууцаа өөрийн төрсөн дүү Т, түүний нөхөр А.А нарт Х-аас авч буй зээлийн барьцаа хөрөнгөнд барьцаалуулсан. Зээлээ хугацаанд нь төлж чадаагүйгээс Х нь шүүхэд хандаж нэхэмжлэл гаргасан.

Шүүгчийн 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 120/ШШ2016/01595 дугаартай Зохигчдын эвлэрлийг баталж, зээлийн гэрээний үүрэгт 105,052,616 төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид 341,606 төгрөгийг А.А, Т нараас гаргуулан төлүүлэх, төлбөрөө 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор

³¹ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3 дахь заалт.

³² НЗХАШШ, 2020 оны 11 дүгээр сарын 04. Дугаар 128/ШШ2020/0728

төлж барагдуулаагүй тохиолдолд барьцаа хөрөнгүүд СХД-ийн ... хаягт байрлах, СХД-ийн ... тоот хаягт байрлах орон сууц зэргийг ШШГТ хуульд заасан журмын дагуу худалдан борлуулах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шийдвэрлэсэн.

Шийдвэр гүйцэтгэлийн байгууллагаас 2016 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр төлбөр төлөгчөөс хураан авсан эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлсэн тухай 129/03 тоот тогтоол гаргаж, уг тогтоолдоо шүүгчийн 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01595 тоот шийдвэр, 299 дугаар гүйцэтгэх хуудсыг үндэслэн 105,574,222 төгрөгийн эд хөрөнгө болох СХД-ийн ... тоотын орон сууцыг төлбөр авагч “Х” ХХК-ны ажилтан Л.Б, Б.Г нарт шилжүүлэн өгч байгааг тодорхой тусгасан байдаг.

Нэхэмжлэлд дурдсанаар “1 өрөө орон сууцанд 4 өрөө орон сууцыг хураан авсан тогтоолыг хавсаргаж, “Х” ХХК мэдүүлэг гаргаж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2016 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 3/031030 гэх дугаартай албан бичгийн хамт өгч өөрсдийн нэр дээр бүртгэл хийлгэсэн.”

Хариуцагч УБЕГ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч: “Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гүйцэтгэх ажиллагаа явуулж манайд албан бичиг хүргүүлсэн. Мөн өмчлөх эрхээ шилжүүлж авахаар “Х” ХХК албан бичиг, өмчлөгч А, Н нар тухайн ...1 өрөө орон сууцыг өмчлөх эрхийг “Х” ХХК-ийн нэр дээр бүртгүүлэхийг зөвшөөрсөн гарын үсгийн үнэн зөвийг батлуулсан өргөдөл зэргээр баталгаажиж байна гэж үзэж байна. Мөн хуулийн 14 дүгээр зүйлд “Мэдүүлгээс татгалзах үндэслэл байхгүй бол мэдүүлгийг буцаахыг хориглоно” гэж заасан. Тиймээс хуулийн дагуу бүртгэл хийсэн” гэж маргадаг.

Шийдвэрлэсэн байдал:

ЗЕХ-ийн 47 дугаар зүйлийн 47.1.6, ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 12 дугаар зүйлийн 12.4, 12.5.1, 14 дүгээр зүйлийн 14.1.6, 24 дүгээр зүйлийн 24.4-д заасныг тус тус

баримтлан Н, А нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн.

Шүүх НШШГА-ны албан бичигт маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлсэн тогтоолыг хавсарган ирүүлээгүй, “Х” ХХК-ны зүгээс мэдүүлэг гаргахдаа шилжүүлэн авсан тогтоол, актыг хавсаргаагүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад худалдан борлуулсан, төлбөр авагчид шилжүүлсэн ажиллагаа хийгдээгүй байхад “шүүх арбитрын шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн” гэж дүгнэх боломжгүй бөгөөд ЭХӨЭТХЭХБЭУБТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1-д “... үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх тус бүрийг эрхийн улсын бүртгэлд тусад нь бүртгэж хувийн хэрэг нээх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана” гэж, 17.1.3-д “өмчлөх эрхийг бүртгүүлэх болсон үндэслэл”, 17.1.6-д “Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ” (...өмчлөх эрх шилжиж байгаа бол өмчлөх эрх шилжих болсон хэлцэл, бусад баримт бичигт тусгагдсан үнэ)-ийг тусгах шаардлага хангаагүй байхад уг бүртгэлийг хийсэн нь буруу гэж үзсэн.

Түүнчлэн “Хариуцагчийн тайлбар татгалзлаа үндэслэж буй Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Э-ын 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 1/31030 дугаар албан бичиг, иргэн Н, А нарын Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд гаргасан хүсэлт зэрэг нь “шүүх, арбитрын шийдвэр” гэхийн алинд ч хамаарахгүй, “Х” ХХК-аас улсын бүртгэлийн байгууллагад гаргасан мэдүүлгийн бүрдүүлбэр дутуу, НШШГА-аас ирүүлсэн албан бичигт маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийг шилжүүлсэн тогтоол авагдаагүй, дээрх баримт бичиг нь өмчлөх эрхийг “Х” ХХК-ийн өмчлөлд бүртгэх үндэслэл болох эсэхийг шалгах чиг үүрэг, эрх хэмжээ Улсын бүртгэгчид хуулиар олгогдсон байхад хэрэгжүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл, хавсаргаж ирүүлсэн баримт дутуу буюу 1 өрөө орон сууцыг “Х” ХХК-д шилжүүлж өгсөн тухай акт шаардлагатай байхад эрх бүхий байгууллагын шийдвэр, “Х” ХХК-ийн

мэдүүлэг, холбогдох баримт бичгийг үндэслэн бүртгэсэн гэх тайлбар үндэслэлгүйн дээр Н, А нараас НШШГА-нд хандан гаргасан зөвшөөрөл гэх бичиг нь өмчлөх эрхийг өөрчлөн бүртгэх эрх зүйн үр дагавар үүсгэхгүй, тухайн баримтыг үндэслэн эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, өөр этгээдэд гэрчилгээ олгох эрх хэмжээ улсын бүртгэлийн байгууллагад хуулиар олгогдоогүй болохыг дурдах нь зүйтэй” гэж дүгнэсэн нь хуульд нийцсэн, үндэслэл бүхий дүгнэлт юм.

Дүн шинжилгээ:

Энэхүү шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр болохын зэрэгцээ хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх, цаашлаад захиргааны байгууллагын үйл ажиллагаанд жишиг болохуйц ач холбогдолтой гэж үзэн тайланд оруулсан болно.

Шүүхийн шийдвэр бичвэрийн хувьд цэгцтэй, ойлгомжтой байгаа боловч шийдвэрийн тогтоох хэсгийг үндэслэх хэсгээс зааглаагүй үргэлжлүүлсэн.

1.4 НЭГДСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү судалгааны үр дүнд үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд учирч байгаа бэрхшээл, түүний учир шалтгааныг тодруулахыг зорьсон бөгөөд бэрхшээл учруулж буй асуудлыг тодорхойлсноор хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Сонгож авсан шүүхийн шийдвэрийн 10 тохиолдолд “Өмчлөгчийн эрхийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй эсэх”-д, 1 тохиолдолд “улсын бүртгэлд бүртгэсэн

нь үндэслэлтэй эсэх”-д дүгнэлт өглөө.

Маргаан гарах болсон үндэслэл бүгд ижил буюу:

- 30-60 хувийн гүйцэтгэлтэй дуусаагүй барилга байхад барилгын компанийн өмчлөлд бүртгүүлсэн;
- Барьцаанд тавьсан;
- Эрх бүхий байгууллагаас эрхийг түдгэлзүүлсэн байсан.

Шүүх асуудлыг өөр өөрөөр шийдвэрлэсэн нь нэхэмжлэлийн шаардлага, тохиолдол бүрийн онцлогоос хамаарсан боловч яг адилхан үйл баримтыг өөр өөрөөр дүгнэсэн нь цөөнгүй байна.

Ерөнхийдөө хугацааны хувьд өмнө үүссэн эрхийг хүчинтэй гэж үзэх байдал буюу цаг хугацааны хүчин зүйлийг үндэслэл болгож шийдвэрлэх нь жишиг болжээ.

Дийлэнх тохиолдолд нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдсэн буюу улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан нь үндэслэлтэй гэж дүгнэсэн. Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлийн агуулга дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Барьцаалагчийн зөвшөөрлийг авах буюу өөрөөр хэлбэл барьцааны эрхийг дуусгавар болгох шаардлагатай;
- Эрх түдгэлзүүлсэн этгээдийн шийдвэрээр эрх түдгэлзүүлснийг хүчингүй болгох шаардлагатай;
- Өмнөх өмчлөгчийн (дуусаагүй барилгаар бүртгүүлсэн этгээд) өмчлөх эрх хүчинтэй байгаа тул;
- Өмчлөгч болохыг баттай нотлох баримт байхгүй (өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх хүчинтэй байгаа, иргэний шүүхээр өмчлөгчөөр тогтоолгох шаардлагатай);

Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн үндэслэлүүдийг авч үзвэл:

- Цаг хугацааны хувьд барьцааны эрх үүсэхээс өмнө орон сууц захиалсан гэрээ хийсэн;
- Дуусаагүй барилга байхад бүртгүүлж, барьцаалсан, эрхийг түдгэлзүүлсэн нь 100 хувийн гүйцэтгэлтэй барилгад хамаарна гэх үндэслэлгүй;
- Иргэний шүүхээр өмчлөгч мөн болохыг тогтоосон;
- Өмчлөгчөөр бүртгэсэн ч барьцаалагчийн эрх хэвээр үргэлжлэх гэх мэт.

Түүнчлэн улсын бүртгэгч захиргааны акт гаргах үндэслэл болж байгаа эрх зүйн зохицуулалт зарим талаар тодорхойгүй, уялдаа холбоо хангалтгүй байдал ажиглагдлаа. Жишээлбэл, ИХ-ийн 170 дугаар зүйлийн 170.6-д “Өмчлөгч ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхээ гуравдагч этгээдэд шилжүүлэх хэлцэл хийх бол үүрэг гүйцэтгүүлэгчээс зөвшөөрөл авах үүрэгтэй”³³, 172 дугаар зүйлийн 171.2-т “Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна”³⁴ гэсэн заалтууд, ҮХЭХБтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Барьцаалуулагч үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны зүйлийг бусдын өмчлөлд шилжүүлэхдээ барьцаалагчийн зөвшөөрөл авна”³⁵ гэсэн заалтууд хүчингүй болсон байхад ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн холбогдох зүйл заалтад өөрчлөлт ороогүй. Үүний улмаас ЭХӨТХЭХБЭУБТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Эрхийн улсын бүртгэлд зохих нэмэлт, өөрчлөлт хийхийн өмнө түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөж болох иргэн, хуулийн этгээд буюу төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг заавал

³³ ҮХЦ-ийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

³⁴ ҮХЦ-ийн 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

³⁵ ҮХЦ-ийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон.

авсан байх бөгөөд иргэд, хуулийн этгээдээс олгох зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна” гэснийг баримтлан өмчлөгчийн эрхийг хязгаарлах асуудал гарсаар байжээ.

Дүн шинжилгээ хийсэн тохиолдлуудад орон сууц, автомашины зогсоол зэргийг барилгын гүйцэтгэгч компанид урьдчилан захиалж бариулсан байгаа нь нэхэмжлэгч нарын хувьд өмчлөх эрх анхдагч байдлаар үүссэн гэж үзэх үндэслэлтэй юм. Улсын бүртгэлд ч энэ тохиолдолд захиалж авсан этгээдийг “анхны өмчлөгч” гэж бүртгэдэг.

Харин шүүх өмчлөх эрхийг гэрээ хэлцлээр шилжүүлэн авсан буюу өмчлөх эрх үүсмэл байдлаар үүссэн гэж дүгнэсэн нь дийлэнх байна. Нэгэнт уг барилга дуусаагүй байхдаа барилгын компанийн өмчлөлд бүртгэгдсэн, түүнээс эрх шилжүүлэн авах процесс тул шүүхийн дүгнэлт хууль ёсны бөгөөд үндэслэлтэй болж байна. Хэрэв ингэж үзвэл эрх шилжүүлж байгаа тал болох барилгын компани үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татвар³⁶ төлөх учиртай.

Дээрх тохиолдлуудад нэхэмжлэгч нар өмчлөгч болохыг тогтоосон Иргэний шүүхийн шийдвэр гарсан боловч түүнээс өмнө өөр этгээдэд өмчлөх эрх үүссэн, тэр өмчлөх эрхээ хэрэгжүүлэх хүрээнд үл хөдлөх хөрөнгийг барьцаалсны улмаас иргэний хэргийн шүүхийн шийдвэр хэрэгжихгүй, жинхэнэ өмчлөгчийн хууль ёсны эрх ашиг хохирох байдал үүсэж байна. Доктор Д.Янжинхорлоо “Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх зүйн харилцааны зохицуулалтын зарим асуудлыг шинжлэхүй” бүтээлдээ “Барьцааны зүйл болох эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь өөр этгээдэд шилжих нь төдийлөн ач холбогдолтой биш бөгөөд барьцааны зүйлийг өмчлөх эрх төлбөртэй, төлбөргүй аль ч хэлбэрээр бусдад

³⁶ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль. 2019 он. 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан.

шилжсэн барьцааны эрх хэвээр хадгалагдаж үлддэг”³⁷ болохыг тэмдэглэсэн байдаг.

Өмчлөх эрх нь эрх зүйн тогтолцоонд тал бүрээсээ хамгаалагдсан туйлын эрх юм.³⁸

Ямар ч тохиолдолд жинхэнэ өмчлөгчийн өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэх нь өмчлөгчийн эрх ашигт нийцэх төдийгүй улсын бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцнэ.

Барьцааны зүйлийн өмчлөх эрх шилжих тохиолдолд ОХУ-ын Ипотекийн тухай хууль³⁹-д хэрхэн зохицуулсныг жишээ болгон авч үзье.

Холбооны хууль. 6 дугаар бүлэг

“Бүлэг 6. Ипотекийн гэрээгээр барьцаалагдсан эд хөрөнгийн эрхийг бусад этгээдэд шилжүүлэх, энэхүү эд хөрөнгөөр бусад этгээдийн эрхэнд дарамт учруулах”⁴⁰

38 дугаар зүйл. Барьцаалсан эд хөрөнгийн эрх бусад этгээдэд шилжсэн тохиолдолд ипотекийн зээлийг хадгалах⁴¹

1. Хураагдсан/Шилжүүлэгдсэн болон хууль ёсны өв залгамжлалын замаар, түүний дотор хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсаны үр дүнд Ипотекийн гэрээгээр барьцаалагдсан эд хөрөнгийг олж авсан

³⁷ Д.Янжинхорлоо, “Монгол Улсын Иргэний эрх зүй, Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй”, (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), УБ., 2015, 223 дахь тал.

³⁸ Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн удиртгал I”, Дөрөвдүгээр хэвлэл, УБ., 2021, 98 дахь тал.

³⁹ Федеральный закон от 16.07.1998 N 102-ФЗ “Об ипотеке (залоге недвижимости)” (с изм. и доп., вступ. в силу с 28.10.2021).

⁴⁰ Глава VI. Переход прав на имущество, заложенное по договору об ипотеке, к другим лицам и обременение этого имущества правами других лиц.

⁴¹ Статья 38. Сохранение ипотеки при переходе прав на заложенное имущество к другому лицу.

этгээд барьцаалуулагчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ипотекийн гэрээгээр хүлээсэн бүх үүргийг хариуцаж барьцаалуулагчийн байрыг эзэлнэ;

2. Ипотекийн гэрээгээр барьцаалагдсан эд хөрөнгө нь энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт заасан үндэслэлээр хэд хэдэн этгээдэд өв залгамжлагдсан бол хууль ёсны эзэмшигч бүр анхны барьцаалуулагчийн ипотекийн зээлээр баталгаажсан үүргээ биелүүлээгүйгээс үүссэн ипотекийн харилцаанаас үүсэх үр дагаврыг барьцаалсан хөрөнгийн өөрт нь шилжүүлсэнтэй хувь тэнцүү хариуцна. Ипотекийн зүйл нь хуваагдашгүй, эсвэл бусад үндэслэлээр барьцаалуулагчийн хууль ёсны өвлөгчдийн дундын өмч болсон тохиолдолд хууль ёсны өвлөгчид нэгдмэл барьцаалуулагчид болно;
3. Ипотекийн гэрээний эд хөрөнгийн барьцаа нь бусад этгээдэд энэ хөрөнгийг шилжүүлэх явцад ямар нэгэн ийм бусдад шилжүүлэх дүрэм зөрчсөн эсэхээс үл хамааран хүчинтэй хэвээр байна” гэж зохицуулсан байна.

Мөн ипотекийн зүйлд хамаарах гуравдагч этгээдийн эрхийн талаар мэдэгдэхийг барьцаалуулагчид үүрэг болгосон зохицуулалт байна: Тодруулбал,

- “12 дугаар зүйл. Ипотекийн зүйлд гуравдагч этгээдийн эрхийн талаар барьцаалагчид анхааруулах.⁴² Ипотекийн гэрээ байгуулахдаа барьцаалуулагч нь ипотекийн зүйлд (ипотекийн эрх, бүх насаар ашиглах, түрээслэх, сервитут болон бусад эрх) гэрээг улсын бүртгэлд бүртгэх үед түүнд мэдэгдэж байсан гуравдагч этгээдийн бүх эрхийн талаар бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүй нь барьцаалагч нь ипотекийн зээлээр баталгаажсан үүргээ хугацаанаас нь өмнө гүйцэтгэхийг

⁴² Статья 12. Предупреждение залогодержателя о правах третьих лиц на предмет ипотеки.

шаардах, эсхүл ипотекийн гэрээний нөхцөлийг өөрчлөх эрхийг олгоно.”Мөн хуулийн “Ипотекийг улсын бүртгэл” гэсэн 4 дүгээр бүлгийн⁴³ 20 дугаар зүйлийн 5-д “Ипотекийн зээлийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор бүртгүүлэх, эрхийн улсын бүртгэлд газар, барилга, байгууламж, орон сууцны бус байрыг барьцаалах - ажлын арван таван өдрийн дотор, орон сууцны байрыг барьцаалах - ажлын таван өдрийн дотор”⁴⁴ тус тус бүртгэдэг байна.

- 21 дүгээр зүйлд “Ипотекийн зээлийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах, ипотекийн улсын бүртгэлийг хойшлуулах”⁴⁵ үндэслэлийн нэг нь “ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг шалгах хэрэгцээ” байхаар зохицуулсан байна. Энэ хуулийн 13 дугаар бүлгээр⁴⁶ орон сууцны ипотекийг тусгайлан зохицуулсан байна. “76 дугаар зүйл. Барьж буй орон сууцны барилгуудын ипотекийн зээл Орон сууцны барилга барихад зориулж зээл олгохдоо ипотекийн гэрээнд барьцаалагчийн эзэмшиж буй дуусаагүй барилга байгууламж, барихад бэлтгэсэн материал, тоног

⁴³ Глава IV. Государственная регистрация ипотеки.

⁴⁴ Статья 20. Порядок государственной регистрации ипотеки. “5.Ипотека должна быть зарегистрирована в течение одного месяца со дня поступления необходимых для ее регистрации документов в орган, осуществляющий государственную регистрацию прав, ипотека земельных участков, зданий, сооружений, нежилых помещений - в течение пятнадцати рабочих дней, ипотека жилых помещений - в течение пяти рабочих дней.

⁴⁵ Статья 21. Отказ в государственной регистрации ипотеки и приостановление государственной регистрации ипотеки. 2. Государственная регистрация ипотеки может быть приостановлена не более чем на один месяц при:
(в ред. Федерального закона от 06.12.2011 N 405-ФЗ) непредставлении в орган, осуществляющий государственную регистрацию прав, какого-либо из документов, указанных в пунктах 2 и 3 статьи 20 настоящего Федерального закона;
(в ред. Федерального закона от 30.12.2004 N 216-ФЗ) несоответствии договора об ипотеке, закладной и приложенных к ним документов требованиям, предусмотренным законодательством Российской Федерации; необходимости проверки подлинности представленных документов.

⁴⁶ Глава XIII. Особенности ипотеки жилых домов и квартир.

төхөөрөмжөөр үүргийг баталгаажуулж болно.”⁴⁷

Монгол Улсын ЭХЭУБТХ-ийн 10 дугаар зүйлд барьж дуусаагүй үл хөдлөх хөрөнгийг “дундаа хамтран өмчлөх эрхтэй өмчлөгчдийн дундын өмчлөлд, эсхүл дундаа хэсгээр өмчлөгч нарын тус тусын өмчлөлд” бүртгэх зохицуулалт орсон. Энэ нь дуусаагүй орон сууцны барилгыг гүйцэтгэгч өөрийн өмчлөлд бүртгүүлж, барьцаанд тавих шаардлагагүй болж, орон сууцыг захиалан бариулж байгаа өмчлөгч нар дуусаагүй орон сууцаа бүртгүүлж, ипотект хамрагдан орон сууцны барилгаа санхүүжүүлэх боломжийг бий болгож байна.

Дүн шинжилгээ хийсэн тохиолдлуудад барилгын компани дуусаагүй барилгыг өмчлөлдөө бүртгүүлсэн санаа зорилго юу байсан бэ? гэсэн асуудал гарч ирнэ. Тэд өөрсдөө өмчлөх эрхгүй гэдгээ анхнаасаа мэдэж байсан гэж үзэх үндэслэлтэй. Учир нь бүртгүүлэхээс өмнө иргэдтэй гэрээ байгуулж, төлбөрийг авсан тохиолдол олон байдаг.

Хэдийгээр улсын бүртгэлд бүртгэлтэй барьцааны эрх хууль ёсны бөгөөд барьцаалагчийн эрх улсын бүртгэлээр хамгаалагдаж байгаа ч энэ нь дуусаагүй барилгаар бүртгэгдсэн барилгын (ялангуяа орон сууцны зориулалттай) тухайд туйлын болгоомжтой хандах шаардлагатай асуудал юм.

Энэ чиглэлд судалгаа хийж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, онол, арга зүйг илүү тодорхой болгох хэрэгцээ байна.

Улсын бүртгэгч өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэх, эсвэл бүртгэхээс татгалзах нь захиргааны шийдвэр гаргах

⁴⁷ При предоставлении кредита или целевого займа для сооружения жилого дома договором об ипотеке может быть предусмотрено обеспечение обязательства незавершенным строительством и принадлежащими залогодателю материалами и оборудованием, которые заготовлены для строительства. По завершении строительства жилого дома ипотека на него не прекращается.
(в ред. Федеральных законов от 24.12.2002 N 179-ФЗ, от 30.12.2004 N 216-ФЗ)

ажиллагаа болохын хувьд улсын бүртгэлийн хууль тогтоомжид нийцсэн байхаас гадна захиргааны үйл ажиллагааны үндсэн болон тусгай зарчимд нийцсэн байх шаардлагатай.

Захиргааны үйл ажиллагааны зарчмыг ерөнхий шинжээр нь дараах байдлаар ангилж үзэж болно. Үүнд:

1. Захиргааны байгууллагаас үйл ажиллагаа явуулахдаа баримтлах зарчмууд:
 - Захиргааны шийдвэрийн хэлбэр, үйл ажиллагаа тодорхой байх;
 - Захиргааны шийдвэр үндэслэлтэй байх;
 - Захиргаа төвийг сахих;
 - Захиргаа ил тод, нээлттэй байх;
 - Захиргааны үйл ажиллагаа шаардлагатай тохиолдолд л хийгдэх;
 - Зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон байх;
 - Захиргааны үйл ажиллагаа тасралтгүй байх;
 - Захиргааны үйл ажиллагаа үр ашигтай-эдийн засгийн хэмнэлттэй байх гэх мэт.
2. Захиргааны шийдвэрээр эрх нь хөндөгдөх иргэд, захиргааны үйл ажиллагаанд оролцогчдын эрхийг аль болох хангахад чиглэсэн зарчмууд:
 - Эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийг сонсох;
 - Зөвлөгөө өгөх болон мэдээллээр хангах;
 - Иргэдийн итгэлийг хамгаалах;
 - Эрх зүйн байдлыг нь дордуулахгүй байх;
 - Бусдын эрх, эрх чөлөөг хууль бусаар зөрчихгүй байх;
 - Оролцогчоос бичиг баримттай танилцах эрх;
 - Захиргаанаас гомдлыг хугацаанд нь журмын дагуу хянан шийдвэрлэх үүрэг ”⁴⁸ зэрэг болно.

⁴⁸ Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. ХБНГУ-ын ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН, “ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” академи. УБ., 2017, 43 дахь тал.

Доктор А.Эрдэнэцогт “Захиргааны хэргийн шүүхийн практикт нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн нийтлэг зарчмуудыг удирдлага болгох замаар хуулийн хийдэл, салаа утга, тодорхойгүй байдлыг даван туулах боломж бий”⁴⁹ гэж үзсэн.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаа юуны өмнө хуульд үндэслэх зарчимд нийцсэн байх учиртай. Энэ нь улсын бүртгэгчийн аливаа шийдвэр зөвхөн хуулийн дагуу байна гэсэн үг юм. Доктор Г.Банзрагч “Эрх зүйт төрийг захиргааны эрх зүйн үүднээс захиргааны шийдвэр болгон нь хуулийн үндэслэлтэй буюу хүний эрхэд үндэслэлгүйгээр халдсан байх ёсгүй бөгөөд түүнд нь хяналт тавьдаг бие даасан захиргааны шүүхтэй байхыг хэлнэ”⁵⁰ гэжээ. Захиргааны үйл ажиллагаа зорилгодоо нийцсэн, шийдвэр нь үндэслэл бүхий байх зарчимтай. Энэ зарчмын агуулга нь захиргаанаас гаргасан шийдвэр хууль ёсны байхтай шууд хамаатай. Тухайн шийдвэр гаргаж буй бодит нөхцөл байдалд, асуудлын агуулгыг хамаарсан шийдвэр гаргахдаа захиргаа өөрийн үзэмжээр, дур зоргоороо асуудлыг шийдэх бус, хуулийн эрх хэмжээний сонголтын хүрээнд зөв сонголт хийж шийдвэр гаргасан эсэх нь захиргааны шийдвэрийн үндэслэлээр тодорхой болох юм.⁵⁰

Түүнчлэн УБЕХ-д улсын бүртгэлийн үйл ажиллагаанд долоон зарчмыг баримтлахаар заасан. Улсын бүртгэл “үнэн зөв, бодитой ... байх” зарчим нь улсын бүртгэлд бүртгэгдсэн мэдээлэл бүхэн бодит байдалтай нийцсэн байхаар илэрхийлэгдэнэ. Энэ зарчмыг бүрэн хангаж байж л улсын бүртгэлийн байгууллага нь “...улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах”⁵¹ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, өмчийн албан ёсны систем буюу үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэл нь хөрөнгийн эрх зүйн байдлыг үнэн зөв тодорхойлох,

⁴⁹ А.Эрдэнэцогт, “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”, УБ., 2014, 31 дэх тал.

⁵⁰ Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. ХБНГУ-ын ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН, “ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” академи. УБ., 2017. 55 дахь тал.

⁵¹ Улсыг бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт.

өмчлөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, арилжааны аюулгүй байдлыг хангах нийгмийн өмнө хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх билээ. Өөрөөр хэлбэл, өмчлөгч биш этгээд бүртгүүлж, барьцаанд тавьснаас болоод жинхэнэ өмчлөгч (шүүхээр өмчлөх эрх нь тогтоогдсон байсан ч) нь өмчлөх эрхээ бүртгүүлж чадахгүй байгаа нь улсын бүртгэл үнэн зөв, бодитой байх зарчимтай нийцэхгүй юм.

Улсын бүртгэлийг “нотлох баримтад үндэслэж, хуульд заасан журмын дагуу хөтлөх” зарчимтай. Энэ зарчим нь юуны өмнө бүртгүүлж буй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх нь тодорхой баримтаар, эргэлзээгүй нотлогдсон, бүртгэлд тусгах мэдээллүүд нь хуульд заасан арга хэлбэрээр тодорхойлогдсон, бүртгэл хийх ажиллагаа нь хууль, журамд заасны дагуу явагдсан байхыг ойлгоно.

Захиргааны үйл ажиллагааны “хуульд үндэслэх зарчим”, улсын бүртгэлийн үйл ажиллагааны “улсын бүртгэлийг хуульд заасан журмын дагуу хөтлөх” зарчмыг хангахад хууль, журам тодорхой, ойлгомжтой, уялдаа холбоотой, салаа утгагүй, хэрэглэхэд хялбар байх нь чухал юм. Жишээлбэл, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх тохиолдолд өмнөх өмчлөгчид олгосон гэрчилгээг шаардах эсэх, үл хөдлөх хөрөнгө барьцаалагдсан тохиолдолд өмчлөх эрхийг шилжүүлэх (болон бусад) асуудлуудыг үл хөдлөх эд хөрөнгийн хууль, журмаар тодорхой зохицуулж чадаж байгаа юу гэдгийг анхаарах хэрэгтэй.

Түүнчлэн “Захиргааны байгууллага эрх зүйн хэм хэмжээг эрэмбийн хувьд хамгийн доороос нь эхлэн хэрэглэдэг. Захиргааны байгууллага тухайн тохиолдолд зөвхөн доод эрэмбийн эрх зүйн хэм хэмжээ нь хийдэлтэй байгаа тохиолдолд түүний дээр эрэмбэлэгдсэн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэдэг. Хүчин чадлаар нь эрэмбэлсэн байдал нь доод эрэмбэ бүхий эрх зүйн хэм хэмжээ дээд эрэмбэ бүхий эрх зүйн хэм хэмжээтэй

зөрчилдөж байвал тэр хүчингүй гэсэн санааг илэрхийлж байдаг. Хэрэв эрх зүйн хэм хэмжээнүүд харилцааны хувьд адилхан эрэмбэлэлд байгаа тохиолдолд сүүлд батлагдсан эрх зүйн хэм хэмжээ нь хуучин эрх зүйн хэм хэмжээний дээр байдаг.”⁵²

Доктор Ж.Долгорсүрэн “Эрх мэдэл хаана хэрэгжиж байна, тэнд захирагдал дагалдах бөгөөд тэдгээр нь салгашгүй нэг зүйлийн хоёр тал юм”⁵³ гэж тодорхойлсон. Захиргааны байгууллагын эрх мэдлийн онцлог, давуу байдлаас хамааран захиргааны шийдвэр хууль бус, үндэслэлгүй байсан ч нөлөөлөх чадвар хүчтэй байдаг гэж хэлж болно. Жишээлбэл, улсын бүртгэгч хэд хэдэн удаа үндэслэлгүй шаардлага тавьж (хуульд заагаагүй бичиг баримт шаардах зэрэг) бүртгэхээс татгалзсан байхад тэр нь хууль ёсны шаардлага мэт болж тогтдог аюултай. Д.Ганхүрэл нарын судлаачдын багийн 2021 онд хийсэн “Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг бүртгүүлэхтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг хэрэглэж буй шүүхийн практик, үр дагавар, харьцуулсан судалгаа”-ны тайланд “...Яагаад ийм практик тогтсон талаар тодруулбал, үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн газар түрээсийн гэрээ болгоныг бүртгэх боломжгүй учраас зөвхөн тэр эд хөрөнгийг бүхэлд нь түрээслэх гэрээний хувьд л бүртгэл хөтөлнө гэсэн шаардлага тавьдгаас улбаатай байна”⁵⁴ гэж дурдсан байдаг. Судалгааны явцад барьцаалагдсан үл хөдлөх хөрөнгийг барьцаанаас чөлөөлөөгүй тохиолдолд өмчлөх эрхийг шилжүүлэх боломжгүй, барьцаа бүртгүүлэх, дуусгавар болгох, түрээсийн гэрээ бүртгүүлэх, шүүхийн шийдвэрийн үндсэн дээр болон албадан дуудлага худалдаагаар өмчлөгч өөрчлөгдөх зэрэг бүртгэл хийлгэх тохиолдлуудад “гэрчилгээ авчрах ёстой” (улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиар хавсаргах хууль, журмын зохицуулалт байхгүй) гэсэн нийтлэг ойлголт байна.

⁵² П.Одгэрэл, “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”, УБ., 2004, 53 дахь тал.

⁵³ Ж.Долгорсүрэн, “Монгол Улсын Захиргааны эрх зүй”, УБ., 2008, 40 дэх тал.

⁵⁴ Шүүхийн шийдвэрийн судалгаа. Цуврал 1. 151 дэх тал

Үүнтэй холбоотойгоор Доктор Г.Банзрагч “Эрх зүйт төрийн нэг гол зарчим нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Энэ нь захиргааны эрх зүйн давуу байдлаа ашиглаж иргэдийн болон нийтийн ашиг сонирхлыг хохироохоос сэргийлэхэд оршдог”⁵⁵ гэснийг эш татаж байна. Энэ нь улсын бүртгэлийн эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход ч хамааралтай юм.

Судалгааны явцад “Иргэний шүүхээр өмчлөгч болохыг тогтоосон, эсвэл өмчлөгч болох нь хангалттай нотлогдож байгаа, захиргааны хэргийн шүүхээс улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан нь буруу” гэж үзэн бүртгэхийг даалгасан шийдвэрт улсын бүртгэлийн байгууллага давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдлууд нэлээд байгаа нь анхаарал татсан. Гомдол гаргаж байгаа үндэслэлийн дийлэнх нь “барьцаатай, эрхийг түдгэлзүүлсэн нөхцөл байдлыг шүүх буруу үнэлсэн” гэх агуулгатай. Хэдийгээр хэргийн оролцогчийн хувьд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхтэй ч энэ тохиолдолд захиргаа төвийг сахих зарчимд хэр нийцэж байгааг анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Ингэснээр шаардлагатай тохиолдолд давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргахыг үгүйсгээгүй гэдгийг онцолъё.

⁵⁵ Г.Банзрагч “Эдийн засгийн захиргааны эрх зүй нь захиргааны эрх зүйн тусгай ангийн бүрэлдэхүүн хэсэг болох нь”, УБ., 2014. <https://legaldata.mn/b/255>

НЭГДСЭН ДҮГНЭЛТ, САНАЛ

Өмчлөх эрхийн бүртгэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэж байгаа Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг судалж шинжлээд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой маргааныг шийдвэрлэж байгаа шүүхүүд маргаан бүр онцлогтой ч гэсэн яг ижил нөхцөлийг өөр өөрөөр дүгнэж, ижил төсөөтэй хэргийг шийдсэн өмнөх шийдвэрээс эсрэг шийдвэр гаргах тохиолдол байна.
- Нэг үйл баримтыг өөр өөрөөр үнэлж байна. Жишээлбэл, Хан-Уул дүүргийн ... хотхоны доорх автомашины 205 зогсоол бүхэлдээ 2007 оны 8 дугаар сарын 1-ий өдрөөс барьцаалагдаж, барьцааны эрх үүссэн гэж зарим нь дүгнэсэн байхад, зарим нь 2007 оны 10 дугаар сарын 5-ны өдрөөс, зарим нь 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрөөс үүссэн гэх мэт хэд хэдэн өөр байдлаар дүгнэсэн. 205 автомашины зогсоол нь бүхэлдээ барьцаалагдаж, барьцааны гэрээг сунгах, нэмэлт оруулах зэрэг үйл баримт болж байсан атал шүүх хугацааг хэрхэн тогтоосон нь шийдвэрт нөлөөлсөн.
- Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт нэхэмжлэлийн

шаардлага тус бүрийн талаар дүгнэлт өгөх үүрэгтэй⁵⁶ гэсэн шаардлага хангалттай хэрэгждэггүй гэсэн дүгнэлтэд хүрлээ. Тухайлбал, “өмнөх бүртгэлийг хүчингүй болгож, өөрийн өмчлөлд бүртгэхийг даалгах” агуулгатай нэхэмжлэлийн шаардлагын өмнөх бүртгэлийг хүчингүй болгох шаардлагад дүгнэлт өгөөгүй тохиолдол цөөнгүй байна. Дуусаагүй барилгаар 55 хувийн гүйцэтгэлтэй гэж бүртгүүлээд, 90 хувийн гүйцэтгэлтэй гэж бүртгэлд өөрчлөлт оруулсан тохиолдолд нэхэмжлэгч “өмнөх бүртгэлийг хүчингүй болгож, өөрийн өмчлөлд бүртгэхийг даалгах” агуулгатай нэхэмжлэл гаргасан тохиолдлууд байна. Тухайн үед мөрдөгдөж байсан “Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийг хөтлөх журам”⁵⁷-ын 4 дүгээр зүйлийн 4.10-д “...Дуусаагүй барилгын өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд анхны удаа бүртгүүлснээс хойш тухайн барилгыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулах хүртэл гүйцэтгэлийн явцаар эд хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн гэсэн үндэслэлээр эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглоно”, 4.11-д “...Дуусаагүй барилгыг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр бүрэн дуусгаж, ашиглалтад оруулсан тохиолдолд дуусаагүй барилгын өмчлөх эрхийн хувийн хэрэг, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрчилгээг сольж олгоно гэж тус тус зохицуулж өгсөн байсан. Энэ журам хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байсан хэдий ч дуусаагүй барилгын гүйцэтгэлийн хувийг нэмж бүртгэсэн улсын бүртгэлийг хүчингүйд тооцуулах нэхэмжлэлдээ үндэслэл болгосон тохиолдлууд байсан.

- Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн эрх зүйн

⁵⁶ “Шүүхийн шийдвэрийн тухай” УДШ-ийн тогтоолын 3.3. 2006, Дугаар 21.

⁵⁷ Улсын ерөнхий бүртгэгчийн 2004 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 50 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан

зохицуулалт зарим талаар тодорхойгүй, хангалттай биш байгаа нь улсын бүртгэгчийн шийдвэр гаргах ажиллагаанд бэрхшээл учруулж байна. Жишээлбэл, ЭХЭУБТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт нь “Гэрчилгээг улсын бүртгэлд бүртгэлтэй байгаа өмчлөгчид нь дахин нөхөн олгох агуулгатай” зохицуулалтууд байхад 5.5.5-д “Шүүх арбитрын шийдвэрээр өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэхэд улсын бүртгэлийн гэрчилгээг хураан авах боломжгүй болсон” тохиолдлыг оруулж, 5.7-д “5.5.5-д заасан тохиолдолд мэдүүлэг гаргагчийн өргөдөл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан бичгийг үндэслэн...” гэсэн нь зүйл заалтын дунд агуулгын зөрчил үүсгэсэн. Өөрөөр хэлбэл, 5.5.5 дахь заалтаар шүүх арбитрын шийдвэрээр өмчлөх эрх нь шилжиж байгаа талын гэрчилгээг дахин олгох гээд байна уу, шилжүүлэн авч байгаа талд гэрчилгээ шинээр олгох гээд байна уу гэдэг ойлгомжгүй байна. Мөн “Эд хөрөнгийн улсын бүртгэл хөтлөх журам”⁵⁸-ын зохицуулалт бүртгэлийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж чадаагүй, ЭХЭУБТХ болон бусад хуулийн зохицуулалтыг эш татсан, давтсан зүйл ихтэй.

Дүн шинжилгээний ажлын үр дүнд хийсэн дүгнэлтийн үндсэн дээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох;
- Нийтийн зориулалттай орон сууцны дуусаагүй барилгыг бүхэлд нь нэг этгээдийн өмчлөлд болон дангаар өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой эрх зүйн тусгайлсан зохицуулалт шаардлагатай;
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн

⁵⁸ Засгийн газрын 2018 оны 397 дугаар тогтоолоор батлагдсан.

10 дугаар зүйлийн 10.10-д “Барьж дуусаагүй үл хөдлөх эд хөрөнгийг хоёр болон түүнээс олон этгээд хөрөнгө оруулан, эсхүл захиалгаар барьж байгаа бол хөрөнгө оруулагч, захиалагч нарын мэдүүлгээр уг үл хөдлөх эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх эрхтэй өмчлөгчдийн дундын өмчлөлд, эсхүл дундаа хэсгээр өмчлөгч нарын тус тусын өмчлөлд энэ хуулийн 10.6-д заасан нотлох баримтыг үндэслэн эрхийн улсын бүртгэлд бүртгэнэ” гэсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх, үүнтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журамд оруулах;

- Орон сууц захиалагч нар үл хөдлөх хөрөнгөө улсын бүртгэлд бүртгүүлэх, урьдчилсан тэмдэглэл хийлгэхтэй холбоотой харилцааг хуульд оновчтой зохицуулж, хэрэгжүүлэх;
- Шүүхийн шийдвэр хууль ёсны, үндэслэл бүхий байх шаардлагыг хангах, шүүхийн шийдвэрийн бичвэр үг үсэг, найруулгын алдаагүй, ойлгомжтой, цэгцтэй байхад анхаарах шаардлагатай байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Эрх зүйн баримт бичиг

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019
2. Захиргааны ерөнхий хууль, 2015
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016
4. Иргэний хууль, 1994, 2002
5. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
6. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2009, 2018
7. Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоол.
8. ҮХЦ-ийн 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01 дүгээр тогтоол
9. Шүүхийн шийдвэрийн тухай, УДШ-ийн тогтоол. Дугаар 21, 2006
10. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Засгийн газрын 2018 оны 397 дугаар тогтоолын хавсралт.
11. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох журам, 2018 оны 394 дүгээр тогтоолын хавсралт.
12. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018
13. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийг хөтлөх журам, Улсын ерөнхий бүртгэгчийн 2004 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 50 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан. (хүчингүй болсон)
14. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, 2003

Б. Ном бүтээл

1. А.Эрдэнэцогт, “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй”, 2014
2. Б.Буянхишиг, “Иргэний эрх зүйн удиртгал I”, Дөрөвдүгээр хэвлэл, УБ., 2021
3. Г.Агар-Эрдэнэ, “Хувийн өмчийн онол”, УБ., 2009
4. Г.Банзрагч, “Эдийн засгийн захиргааны эрх зүй нь захиргааны эрх зүйн тусгай ангийн бүрэлдэхүүн хэсэг болох нь” нийтлэл, 2014
5. Г.Банзрагч, “Эрх зүйт төр буюу Захиргааны шүүх” илтгэл, 2014
6. Д.Янжинхорлоо. “Монгол Улсын Иргэний эрх зүй, Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүй”, (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 2015
7. Ж.Долгорсүрэн, “Монгол Улсын Захиргааны эрх зүй”, УБ., 2008
8. Ж.Оюунтунгалаг, “Иргэний эрх зүй I”, Ерөнхий анги, УБ., 2020, 153 дахь тал.
9. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. ХБНГУ-ын ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН, “ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” академи. 2017
10. ННФ. “Шүүхийн шийдвэрийн судалгаа”, Цуврал 1. УБ., 2021
11. П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”, УБ., 2004
12. Эрнандо дэ Сото, “Капиталын нууц”, УБ., 2004

В. Гадаад хэлээрх

1. Федеральный закон от 16.07.1998 N 102-ФЗ “Об ипотеке (залоге недвижимости)” с изм. и доп., вступ. в силу с 28.10.2021.

Г. Цахим хуудас

1. <https://burtgel.gov.mn>
2. <https://legaldata.mn>
3. <https://www.legalinfo.mn>

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M, MBA)

Өмгөөллийн DB>S ХХН-ийн гишүүн хуульч



Өмгөөллийн DB>S ХХН-ийн Гүйцэтгэх захирал тэрээр Монголын санхүү, банк, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтний нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. Хуулийн зөвлөх үйлчилгээний хувийн салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа. Түүнээс өмнө Монголын томоохон арилжааны банканд хуульчаар ажиллахын зэрэгцээ МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Билиг” дээд сургуульд хичээл зааж байсан түршлагатай. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавр, АНУ-ын Оклахомагийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр, АНУ-ын Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн. Chambers & Partners, Legal500, IFLR зэрэг олон улсын хуульчдын зэрэглэл тогтоодог байгууллагаас Д.Золжаргал, түүний удирдаж ирсэн хуулийн фирмийг олон жилийн түрш өндрөөр үнэлсэн байдаг.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.)



МУИС-ийн Хууль зүйн сургуульд төрийн захиргаа, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, Үндсэн хуулийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл түүрвил, улирал тутмын “Эрх зүй” сэтгүүлийг эрхлэн гаргах ажил хариуцан ажиллаж байв. 2021 оноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг дүүргэж, БНСУ-ын Күүкминий Их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)



Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын Тамгын газар, олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх зэргээр мэргэжлээрээ 23 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оны 11 дүгээр сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр, магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.)



Криминологи, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын чиглэлээр мэргэшин судалдаг ба практик болон судалгааны байгууллагад 20 жил ажилласан туршлагатай. Цагдаагийн академийг эрх зүйч, Хүмүүнлэгийн ухааны Их сургуулийг англи хэл-менежерийн бакалавр зэрэгтэй төгсөж, 2007 онд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хугацаа” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. Түүнчлэн академик болон бодлогын судалгааны чиглэлээр дангаар, бусадтай хамтран 40 орчим судалгааны ажил, 20 гаруй сурах бичиг, гарын авлага боловсруулж нийтийн хүртээл болгосон. Хуульч, хууль сахиулагчийг чадавхжуулах хүрээнд 10 орчим жил сургагч багшаар ажиллаж байна.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)



Тэрээр хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

МУИС-ийн Хууль зүйн сургуульд суралцаж “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон Улсын Кьюсюгийн Их сургуульд суралцаж “Монгол Улс дахь нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан. Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

ISBN 978-9919-9990-1-8



9 789919 999018